


БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ-2022



**БАГШ СУРГАЛТ ЗААХ АРГА ЗҮЙД
НЭВТРҮҮЛСЭН ИННОВАЦИ**

СЭДЭВ: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОЮУТНЫ СУРАЛЦАХ ХАНДЛАГАД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН СУДАЛГАА



Хураангуй: Өнөөдөр суралцагчийн суралцах хандлага, төлөвшлийн асуудлыг чухлаар авч үзэж байгаа энэ үед оюутан суралцагчийн хандлага нь сурах үйлд хэрхэн нөлөөлж байгааг судлах нь бас чухал асуудал болж байна. Бид нөгөө талаас нь суралцах үйлд хэрхэн хандаж буйг судлах, суралцах үйлд хандах хандлагад нь нөлөөлж буй сургалтын орчноос хамаарсан хүчин зүйлийг судлах хэрэгцээ байна гэж үзсэн. Манай улсын мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын чанарыг сайжруулах гол хүчин зүйлийн нэг болох оюутны суралцах хандлагыг тодорхойлох, оюутны хандлага, суралцах идэвхи, бүтээмжийн чадвар, мэдлэгийн түвшин зэрэг арга аргачлалуудыг харьцуулан судалж үнэлэлт дүгнэлтөгөх нь энэхүү ажлын гол зорилго болно. Иймээс бид суралцах хандлагад нөлөөлөх зарим хүчин зүйлсийн нөлөөллийг судлах нь зүйтэй гэж үзэж эл судалгааны ажлыг хийсэн болно.

ОРШИЛ

Оюутны суралцах хандлагын онол, арга зүйн харьцуулсан судалгаа. Хандлага хэмээх нэр томъёоны хувьд олон улсад түгээмэл хэрэглэгдэж буй тодорхойлолтоос авч үзвэл, хандлага төлөвшлийг (attitude) “Хувь хүн, эд юмс болон үйл явдалд үзүүлж буй тодорхой үнэлгээ, дүгнэлт бүхий хариу үйлдлийн тогтсон загвар төлөв юм” гэж тодорхойлсон байдаг. Мөн аливаа асуудалд аль өнцгөөс хэрхэн хандах үйлийн баримжааг хандлага (approach) гэж үзэх тохиолдол ч байна.

Монгол хэлний тайлбар толинд хандлагыг “Ямар нэгэн үзэгдэл, бодол, үзэл санааны ерөнхий чиглэл: зөв хандлага (зөвөөр хандах байдал)-ыг хэлнэ” гэжээ.

Сургалтын чанарыг хэдэн хувиар хэрхэн өөрчлөгдөн сайжирч байгаа зэргийг хянахын тулд оюутны суралцах үйл явцад нөлөөлж буй хүчин зүйлсийг ямар түвшинд байгааг тодорхойлох нь зүйтэй юм. Иймд оюутны суралцах үйлд хандах хандлагыг үнэлэх арга, арга зүйн талаар судлах асуудал урган гарч ирж байгаа тул энэ төрлийн судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хийх нь чухал байна.

Оюутны сургалтын үнэлгээ, сургалтын чанарын асуудал, сургалтын орчны талаар судлаачдын бүтээлүүдэд дурдагдсан байдлыг тоймлон авч үзье. Үүнд: МУИС-ийн эрдэмтэн, профессор Т.Ганбаатар, Ц.Далайжамц, У.Доед нар суралцагчдын мэдлэг, чадвар хандлага, төлөвшлийг үнэлэх нь тэдний сурахуйд тусалж, дэмжих, сургалтын арга хэрэгслээ сонгох, үйл ажиллагаандаа хийх өөрийн үнэлгээг сайжруулах, сурахуйн үр дүнг тодорхойлох, оюуны хөдөлмөрийн соёл, сахилга суулгах зэрэг ач холбогдолтой хэмээн үзсэн байна [39]. Тиймээс суралцахуйн үр дүн үнэлгээ, сурлагын амжилтад дүн шинжилгээ хийж үзэх нь чухал байна.


Сургалтын чанарыг дээшлүүлэх асуудал чухлаар тавигдаж байгаа орчин үед сурлагын амжилтын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх арга зүйд дараах асуудлууд чухал байр суурь эзэлж байна. Үүнд:

- Оюутны үнэлгээг боловсронгуй болгох буюу ялангуяа оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа нь боловсрол судлалын салбарт тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байгаа юм.
 - Боловсролын стандарт, хөтөлбөрийг нийгэм, хувь хүний хөгжлийн боловсролын хэрэгцээ, шаардлага болон 12 жилийн сургалтын тогтолцооны шилжилттэй уялдуулан боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүсээд байна.
 - 2011 оноос: 40 лаборатори сургууль дээр “Шинэчилсэн хөтөлбөр”-ийн туршилт явагдаж байгаагийн хамгийн чухал нь суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх асуудал юм.
- Сургалтын технологийн шинэчлэл боловсронгуй болохын хэрээр сургалтыг үнэлэх асуудлаар туршилт судалгааг хийж, Юуг, Хэзээ, Яаж үнэлж байгааг нарийвчлах, зорилго, агуулга арга зүй, үр дүнтэй танилцаж, судлах шаардлага улам нэмэгдсээр байна. Иймээс манай улсын хувьд олон улсын чиг хандлагад нийцсэн хөгжлийн бодлогыг баримталж үнэлгээнийхээ тогтолцоог боловсронгуй болгох шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна (Булган, Ж. 2013).

Сурах үйлийн талаар манай орны эрдэмтэн, судлаачид судалгааны ажил хийж үр дүнг нь үйлдвэрлэл практикт нэвтрүүлжээ. Тухайлбал: Оюутны сурах сонирхол, идэвхийг өрнүүлэх арга зүй боловсруулан туршсан судалгаа, (Хишигсүрэн, Л. 2013), Дээд сургуулийн оюутны суралцах чадварын төлөвшлийг судалсан нь, (Лхагвасүрэн, Ч. 2012), Сургалтын идэвхтэй арга барилаар оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь, (Эрдэнэчимэг, С. 2010), Оюутны логик сэтгэхүйн хөгжилд сургалтыг идэвхжүүлэх арга замын нөлөөллийн судалгаа, (Энхтуяа, О. 2005) гэх мэт олон бүтээлийг дурьдаж болно. Харин сурах үйлийг оюутан холбон авч үзсэн судалгаа шинжилгээний ажил төдий л олон биш байна (Бэгз, Н. 2011). Оюутны суралцах үйлийг тодорхойлох нь сургалтын үйл ажиллагааны үнэ цэнийг ойлгож, мэдлэг эзэмших үйл ажиллагааг оюутанд төлөвшүүлэх асуудал юм. Суралцагч бие хүн нь байгаль орчны бодит юмс үзэгдлийг зөв ажиглан таньж мэдэх, мэдээллийг зөв хүлээн авч боловсруулах, мэдлэг болгон хувиргаж хадгалах, сэргээн санаж хэрэглэх, шинэ санаануудаар баяжуулах зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэх нь тэдний биеийн болон оюуны хөгжилтэй салшгүй холбоотой байдаг.

Сургалтын үйл ажиллагааны бүтцийг сурч танин мэдэх сонирхол, тэрхүү үйл ажиллагааны нийгмийн ач холбогдол, үнэ цэнийг ойлгож авах чиг хандлага, сургалтын явцад зайлшгүй сурч эзэмшихтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх боломж, асуудлаа томъёолж бэлэн байгаа шаардлагатай мэдлэг, чадварын багтаамж болон сурах, суралцах үйл ажиллагааны үндсэн нэгж болох үйлдлийн бүтцийг тодорхойлж, хэрэгжүүлэх зэрэг зорилтготой. Тухайн судлах шаардлагатай хийсвэр ухагдахууныг янз бүрийн арга барилуудын хослолоор тодорхой болгож авч үзэх нь оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааны чухал үндэслэл болж өгнө. Сургалтын үйл ажиллагааны бүтэц нь сурч танин мэдэх сэдэл, сургалтын зорилт, сургалтын зорилтыг шийдвэрлэх сургалтын үйл явц зэргээс бүрдэнэ.

ОЮУТНЫ СУРАЛЦАХ ҮЙЛ ХАНДАХ ХАНДЛАГЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА



Өнөө үед боловсролын нийгмийн үр ашгийг нэмэгдүүлэх асуудал зайлшгүй тавигдаж байна. Бидний өмнөх туршлага, дэлхийн олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлагаас үзэхэд дэлхийн нийгмийн хөгжлийн шинэ урсгал нь иргэдийг олон зүйлд шинэлэг байр сууринаас хандаж, шинэ орчинд чадварлагаар дасан зохицож байнга тасралтгүй суралцах шаардлагыг бий болгож байна. Гадаад орнуудад гарсан дээрх хандлагууд нь манай их, дээд сургуульд суралцагчдын сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх үйл ажиллагаанд тэр бүр нэвтэрч чадахгүй байгаа нь суралцагчдын дүн бодитой биш байхад

нөлөөлдөг гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, оюутан суралцагчдын хөгжилд гарч байгаа өөрчлөлт, боловсролын системд хийгдэж буй өөрчлөлт, багшийн хөгжилд гарч буй өөрчлөлтийг одоогийн үнэлгээний системд зохих ёсоор тусгах хэрэгтэй.

Сургалтын агуулга, арга зүйд гарч байгаа өөрчлөлтүүд нь суралцагчдын цогц чадамжийг үнэлж, дүгнэх, оюутан суралцагчдын ахиц дэвшлийг тооцох хэрэгцээг бий болгож байна. Зах зээлийн нөхцөлд ажиллаж амьдрах мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд оюутны суралцах үйлд хандах хандлагын талаар шинэ шаардлага тавигдах боллоо.

Судалгааны арга зүй: Найдвартай байдлын шинжилгээ, фактор шинжилгээ, корреляцийн шинжилгээ, регрессийн шинжилгээ. ANOVA тест, тодорхойлогч статистикийн шинжилгээг хийлээ.

Нийгмийн тэр эрэлт хэрэгцээг хэрхэн хангаж байгаа, түүнийг хэрхэн хөгжүүлж, хэрэгжүүлж болох талаар судалгаа туршилтыг дараах үе шаттай явуулав.

1. Оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг хийх. Сургалтын үйл ажиллагаанд оролцож байгаа оюутнуудаас түүвэр судалгаа авах, оюутны суралцах хандлагад тавигдаж байгаа шаардлагыг судлах, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын оюутны суралцах хандлагыг тодорхойлох нь суралцах арга барилаа олох, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох гэх мэт сайн талтай. Үүнд:

KMO and Bartlett's Test		
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.		.901
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	4929.478
	df	1275
	Sig.	.000


Статистик үр дүнгийн шинжилгээ.

Судалгааны боловсруулалтын үр дүн, хүчин зүйлсүүдийн хамаарлын шинжилгээг хийхийн өмнө асуулгын, өгөгдлийн найдвартай байдал, статистик тестүүдийг хийнэ. Ингэхдээ статистик тестийн үр дүнгүүд нь найдвартай гэж гарсан бол үр дүнгийн шинжилгээний нь үнэн зөв гэдэгт итгэлтэй байж болно.


Хүснэгт 1. Kaiser Meyer-Olkin (KMO) болон Bartlett-ийн шинжилгээ

Түүврийн найдвартай байдал

Судалгааны түүврийн хангалттай байдлыг Kaiser Meyer-Olkin (KMO) болон Bartlett-ийн шинжилгээгээр тодорхойлоо.




		Нас			
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	14	1	.4	.4	.4
	15	52	21.5	21.5	21.9
	16	89	36.8	36.8	58.7
	17	54	22.3	22.3	81.0
	18	33	13.6	13.6	94.6
	19	8	3.3	3.3	97.9
	21	1	.4	.4	98.3
	23	1	.4	.4	98.8
	25	1	.4	.4	99.2
	27	1	.4	.4	99.6
	28	1	.4	.4	100.0
Total		242	100.0	100.0	



Хүйсийн ангилал судалгаанд оролцсон хүмүүсийн 171 хувь нь эмэгтэй байсан ба үлдсэн 71 эрэгтэй оролцогч түүврийн 29.3 эзэлнэ.

Ерөнхий хандлагын шинжилгээ


Код	Асуулт
q1	Та ямар нэгэн хичээлийг судлахдаа өмнөө зорилго, зорилт тавьдаг уу?
q2	Та сурах явцдаа тавьсан зорилго зорилт үйл ажиллагааны явц үр дүнгээ хянадаг уу?
q3	Та сурах явцдаа ямар нэгэн асуудлын талаар танин мэдэх, гүнзгийрүүлэн судлах, үнэ цэнийг нь ойлгоё гэсэн сэдэл төрдөг үү?
q4	Та сурах явц бүртээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулан жиших гэх мэт үйлдлүүдийг хийдэг үү
q5	Та оюутан байх хугацаандаа үр дүнтэй суралцаж байгаа юу?
q6	Та тоо, математикт дуртай юу?
q7	Та урлагийн бүтээлд дуртай юу?
q8	Та шинэ мэдлэг эзэмшихдээ түүнийгээ цогцоор нь судлах эдгээр мэдлэгээ хэрэглэж үзэх гэсэн хүсэл төрдөг үү?
q9	Та сурах явцдаа мэдээллийг хүлээн авч боловсруулж үр дүнг нь тооцдог уу?



Оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа. Судалгааны бүрэлдэхүүн элемент тус бүрийн хувьд дундаж онооны статистик, асуулт тус бүрийн хариултын давтамжийн шинжилгээг хийсэн болно.



Судалгааны энэ хэсэгт тодорхойлох статистикийн болон давтамжийн шинжилгээнүүдийг хийсэн болно. Тодорхойлох статистик нь түүврийн бүтэц болон судалгаанд оролцогчдын үндсэн шинж чанарын талаарх мэдээллээр хангадаг. Тэдгээр мэдээллүүд нь дундаж, давтамж болон хувь зэргээр илэрхийлэгдэнэ. Дундаж утга нь тодорхой зүйл, шинж чанарын ерөнхий, нийтийн дүр төрхийг илэрхийлдэг. Дундаж өндөр байх нь тухайн зүйл оролцогчийн хувьд хэр нийцтэй вэ? гэдгийг харуулна. Түүнчлэн судалгааны үр дүнг илүү нарийн гаргахын тулд нийт цуглуулсан өгөгдлөө ерөнхий шинж чанараар хэсэгчлэн шинжилгээ хийсэн. Дундаж онооны хувьд 2 асуулт хангалтгүй үнэлгээтэй, харин бусад 7 асуулт дундаж болон түүнээс дээш үнэлгээтэй гарсан.



1. Та цагийг оновчтой төлөвлөж чаддаг уу?

Та цагийг оновчтой төлөвлөж чаддаг уу?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Үгүй	9	3.7	3.7	3.7
	Заримдаа	181	74.8	74.8	78.5
	Тийм	52	21.5	21.5	100.0
	Total	242	100.0	100.0	

Цагийг оновчтой төлөвлөж чаддаг эсэх дээр ихэнх нь заримдаа сайн төлөвлөж чаддаг гэж үзсэн бол 1/5 нь үргэлж гэж хариулсан байна.

2. Та нийгмийн амьдралд хир идэвхитэй вэ?

Та нийгмийн амьдралд хир идэвхитэй вэ?					
		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Идэвхгүй	12	5.0	5.0	5.0
	Идэвхи сул	82	33.9	33.9	38.8
	Дунд	4	1.7	1.7	40.5
	Идэвхтэй	144	59.5	59.5	100.0
	Total	242	100.0	100.0	

Нийгмийн амьдралын идэвхийн тулдихэнх нь идэвхтэй байсан бөгөөд 33.9 хувь нь идэвхи султай гэж гарсан.

3. Та өөрийгөө зохион байгуулалт сайтай гэж боддог уу?

Та өөрийгөө зохион байгуулалт сайтай гэж боддог уу?



		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Үгүй	27	11.2	11.2	11.2
	Заримдаа	133	55.0	55.0	66.1
	Тийм	82	33.9	33.9	100.0
	Total	242	100.0	100.0	

Хувийн зохион байгуулалтын хувьд 55 хувь нь заримдаа сайн гэж хариулсан бол 34 хувь нь үргэлж сайн төлөвлөж чаддаг гэж хариулсан байна. Оюутнуудын суралцах хандлагын үзүүлэлтүүдийн шинжилгээг хийлээ. Үүнийг хүснэгтээр илэрхийлье.

Код	Асуулт
attitude1	Суралцах ханлагын үзүүлэлт [Нийгмийн]
attitude2	Суралцах ханлагын үзүүлэлт [Сурах үйлтэй холбоотой асуудлаа]
attitude3	Суралцах ханлагын үзүүлэлт [Өөрийн]
attitude4	Суралцах ханлагын үзүүлэлт [Бүтээлч]
attitude5	Суралцах ханлагын үзүүлэлт [Мэргэжлийн]
attitude6	Суралцах ханлагын үзүүлэлт [Сонирхолгүй]
attitude7	Суралцах ханлагын үзүүлэлт [Харилцааны]
attitude8	Суралцах ханлагын үзүүлэлт [Нэр хүндийн]

Энэ шинжилгээгээр оюутнуудын суралцах хандлагын хувьд нийт 8 асуулт байсан. Эдгээрээс хамгийн сайн үнэлгээтэй нь мэргэжлийн, өөрийн болон бүтээлч хандлагын хувьд үнэлгээ сайтай гарсан бол хамгийн үнэлгээ багатай нь сонирхолгүй гэсэн хариулт байв. Мөн нэр хүндийн хандлагыг талаас илүү хувь нь чухалчилж үзээгүй байна.

Хариултуудын задаргааг харуулъя.





Нийт 8 асуулт байснаас 2 нь хангалтгүй үнэлгээтэй, 6 нь хангалттай үнэлгээтэй гарсан байв. Мэргэжлээ сонгоход нөлөөлсөн хүчин зүйлсийн шинжилгээг хийлээ. Үүнийг хүснэгтээр илэрхийлье.

Код	Асуулт
choice1	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Ажлын байраар хангахад]
choice2	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Мэргэжлээр өсөх бололцоотой]
choice3	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Сар бүр олгодог 200 мянган төгрөгийг авахын тулд]
choice4	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулахын тулд]
choice5	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Манай сургууль илүү нэр хүндтэй учраас]
choice6	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Мэргэжилтэй ажилчин болж мэргэжлийн боловсрол эзэмшихийн тулд]
choice7	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Мэргэжлээ өөрөө сонгоогүй ч сургалтын арга барил, технологи нь надад таалагдсан]

choice8	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Миний зарим онцлогт тохирсон]
choice9	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Би сурах хугацаандаа цэргийн алба хаана]
choice10	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Надад ямар ч өөр сонголт байгаагүй ч би сонголтоо зөв хийсэн]
choice11	Мэргэжлээ сонгох хүчин зүйл [Мэргэжлийн хичээлийн дадлага, сургууль миний сонирхлыг маш их татсан]

Мэргэжлээ сонгоход нөлөөлсөн хүчин зүйлүүдийн хувьд дараах шалтгаанаар мэргэжлээ сонгосон, мэргэжлийн хичээлийн дадлага, сургууль миний сонирхлыг маш их татсан, мэргэжилтэй ажилчин болж мэргэжлийн боловсрол эзэмшихийн тулд, мэргэжлээр өсөх бололцоотой, миний зарим онцлогт тохирсон, эх орныхоо хөгжилд хувь нэмэр оруулахын тулд. Харин санал нийлээгүй асуултуудад сар бүр олгодог 200 мянган төгрөгийг авахын тулд, манай сургууль илүү нэр хүндтэй учраас, би сурах хугацаандаа цэргийн алба хаана г.м. хариултууд орно.


Хариултуудын задаргаанаас нийт 11 асуултаас 5 нь өндөр үнэлгээтэй, 3 нь бага үнэлгээтэй, үлдсэн 3 нь дундаж үнэлгээтэй гарав. Үүнийг Дундаж онооны үнэлгээгээр гаргасныг графикаар харуулав.




Зорилго, төлөвлөлтийн чухалчилдаг зүйлсийн шинжилгээг хийлээ. Үүнийг хүснэгтээр илэрхийлье.

Код	Асуулт
plan1	Зорилго, төлөвлөгөөнд чухалчилдаг зүйл [Эрүүл мэндийн асуудлаа]
plan2	Зорилго, төлөвлөгөөнд чухалчилдаг зүйл [Боловсролын асуудлаа]
plan3	Зорилго, төлөвлөгөөнд чухалчилдаг зүйл [Гэр бүл нийгмийн асуудлаа]
plan4	Зорилго, төлөвлөгөөнд чухалчилдаг зүйл [Сурах үйлтэй холбоотой асуудлаа]
plan5	Зорилго, төлөвлөгөөнд чухалчилдаг зүйл [Бүгд]

Зорилго төлөвлөлтөнд чухалчилдаг зүйлүүдэд сурах үйлтэй холбоотой асуудлууд, боловсролын асуудлууд өндөр үнэлгээтэй гарсан. Бүгд гэж хариулсан оюутан харьцангуй цөөн байсан ч түүврийн дийлэнхийг эзэлнэ. Хариултын задаргаа бадундаж онооны үнэлгээнээс харахад 2 асуулт өндөр үнэлгээтэй, 3 асуулт дундаж үнэлгээтэй гарав.




Оюутнуудын ур чадварын үнэлгээг хийлээ. Үүнийг хүснэгтээр илэрхийлье



Код	Асуулт
skill1	Чадварын үнэлгээ [Оновчтой төлөвлөх чадвар]
skill2	Чадварын үнэлгээ [Ашиглах материалаа эрж хайх]
skill3	Чадварын үнэлгээ [Сурах нөхцлийг бүрдүүлэх чадвар]
skill4	Чадварын үнэлгээ [Ажиглалт явуулах чадвар]
skill5	Чадварын үнэлгээ [Өөрийн үйл ажиллагааг хянах чадвар]
skill6	Чадварын үнэлгээ [Мэдээллийг хүртэж авах чадвар]
skill7	Чадварын үнэлгээ [Мэдээллийг оновчтой тогтоох чадвар]
skill8	Чадварын үнэлгээ [Танин мэдэх асуудал шийдвэрлэх]
skill9	Чадварын үнэлгээ [Дасгал бие даан гүйцэтгэх чадвар]



Оюутнуудын чадварын үнэлгээг 9 асуултаар үнэлсэн ба үүнд ихэнх нь өөрсдийгөө дунд эсвэл сайн гэж үнэлсэн байна. Муу эсвэл онц гэж хариулсан оюутнууд харьцангуй цөөн байв. Дундаж онооны үнэлгээнээс харахад дундаж оноонууд ихэнхдээ 2-3 хооронд хэлбэлзэж байна. Оюутнууд өөрсдийн чадварыг доогуур үнэлсэн нь түүврийн хувьд нийтлэг ажиглагдсан зүйл юм.



Оюутнуудын цаг зарцуулалтын шинжилгээг хийлээ. Үүнийг хүснэгтээр илэрхийлье.


Код	Асуулт
time1	Цаг зарцуулалт [Сурах үйлд]
time2	Цаг зарцуулалт [Сонирхол өөрийн хобби]
time3	Цаг зарцуулалт [Амралт зугаалга цэнгүүн]
time4	Цаг зарцуулалт [Олон нийтийн ажил]
time5	Та өдөр бүр хийх ажлын жагсаалт гаргадаг уу?

Цаг зарцуулалтын тухай оюутнуудаас асуухад ихэнх нь өөрийн хобби болон сонирхолд цагаа зарцуулах дуртай байдаг бол сургалтанд 2/3 нь хугацаагаа зарцуулах сонирхолтой байдаг байна. Амралт зугаалга болон цэнгүүнд 2/3 нь зарцуулах дургүй гэж хариулсан бол олон нийтийн ажилд түүврийн санал бодол тэнцүү хуваагдаж байсан. Өдөр тутмын ажлын жагсаалтыг с нь тогтмол гаргадаггүй гэж хариулсан. Дундаж онооны үнэлгээгээр 1 асуулт өндөр үнэлгээтэй, 1 нь дундаж болон үлдэх 3 нь хангалтгүй үнэлгээтэй гарав.




Оюутнуудын мэргэжлийн сэтгэл ханамжийн үнэлгээг гаргав. Үүнийг хүснэгтээр илэрхийлье.

Код	Асуулт
satisfaction1	Оюутны мэргэжлийн сэтгэл ханамж буюу үнэлгээ ямар байдаг вэ?
satisfaction2	Та өөрийн сурч буй мэргэжлээ сонгосондоо сэтгэл хангалуун байна уу?



Оюутнуудын сэтгэл ханамжийг харахад оюутны мэргэжлийн сэтгэл ханамж харьцангуй бага гарсан боловч өөрийн мэргэжлээ сонгосондоо баяртай байгаа эсэхэд ихэнх нь сэтгэл хангалуун гэж хариулсан байна.



Хувьсагч хамаарлын шинжилгээ ба Корреляцийн шинжилгээ. Судалгааг хийх явцад тоон мэдээллийг нэгтгэн дүгнэх статистик арга аргачлалын нэг нь корреляцийн шинжилгээ байдаг.

Корреляцийн шинжилгээ нь тэдгээр үзүүлэлтүүдийн хоорондоо ямар хүчээр нөлөөлж буйг тооцоолоход ашиглагддаг арга аргачлал юм. Нэг хувьсагчийн утга бүрд нөгөө хувьсагчийн тодорхой утга харгалзаж байвал энэ нь функцийн хамаарал болно. Нэг хувьсагчийн тодорхой утгад нөгөө хувьсагчийн тодорхой тархалт харгалзаж байвал тэдгээрийг статистик хамааралтай хувьсагчид гэнэ.

Нэг хувьсагчийн дундаж утгаас нөгөө хувьсагчийн утга хамаарах функцийн хамаарлыг корреляци /коварианс/ хамаарал гэх ба энэ хамаарал нь статистик хамаарлын нэг хэлбэр нь болно.

Хувьсагчид статистик хамааралтай үед тэдгээрийн хоорондын нөлөөлөл, хувирч өөрлөгдөх зүй тогтлыг корреляцийн ба регрессийн шинжилгээний аргаар тодорхойлно. Нэг хувьсагчийн Х өсөх утгад нөгөө хувьсагчийн буурах утга харгалзаж байвал урвуу хамаарал гэнэ. Эерэг корреляци үед хувьсагчийн утга өсөхөд нөгөө хувьсагч дунджаараа хамт өснө. Сөрөг корреляцийн үед хамт буурна.

Корреляци хамаарлын төрлүүдийг тайлбарлавал:

Эерэг корреляци: Нэг хувьсагчийн утга нэмэгдэхэд нөгөө хувьсагчийн утга дагаад нэмэгддэг.

Сөрөг корреляци: Нэг хувьсагчийн утга нэмэгдэхэд нөгөө хувьсагчийн утга буурдаг

Шугаман корреляци: Нэг хувьсагчийн утга өөрчлөгдөхөд нөгөө хувьсагчийн утга дагаад өөрчлөгддөг. Өөрөөр хэлбэл, хувьсагчууд хоорондоо тодорхой харьцаатайгаар харилцан бие биедээ нөлөөлдөг.

Шугаман бус корреляци: Хувьсагчдын хоорондын тодорхой харьцаа байхгүй.

Судалгааны үр дүнгийн математикийн боловсруулалт ба загвар.

Пирсоны корреляцийн матриц. Корреляцийн шинжилгээнээс дүгнэхэд оюутнуудын суралцах хандлага нь зорилго төлөвлөлттэй, сэтгэл ханамжтай болон цаг зарцуулалттай ач холбогдол бүхий корреляци хамааралтай байна. Харин оюутнуудын ур чадвараас хамааралтай корреляци хамаарал илрээгүй болно. Суралцах хандлагад нөлөөлж байгаа хүчин зүйлийн чанарын шинж тэмдгүүдийн хоорондын хамаарлын хүчийг хэмжих шинжилгээг Пирсоны коэффициентоор шалган үр дүнг тооцлоо.

Пирсоны коэффициент гнь 0-оос 1-ийн хооронд байх бөгөөд 0-д ойрхон бол хамаарал сул байх бөгөөд 1-д ойрхон байх тусам хамаарал хүчтэй байна[16]. Пирсоны коэффициентыг дараах илэрхийллээр тодорхойлно.

1. Хэрэв: 1. Сул $0 < r < 0,1$;
2. Дунд зэрэг $0,1 < r < 0,2$;
3. Мэдэгдэхүйц $0,2 < r < 0,5$;
4. Хүчтэй $-0,5 < r < 0,7$;
5. Маш хүчтэй $0,7 < r < 1$ хүртэлх байна.

Оюутны суралцах хандлагад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг дараах үзүүлэлтээр хийснээс суралцах хандлагад нөлөөлж байгаа нөлөөллийг харуулав. Мөн нарийвчилсан шинжилгээг регрессийн шинжилгээний үр дүнгээс харна уу.

		Correlations				
		ATTITUDE	PLAN	SATISFACTION	SKILL	TIME
ATTITUDE	Pearson Correlation	1	.274**	.273**	.008	.249**
	Sig. (2-tailed)		.000	.000	.897	.000
	N	242	242	242	242	242
PLAN	Pearson Correlation	.274**	1	.207**	.111	.384**
	Sig. (2-tailed)	.000		.001	.084	.000
	N	242	242	242	242	242
SATISFACTION	Pearson Correlation	.273**	.207**	1	.083	.156*
	Sig. (2-tailed)	.000	.001		.200	.015
	N	242	242	242	242	242
SKILL	Pearson Correlation	.008	.111	.083	1	.225**
	Sig. (2-tailed)	.897	.084	.200		.000
	N	242	242	242	242	242
TIME	Pearson Correlation	.249**	.384**	.156*	.225**	1
	Sig. (2-tailed)	.000	.000	.015	.000	
	N	242	242	242	242	242

Регрессийн үнэлгээ. Хоёр болон түүнээс дээш хувьсагчдын хамаарлыг шалгах үүднээс дараах статистик тестийг ашигласан. интервал утгатай Хүл хамаарах хувьсагч болон интервал утгагүй Y хамааран хувьсагчдын хамаарлын шинжилгээ. Уг шинжилгээг ашиглах зорилго нь интервал утгатай хувьсагчийн вариаци нь хэрхэн интервал утгагүй хувьсагчдад нөлөөлж байгааг шалгахад оршино. Регрессийн шинжилгээнд ашигласан математик загвар:

$$Y = a + b_1 * x_1 + b_2 * x_2 + \dots + b_k * x_k + E$$

		Coefficients ^a				
Model		Unstandardized Coefficients		Standardized Coefficients	t	Sig.
		B	Std. Error	Beta		
1	(Constant)	1.029	.121		8.507	.000
	PLAN	.142	.054	.174	2.641	.009
	SATISFACTION	.064	.018	.217	3.520	.001
	SKILL	-.028	.026	-.066	-1.065	.288
	TIME	.151	.061	.163	2.453	.015

Үүнд: Y — хамааран хувьсагчийн таамагласан утга

a — бүх X хувьсагч 0 байх үеийн Y утга


x — үл хамааран хувьсагч

b — үл хамааран хувьсагчийн коэффициент

e — статистик алдаа

Регрессийн шинжилгээний үр дүнгээс харахад оюутнуудын суралцах хандлагад хамгийн ач холбогдол хүчин зүйлд цаг зарцуулалт болон зорилго төлөвлөлтийн хүчин зүйлүүд орж байна. Оюутны сэтгэл ханамж ач холбогдол бүхий нөлөөтэй ч гэсэн коэффициент нь сул байна. Оюутны ур чадвар нь ач холбогдол бүхий нөлөө үзүүлж чадахгүй байна.

Регрессийн шинжилгээний нэгтгэл



Судалгааны дүгнэлт. Судалгааны найдвартай байдлын шинжилгээний үр дүнг дүгнэхэд асуулгын Кронбах альфа коэффициент 0.819 гарсан тул судалгааны үр дүнг хангалттай сайн түвшинд байна гэж үзэж болно. КМО үр дүн нь 0.901 байгаа нь түүврийн хэмжээ хангалттай буюу төлөөлөх чадвартай байгааг илэрхийлж байна. Бүх хувьсагчдын фактор коэффициентийн утгууд нь 0.5-с их байгаа тул цаашдын шинжилгээнд бүх хувьсагчдыг оруулах боломжтой гэсэн үр дүнг дээрх шинжилгээгээр илрүүлэв.

Анкетын inter-item correlation коэффициент 0.3-с дээш байх ёстой байдаг ба дээрх үр дүнгээр 0.460 гарсан нь судалгааны анкетмөн ялгаагүй найдвартай гэдэг нь нотлогдоно. Иймд судалгаанд орсон бүх асуултуудаар шинжилгээ хийх боломжтой гэж дүгнэж үр дүнгийн шинжилгээг хийсэн болно.

Судалгаанд оролцсон хүмүүс ихэвчлэн 15-18 насны хүмүүс байсан ба түүврийн дийлэнх нь буюу 71 хувь нь эмэгтэй оролцогчид байсан. Судалгаанд нийт 244 хүн оролцсоноос шинжилгээнд ашиглах боломжтой түүврийн тоо 242 байсан ба үлдэх 2 анкетыг шаардлага хангаагүйн улмаас шинжилгээнээс хассан болно.

Корреляцийн шинжилгээнээс дүгнэхэд оюутнуудын суралцах хандлага нь зорилго төлөвлөлттэй, сэтгэл ханамжтай болон цаг зарцуулалттай ач холбогдол бүхий корреляци хамааралтай байна. Харин оюутнуудын ур чадвараас хамааралтай корреляци хамаарал илрээгүй болно.

Регрессийн шинжилгээний үр дүнгээр оюутнуудын суралцах хандлага оюутны ур чадвар, мэдлэг нь ач холбогдол бүхий нөлөө үзүүлж чадахгүй байна. Харин зорилго төлөвлөлт болон цаг зарцуулалт нь хамгийн өндөр нөлөөтэй байсан бол мэргэжлийн сэтгэл ханамж нь дундаж нөлөөтэй байсныг илрүүлэв.

ANOVA тестээр бүлэг хоорондын ялгаа байгаа эсэхийг шалгах зорилгоор нийт 7 бүлгийн хувьд тестийг ажиллуулсан: оюутны ур чадвар, зорилго төлөвлөлт, цаг зарцуулалт, сэтгэл ханамж,

оролцогчийн хүйс болон оролцогчийн насаар тооцлоо. Уг тестийн үр дүнгээр оюутнуудын суралцах хандлага нь дараах бүлгүүдийн хувьд ялгаатай гарсан ба зорилго зорилт төлөвлөлт, цаг зарцуулалт, мэргэжлийн сэтгэл ханамж талаас эдгээр хувьсагчдын үнэлгээ их байсан нь дэд түүврүүдэд суралцах хандлага илүү ажиглагдсан. Харин ялгаатай ур чадвартай, ялгаатай нас болон хүйстэй дэд түүврүүдэд суралцах хандлага төстэй байдлаар илэрч байв.

Ашигласан ном зүй:

Монгол хэл дээр бичигдсэн зохиол бүтээл



1. Авдай, Ч., Энхтуяа, Д. (2000). Судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэх арга зүй, Статистик боловсруулалт, загварчлал, оновчлол. Улаанбаатар. 352х.
2. Бэгз, Н. (2008). Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд.
3. Бэгз, Н. (2011). Монголын боловсрол судлалын шинэ парадигм.

4. Бадарч, Д. (2017). Боловсролын тухай дахин эргэцүүлэн бодох нь. Улаанбаатар. 16х, 38-39х.
5. Бадарч, Д. (2013). Дээд боловсролын шинэчлэлийн инноваци. Өгүүлэл. Улаанбаатар.
6. Балтзерсен, Ж. (2007) Хүүхэд хэрхэн суралцдаг тухай. Мэдээлэл. Улаанбаатар. 104-111х.
7. Батхуяг, С. (2012). Амжилттай суралцах арга зам, Содпресс ХХК.
8. Батхуяг, С. (2003). Дээд сургуулийн сурган хүмүүжүүлэх зүй.
9. Валерика, Анжелеш. (2013). Суралцагчдын хандлагад нөлөөлөх хүчин зүйлийг судлах нь диссертаци, Румын улс
10. Гэрэлт-Од, Я. (2010). Оюутны суралцах орчны үнэлгээ, Магистрын ажлын бүтээл. Улаанбаатар.
11. Гэрэлтуяа, Т. (2017). Оюутны суралцах хандлагад хийсэн дүн шинжилгээ (МУБИС-ийн СӨБСС-ийн 1, 2-р курсийн оюутнуудын жишээн дээр) МУИС, Боловсрол судлал сэтгүүл. Улаанбаатар. №17(469). 169-171х.
12. Лахавасүрэн, Ч. (2012). Дээд сургуулийн оюутны суралцах чадварын төлөвшилийг судалсан нь, диссертаци. Улаанбаатар.
13. Оюунцэцэг, Л. (2001). Сургалтын орчны хүчин зүйлийн судалгаа. Улаанбаатар.
14. Уртнасан, Г., Мөнхтунгалаг, Е., Сүнжидмаа, Т. (2013). Оюутны сурах үйлийн хүрээнд сурах орчин, нөхцөл байдалд дүн шинжилгээ өгөх нь, Их, дээд сургуулиудын онол практикийн бага хурал. Улаанбаатар.
15. Уртнасан, Г., Тамир, Х. (2018). Их, дээд сургуулийн оюутны суралцах хандлагыг үнэлэх сургалтын орчны нөлөөллийн судалгаа, ШУТИС, ЕНИ, Олон улсын онлайн хурал. Улаанбаатар.

Орос хэл дээр бичигдсэн зохиол бүтээлүүд

16. Миронов Б.Н., Степанов З.В., Историк и Математика (математические методы в историческом исследовании), Москва. (2014).

Англи хэл дээр бичигдсэн зохиол бүтээл

18.ADEA. (2003). Case study on distance education for teacher education in Mauritius. ADEA Biennial Meeting,Mauritius.

19.MUST, E-Open institute, International online conference, Ulaanbaatar, Mongolia.(2018, 57-62, 68-73, 74-77).

20. James Brian Quinn., *Intelligent Enterprise*, (1992).

21.Somboon Chetchumlong.,(2010). The effect of web-based formative assessmenton students' achievement and attitudes in a large enrolmenttertiary English course.

22.ValericaAnghelache., Determinant Factors of Students' Attitudes Toward learning,<https://doi.org/10.1016/j.sbspro.2013.09> 223, pages 478-482

23.Магнус Лиги, Кармен Трасберг, Причины недобросовестности в учебе и представления студентов о правилах поведения, Тартуского университета, (2017).

Вэб хүүдас

24. www.agepedagog.ru/ Понятие <отношение> к обучению в педагогической науке. (2018).

25. <https://psyera.ru/3436/psihologicheskie-faktory-opredelyayushchie-uspeshnost-uchebnoy-deyatelnosti>

Ишков А.Д., Учебная деятельность студента,(2012).

26.http://bataabaatar.blogspot.com/2015/03/blog-post_19.html /Learning theories/.

Диссертациуд

27.Жизненные стратегии как фактор отношения студентов в учебной деятельности тема диссертации и автореферата по ВАК 19.00.07, кандидат психологических наук Воронина, Ольга Александровна.(2008).

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a single page of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and extend across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЁДОЛЧИН
МЭРГЭЖЛИЙН ХУВЦАСНЫ АЖЛЫН ЗУРАГ ЗУРАХ
АРГА ЗҮЙ БОЛОВСРУУЛАХ

ОЁДЛЫН БАГШ: Х.МӨНХЦЭЦЭГ



СЭДЭВ: ОЁМОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ОЁДОЛЧИН МЭРГЭЖЛИЙН ХУВЦАСНЫ АЖЛЫН ЗУРАГ ЗУРАХ АРГА ЗҮЙ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

Хураангуй



Судалгаа ньҮУПК-н Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн Ажлын зураг чадамжийн нэгж хичээлийн агуулга ,цагийн багтаамж, ном гарын авлага байдаг эсэх, олон улсын сэтгүүлүүдэд хэвлэгдсэн ажлын зургийн харьцааг судлах, судалгааны үр дүн гэсэн хэсгүүдээс бүрдсэн ба мэдээлэл цуглуулах, асуулгын, туршилт, ажиглалт харьцуулалтын аргуудыг ашигласан.Үүний үр дүнд хялбар ойлгомжтой зурах арга барилыг судалгааны үндэслэлд тулгуурлан гаргаж ирэн түүнийг 3-н хэмжээ ашиглан зурах аргаар бүтээлээ зурж туршиж үзсэн. Гарсан үр дүнд цаг ашиглалт бага ,хялбар болон ижил хэмжээгээр бусад хэлбэр хийцийг

илэрхийлэх боломж байгааг судалгааны үр дүн харуулсан.

Удиртгал

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн сургалтын чадамжид суурилсан сургалтын Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн хөтөлбөрт

1. Сургалтын хөтөлбөрийг ажил олгогчтой хамтран боловсруулж, үйлдвэрийн салбар баталдаг.
2. Багш үйлдвэр аж ахуйн нэгжтэй хамтран сургалтын материалаа сонгоно.
3. Сургууль дээрх сургалтыг бусад мэргэжил, чадамж эзэмшүүлэхтэй хослуулах.
4. Чадамжийг эзэмшсэн тохиолдолд төгссөн гэж тооцно гэх асуудлуудыг авч үзэж боловсруулсан байдаг.

Сургалтын хөтөлбөрийг ажил олгогчтой хамтран боловсруулсны үр дүнд чадамжийн нэгж бүрд өөр өөрийн чадамжийн элементүүдийг бүрэн эзэмшсэн тохиолдолд чадамжтай гэж дүгнэн үзнэ.Үүнээс үзэхэд Ажлын зураг зурах чадамжийн нэгж нь бүтээгдэхүүний зурсан зургийг унших бүрдэл хэсгүүдийг таних ,ялгах ,нэрлэх үйлдвэрлэлээс тавьсан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар судалгааг оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр суралцаж буй оюутнуудын жишээн дээр судаллаа. Тэдний мэргэжлийн Ажлын зураг зурах чадамжийн нэгжийн цаг ,ажлын зураг зурах арга зүй дээр чанарыг сайжруулах асуудлыг мэргэжлийн ур чадварын 4 үндсэн чадамжийн элементийн зурах арга зүйг судалж тогтоох, чадварыг нь цогц чадамж, ур чадвар болгон хөгжүүлэх асуудлыг судалгааны ажлынхаа зорилго болгон ажиллаж байна. Монгол улс оёдлын мэргэжлээр мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх ажил нь өнөөг хүртэл тасралтгүй хөгжиж, улам бүр боловсронгуй болж байна.

Сэдэв сонгосон үндэслэл:

Сүүлийн арав гаруй жил МБС-т ЧСС-ыг зохион байгуулах болсноор мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрт ч мөн адил өөрчлөлт ихээр орсон байна.

Тэгвэл ААН-ийн үзэж байгаагаар оёдолчин хүн захиалагчийн хүсэл, сонирхолыг тусгасан загварыг хурдан хугацаанд пропорцитай буулгах ур чадвар эзэмших нь чухал гэж тодорхойлсон, хөтөлбөрт тусгагдсан цагт багтаан / хөтөлбөрт 54 цагаар тогтоосон байдаг / хялбар аргаар хурдан хугацаанд зурж сурах аргад суралцуулах шаардлага байгааг тодорхойллоо. Үүний нэг жишээ нь ажил олгогчдоос тухайн мэргэжилтэй ажилтны зайлшгүй эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлуулж тэр чиглэлд үр дүнтэй сургалтын хөтөлбөр боловсруулах болжээ.

Түүнчлэн МБС-т ажиллах хугацаанд ажлын зураг зурах ЧН-ийн хичээлийг зохион байгуулсан ба оёдлын мэргэжлээр суралцахаар орж ирэхэд тэднээс зурах ур чадварын шалгалт авах шаардлага байхгүй гэж үздэг учир үндсэн суурь авъяасгүй, зурах чадвараа хөгжүүлээгүй сурагчид 90-100%-ийг эзэлж байгаа нь харагдсан.

Эндээс дээрхи нөхцөл байдалд ур чадварыг богино хугацаанд хэрхэн олгох вэ гэсэн асуудал гарч ирсэн юм.

Гэтэл үйлдвэрлэлийн явцад ямар ч зургийн авъяасгүй нэгэнд ийм шаардлага гарах бөгөөд оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжил сонгон суралцах хүсэлтэй байвал загварыг хавтгайд дүрсэлж чаддаг байх хэрэгтэй гэж тогтоосон байдаг. 2017 онд батлагдсан МБС-н ерөнхий шаардлага MNS6541:2015-д зааснаар Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн стандартын II-р түвшингээс эхлэн "Ажлын зураг зурах, ЧН-ийн хүрээнд Бүсэлхийн болон Цээжний хувцасны ажлын зураг зураж, техникийн тодорхойлолт бичиж чаддаг болсон байх ёстой гэж зааж өгсөн байна. Иймд ажлын зураг зурах хичээлийн ур чадвар олгох сургалтыг үр дүнтэй зохион байгуулах хэрэгцээ шаардлага гарч ирж байгаа юм. Цаашлаад эсгүүр, оёх технологийн сонголт хийхэд гол бичиг баримт болдог байна.

Зурах аргачлал хэмжээсийг гаргаж ирснээр богино хугацаанд суурь чадваргүй хэнд ч ажлын зураг зурах ур чадварыг эзэмшүүлж болох учраас энэ сэдвийг сонгосон. Иймээс ажлын зураг зурах ур чадварыг олгох арга зүйг судлах нь зүйтэй гэж үзлээ.

1.1 Судалгааны ажлын зорилго



Монгол улс оёдлын мэргэжлээр мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх ажил нь өнөөг хүртэл тасралтгүй хөгжиж, улам бүр боловсронгуй болж байна. Сүүлийн арав гаруй жил МБС-т ЧСС-ыг зохион байгуулах болсноор мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрт ч мөн адил өөрчлөлт ихээр орсон байна. Үүний нэг жишээ нь ажил олгогчдоос тухайн мэргэжилтэй ажилтны зайлшгүй эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлуулж тэр чиглэлд үр дүнтэй сургалтын хөтөлбөр боловсруулах болжээ. Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр суралцаж байгаа суралцагч нарт заавал эзэмшсэн байх ур чадвар дотор "Ажлын

зураг зурах" ур чадвар багтсан байна. Тэгвэл ААН-ийн үзэж байгаагаар оёдолчин хүн захиалагчийн хүсэл, сонирхлыг тусгасан загварыг хурдан хугацаанд пропорцитай буулгах ур чадвар эзэмших нь чухал гэж тодорхойлсон учраас хялбар аргаар хурдан хугацаанд зурж сурах аргад суралцуулах шаардлага байгааг тодорхойллоо. Цаашлаад сурагчдад зориулсан хялбар аргаар зурах гарын авлага боловсруулах хэрэгцээ байгаад байгаа нь харагдаж байна. Зурах аргачлал хэмжээсийг гаргаж ирснээр богино хугацаанд суурь чадваргүй хэнд ч ажлын зураг зурах ур чадварыг эзэмшүүлж болох учраас энэ сэдвийг сонгосон.

1.2 Судалгааны арга зүй



Ажлын зураг зурах хичээлийн чухал хэсэг бол хувцасны бүтцийг илэрхийлж буй үндсэн дүрс, хэлбэр харьцааг гаргах явдал юм.

Хувцасны онцлог, деталь хэсгүүд, хуваалт, загварын гол санаа түүний харьцааг түүний хэлбэр хийцийг зөв илэрхийлж хавтгайд зурснаар мэргэжилтнүүдэд таны ажлын зургийг харан ойлгоод унших, түүний дагуу

үйлдвэрлэх үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ. Иймээс хялбар ойлгомжтой зурах арга барилыг судалгааны үндэслэлд тулгуурлан гаргаж ирэн түүгээрээ оёдлын чиглэлд ажиллаж байгаа болон энэ оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийг сонгон хичээллэх хүмүүст гарын авлага хийх зорилготой байна.

Хүний биеийн анатоми түүний нарийвчилсан онолын судалгааны үр дүн практикаар нотлогдсон талаарх мэдээл цуглуулах. Үүнд: Хүний дүрсийг зөв дүрслэхийн тулд зурах хүний хувь хэмжээг мэдэх хэрэгтэй. Тиймээс зураг зурахад зайлшгүй шаардлагатай хүний биеийн харьцааны талаарх үндсэн цэгүүдийг 20 зууны турш уран зураач, философич, сурган хүмүүжүүлэгчдийн сонирхлыг татсаар ирсэн нэг зүйл бол хүний биеийн хэсгүүдийн эзлэх хувийн судалгаа юм. [Ромын архитектор Витрувиусийн] онолын талаас нь судлах.

Ажлын зураг зурах хичээлийн цаг, асуулгын судалгааг сурагчид болон тухайн хичээлийн ордог багш нараас асууж үр дүнг тооцон оновчлох.

Ажлын зураг зурах аргуудын хүндрэл, зарцуулах цагаар нь харьцуулан судалж хамгийн хялбар аргаар бага цаг зарцуулан зурах арга зүйг туршин боловсруулахаар төлөвлөх.

1.3 Ач холбогдол

Хувцасны ажлын зураг нь үйлдвэрлэлийн явцад загвар бүтээгдэхүүн эсвэл таны төсөөлөл хэрхэн харагдахыг харуулах боломжийг олгодог. Хувцасны ажлын зураг зурах чадваргүй бол бүтээгдэхүүнийг өөрөө боловсруулах ажлыг эхлүүлэх бөгөөд хэрэглэгчийн төлөөллийг бүтээгдэхүүн болгох боломжгүй болдог. Ажлын зургийн дагуу загварыг нарийвчлан задлан шинжилж, бүрдэл хэсгүүдийн байрлалыг цээж, бэлхүүс, өгзөг гэсэн уламжлалт шугамтай харьцуулан тодорхойлоход тохиромжтой. Энэ бол бүтцийн загварчлалын мэдээллийн анхдагч эх үүсвэр юм. Эзлэхүүн ба дүрсний зөв харьцаа, зураглал нь техникийн зураг төслийг боловсруулахад тавигдах үндсэн шаардлагуудын нэг юм. Ажлын зураг зурах ЧН-н цагийн

оновчлол хийх,хөтөлбөрт тусгагдсан цагт ур чадварыг бүрэн эзэмшүүлэх арга зүйг олж тогтоох нь энэхүү сэдвийн гол ач холбогдол байх болно.

1.МСБ-ийн Чадамжийн хөтөлбөрийн биелэлт дээр аливаа ур чадварыг 85-с дээш хувь биелүүлж байж чадамжтай гэж үнэлэгддэг ба дараагийн ЧН-ийг судлах боломж бүрддэг. Тиймээс хөтөлбөрийн биелэлт сайжирна


2.МСҮТ-д оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр суралцаад төгсөж байгаа төгсөгч хувийн оёдлын бизнес эрхлэхэд захиалагчийн загварыг ярилцан цаасан дээр хурдан бөгөөд хялбар буулгах чадвартай байх

3.Ажил олгогчдод загварын техникийн зургийг унших, загварын техникийн зураг зурдаг оёдолчны эрэлт байгаа. Жишээ: ДАРХАН МИНЖ ХХК, АЛТАН УРЛАН ХХК—ны инженер техникийн ажилчид нь загварын техникийн зургийг уншиж чаддаггүй, захиалагчийн санааг зөв буулгаж чаддаггүй нь тухайн загварыг 1 оёдолчин бүтнээр нь оёж дуусгадаг онцлогтой манай үйлдвэрийн хувьд бэрхшээл болж байгааг хэлж байсан юм.

4.Үүнээс дүгнэж үзэхэд хувиараа оёдлын цех болон салонд ажиллаж байгаа оёдолчинд хүртэл дамжлагад оёх биш бүтээгдэхүүн оёж дуусаж байгаа нь ажлын зураг дээрх мэдээлэл унших чадвар эзэмшихээс гадна ,Загвар дээр өөрчлөлт гаргахад загварын өөрчлөлтийг зурж тэмдэглэх чадвар эзэмшүүлснээр оёдолчинг үнэлэх үнэлэмж нь ихэснэ гэж бодож байна.

СУДЛАГДСАН БАЙДАЛ

1.4 Ажлын зураг зурах арга зүй




20 зууны турш уран зураач, философич, сурган хүмүүжүүлэгчдийн сонирхлыг татсаар ирсэн нэг зүйл бол хүний биеийн хэсгүүдийн эзлэх хувийн судалгаа юм.

[Ромын архитектор Витрувиусийн]


МЭ 1 -р зууны эхэн үед толгой ,нүүр нь бүх биеийн аравны нэг хэсэг юм" гэж бичжээ. Тэрээр мөн хүйс нь биеийн төв хэсэг тул энэ цэгийг тойруулан зурсан тойрог нь нуруун дээрээ хэвтэж буй хүний гар, хөлийн хуруунд хүрнэ гэж маргаж байв. Энэ онолыг доор үзүүлсэн Леонардо да Винчигийн алдартай зургаар дүрсэлсэн болно.

Хүний дүрсийг зөв дүрслэхийн тулд зурах хүний хувь хэмжээг мэдэх хэрэгтэй . Тиймээс зураг зурахад зайлшгүй шаардлагатай хүний биеийн харьцааны талаарх үндсэн цэгүүдийг авч үзэх хэрэгтэй.

Гэсэн хэдий ч, арга барилын аль нь ч нийтлэг биш байсан тул бүх хүмүүс өөр өөр байдаг гэдэг нь үнэн гэдгийг үгүйсгэхгүй, эдгээр хандлага нь зөвхөн сонгодог хүмүүсийн сонирхлыг татдаг. Хамгийн түгээмэл арга бол биеийн өндрийг харьцангуй хэмжихийн тулд толгойны өндрийг хэмжих нэгж болгон ашиглах явдал юм. Дундаж тоо нь долоон толгой боловч зургаагаас найман толгой хүртэл байдаг нь хэвийн гэж тооцогддог. Хамгийн тохиромжтой дүрсийг найман толгой өндөр хэлбэрээр дүрсэлсэн байдаг.Гэхдээ хүний дүрсийг зөв дүрслэхийн тулд зурах хүний хувь хэмжээг мэдэх хэрэгтэй . Тиймээс зураг зурахад зайлшгүй шаардлагатай хүний биеийн харьцааны талаархи үндсэн цэгүүдийг авч үзэх хэрэгтэй.



DIJUJO DE FIGURINES ном 77 хуудас




Бэлхүүсний өргөн нь бүхэл бүтэн толгойтой тэнцүү байдаг бол эрэгтэйчүүдэд энэ нь эмэгтэйчүүдийнхээс доогуур байдаг ба тохой нь хүйсний түвшинд, хуруунууд нь гуяны дунд хүрдэг,хонго нь мөрнөөс нарийссан.

Эмэгтэйчүүдийн их бие нь дугуй хэлбэртэй, харин эрчүүд трапец хэлбэртэй, өнцөг хэлбэртэй,тохойноос хурууны үзүүр хүртэлх гар нь өвдөгнөөс өсгий хүртэлх хөлтэй тэнцүү хүзүү нь цилиндр биш тул доошоо чиглүүлдэг бөгөөд үүнээс мөр рүү шилжих нь трапец хэлбэртэй байх ёстой .

Хүний биеийн булчингийн бүлгүүдийг судлахад геометрийн хэлбэртэй адилхан биш боловч хэлбэрийг тоймтой гаргахад дусалдаг . Хэлбэр хэмжээг хүний биетэй

төстэй харагдуулж зурахын тулд хүний биеийн анатоми судалсан дээр үндэслэн ерөнхий хэлбэрийг гаргаж ирэх шаардлага байгааг харж байна.

Хэмжилтийн хамгийн өргөн хэрэглэгдэх хэмжүүр болох толгойг их биетэй нь харьцуулах юм.Анатоми болон хүний биеийн хэмжил зүйг судалснаар харьцаа улам нарийсаж гаргах боломжтой.



Гар болон хөлнийг дүрслэх арга

Ажлын зураг зурахад мэдээж хүнд өмсөгсөн байдлаар хавтайг дүрслэх нь боловч харах түвшинд хүнд ойлгогдож хувцасны загварын санааг бүрэн уншиж байхаар зурснаар хэлбэр хэмжээг хүний биетэй төстэй харагдуулж зурахын тулд хүний биеийн анатоми судалсан дээр үндэслэн ерөнхий хэлбэрийг гаргаж ирэх шаардлага байгааг харж байна. Хэмжилтийн хамгийн өргөн хэрэглэгдэх хэмжүүр болох толгойг их биетэй нь харьцуулах юм. Анатоми болон хүний биеийн хэмжил зүйг судалснаар харьцаа улам нарийсаж гаргах боломжтой.

1.5 Ажлын зураг, зурах арга

Дизайнерууд хүний дүрс, гар, хөлний байрлал ижил байдаг стандарт загваруудыг өөрчлөхгүйгээр ашигладаг.

Загварын график зураг, дизайнерын ноорог дээр биеийн урт мөн мэдэгдэхүйц богиносч, хөлний уртыг нэмэгдүүлж илүү илэрхийлэх чадвартай болжээ. Зарим тохиолдолд бэлхүүс бага зэрэг нэмэгдэж, аарцаг бага зэрэг буурч байгаа нь дүрсийг илүү өндөр, гоолиг болгодог.

Гэхдээ ажлын зургийг бий болгохын тулд хүний дүрсийн хамгийн тохиромжтой харьцааг ашигладаг. Загварыг яг пропорциор буулгаагүй хавтгай дүрслэл нь ажлын зургийн гол онцлог юм. Дизайнерууд өөрийн үндсэн загварын ажлын зургийг зурж оёдолчинд өгснөөр бүтээл гарах цаг хугацаа Дизайнер оёдолчин хоёрын уялдааг хамтран ажиллах үр дүнг үүнээс харж байна. Өөрөөр хэлбэл ажлын зураг зурахад мэдээж хүнд өмсөгсөн байдлаар хавтайг дүрслэх нь боловч харах түвшинд хүнд ойлгогдож хувцасны загварын санааг бүрэн уншиж байхаар зурснаар гол утга нь оршино.

1.6 МБС, сурагалтанд ажлын зураг зурах ЧН-н хичээлийн агуулга, цагийн багтаамж:



Ажлын зураг зурах ур чадвар зайлшгүй эзэмших шаардлагатай хэмээн 2017 онд батлагдсан Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлийн стандартад тусгасан байх бөгөөд, ажил олгогчид энэ ур чадварыг чухалд үзэж байна. Сүүлийн арав гаруй жил МБС-т ЧСС-ыг зохион байгуулах болсноор мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөрт ч мөн адил өөрчлөлт ихээр орсон ажлын зураг зурах хичээл нь. Оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр суралцаж байгаа суралцагч нарт өмнө нь “Зохиомж” хичээлийн нэг нэг бүлэг сэдэв болж орж байсан бол 2017-оноос “Ажлын зураг зурах” ЧН болон өөрчлөгдөж 3 ЧЭ, 9 ГШҮ -р задран нийт 36 цагийн хичээлийн хөтөлбөрөөр зохион байгуулагдсан байна. Энэхүү хичээл нь:

Бүсэлхийн хувцасны ажлын зураг унших зурах 12цаг,

Цээжний хувцасны ажлын зураг унших зурах 12цаг

Бүрдэл хэсгүүдийг зурах нэрлэх, загварын тодорхойлолт бичих, унших 12цаг элементийн хүрээнд хичээл нь орж байсан

Ажлын зураг зурах хичээлийн зохион байгуулахдаа багш суралцагчидад зурах арга зүйн тайлбар өгөхгүйгээр өөрсдийн нөөц бололцоо хичээл зүтгэлд тулшуурлан зурах, хуулбарлах, давтан зурах арга барилаар зааж байсан байна.



2017 оны

хичээлийн ээлжит хичээлийн төлөвлөгөөг харахад:

1. Хувцас гэж юу болохыг тодорхойлж зурах
2. Хувцасны нэр төрөл ангилал
3. Хувцсанд тавигдах шаардлага
4. Сэтгүүл тараах сэтгүүл дээрх ажлын зургийг масштаблан зурах хэлбэрээр ордог байсан ба бүгд л өөр өөрийн аргачлалаар зурж дүгнэгддэг байсан байна.


1.7 Ажлын зураг зурах арга зүй, ном гарын авлага байдаг эсэх:

ОБО мэргэжлийн сурах бичгүүдэд зурах арга талаасаа тусгагдаагүй хүний биеийн бүтэц зохион байгуулалт хүний биеийн галбир гэсэн хичээлүүд л байдаг ба ажлын зураг зурах арга хичээлүүд нь хичээл зааж буй багшийн хүрээнд гарын авлага хэлбэрээр байх ба нарийн хэмжээс хялбар аргаар хурдан хугацаанд зурах арга одоогоор байхгүй байна. Оёдол эсгүүрийн мэргэжлийн сурах бичиг “Оёдлын технологи” номын 4-р бүлэгт хүний биеийн бүтэц зохион байгуулалт, хүний биед үүсэх согог, хүний биеийн марфологийн үзүүлэлтүүд, хүний биеийн галбир гэх мэтээр ерөнхий харьцааг тодорхойлж өгсөн байдаг бусад оёдлын чиглэлийн ном сурах бичигт хувцасны тодорхойлолт бичих талаар, ажлын зургийг зурах хэлбэрээр оруулж хэлбэр өөрчлөлтийг тайлбарлаж өгсөн байна.

Монгол улсад ажлын зураг зурах хичээл нь багш бүрийн гарын авлага байх ба ҮУПК-ийн багш М.Энхтуяа багшийн 2012 онд гаргаж байсан хувцасны “Зохиомж” багшийн гарын авлага, хувцасны зохиомж суралцагчийн дэвтэр нэртэй гарын авлага гаргаж байсан байна.



Хувцасны зохиомж 2012 он




Бусад оёдлын чиглэлийн ном сурах бичигт хувцасны тодорхойлолт бичих талаар ажлын зургийг зураг хэлбэрээр оруулж хэлбэр өөрчлөлтийг тайлбарлаж өгсөн байна.

Энэ ном нь хувцасны зохиомж хичээлийн ажлын зураг, эскиз гэсэн ЧН-ээр суралцагсдын бие даан гүйцэтгэх ажилбарыг багтаасан байна. Энэ нь энэхүү фигур зурагдаагүй үед яаж ажлын зураг зурах вэ гэсэн асуултыг улам бататгаж байгаа юм.

Хүний биеийн харьцаа

[Хар ба уран зураг сурах бичиг] 2014 он зураг 2.4.2



Хар ба уран зураг / Улаанбаатар 2014 он /

Энэ номноос хүний биеийн харьцаа нь амьдрал дээр ямар байдаг талаас нь судлан гаргаж ирсэн ба ажлын зураг зурахад хялбар мөн зөв харьцаа зөв хуваалтыг илэрхийлж чадах шулуунуудыг дүрсэлсэн байна. Шулуун өргөний харьцааг хувцасны ажлын зураг зурахад ашиглах гол харьцаа болох нь харагдаж байгаа ч дизайн болон оёдлын мэргэжлийн зураг талруу юуг засаж уялдуулах талаас нь бас судлах шаардлага гарсан. Мэргэжил бүхэн уяалдаа холбоотой байх бөгөөд бид бие биеээсээ суралцах боломж үргэлж байдаг.

- Энэ номон дээр
- Эмэгтэй хүний биеийн харьцаа
- Эмэгтэй хүний биеийн харьцааг зурах


Эмэгтэй хүнийг хажуу талаас зурах арга барилыг алхам бүрээр заан түүний харьцаа бодит хэмжээг гаргаж ирсэн байна. Ажлын зураг зурах үндсэн шулуунуудыг гаргахад дөхөм болох ба хавтгай дээр зурах бүхий л хүний харьцааг гаргах түүнийг хялбар аргаар тайлбарлан зааж ажлын зураг зурах боломжтой болсон ба үүнд уран сайхны зураг талаас гаргахын тулд дизайнеруудын ажлын зураг зурах арга аргачлал талаас нь судлах хэрэгцээ мөн л байна.

ОХУ-ын дизайнеры ажлын зураг зурах арга зүй, ном гарын авлага



ОХУ-ын дизайнеруудын холбооны гишүүн Dikilp DSTU-ийн тэнхим Fine Graft компьютерын технологийг ашиглан хувцасны загвар гаргах боловсролын төвийн дарга оёдлын инженер-дизайнер доктор Анна Рукавишникова 2017 онд хавтгай дээр, манекен дээр харагдах байдлаар зурсан зургийг харж болно.

2017 онд хавтгай дээр, манекен дээр харагдах байдлаар зурсан зураг



Анна Рукавишникова 2021 онд гаргасан ном

“ЭНЦИКЛОПЕДИЯ МУЖСКОЙ ОДЕЖДЫ в технически РИСУНКАХ” гэдэг номны агуулга

1. Загвар


2. Бүрдэл хэсэг

3. Тодорхойлолт гэсэн хэсгээс бүрдэж хийгдсэн ба энэ нь эрэгтэй хувцасны нэвтэрхий толь юм. Ажлын зураг бүрдэл хэсгийн хэлбэрийг оновчтой судалгаатай зурагдсан байсан ба анхлан сурагч номноос зурах аргачлалыг ойлгох боломжгүй мэт санагдсан ба энэхүү номыг дагалдан ирэх цахим програмын үзэн мөн сургалт авснаар зурах чадвар илүү нэмэгдэх мөн номыг бүрэн дүүрэн ашиглах боломжтой.

2 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1 Судалгааны арга зүй, материал:

Хүний биеийн анатоми ба бодит хэмжээнд тулгуурлан зурах туршилтын аргыг ашигласан. Хувцас зурахаас өмнө мэдэх хамгийн эхний зүйл бол анатоми юм. Анатоми ба харьцаа нь ажлын зураг зурахад зайлшгүй шаардлагатай байдаг. Хүний биеийн байрлалыг хавтгай дээр, тэнхлэгүүдээр тодорхойлоход бие анатомийн зөв байрлалд буюу цэх босоо, хөлийн өлмий урагш чиглэсэн, гарын алга урагш хандсан байх шаардлагатай. Анатомийн зөв байрлал нь зөвхөн хүний биеийн байрлал төдийгүй тэнхлэгүүдийг тойрсон үений хөдөлгөөнийг зөв тодорхойлоход мөн хэрэг болно. Хүний биеийн антомын тодорхой мэдлэгийг мэдлэг олж авснаар ерөнхий хэмжээг гарган түүнд тулгуурлан ажлын зураг зурах явдал юм. Эмэгтэй хувцасны дундаж хэмжээгээр тулгуурлан ажлын зургийг зурах нь ОБО мэргэжлээр суралцаж буй оюутнуудад дөхөм болж оюутан бүр хичээлд хамрагдаж цамц, фотболк, жакет зэрэг зургийг төвөггүй зурж загварчилж байсан. Эмэгтэй цамцны зургийн хэмжээсүүдийг өгөлгүй зуруулахад 20 минут зурсан бол хэмжээг өгөөгүй зурахад 35 минут зурсан. Мөн үндсэн 3 шулууныг ашиглан бүсэлхийн хувцас зурах түүн дээр загварын өөрчлөлтийг хялбархан хийж байсан боловч боловсронгуй болгож өгвөл цаг хугацааг хүртэл хэмнэх боломж байгааг харсан. Ингэхдээ үндсэн



шугам хоорондын хамаарлыг өгсөн нь бүрдэл хэсгүүд хоорондоо порпорт хялбар зурагдах нөхцөл болсон.

Туршилтын хамрах хүрээг цаашид нэмэгдүүлэн YUPK-н ОБО 1а, 1б ангийн нийт 62 сурагчаар бүсэлхийн хувцас зурах ЧН-н дагуу юбка зурах даалгаврыг 2 өөр арга зүйгээр зурах даалгавар өгч зуруулсан. Үүнд:

Даалгавар1. Фото зургийг харж ,өөрийн мэдрэмжээр хуулж зурах .

Даалгавар2. Багшийн заасан хэмжээнд тулгуурлан зурах.





Даалгаврыг ижил хугацаанд гүйцэтгүүлсэн .Эхний ангийн хувьд харьцаа маш ихээр алдагдаж зурагдсан бол 2 ангийн үр дүнгийн ялгаа их зөрүүтэй даалгаврын цагаас өмнө 25 хүүхэд дуусгасан ба хувцасны ерөнхий харьцаа ,бүрдэл хэсгийн хоорондын хэмжээ зөв харагдаж байсан.Туршилтаас харахад биеийн хэлбэрийг гаргах тал дээр хөшүүн бөгөөд шугамын тусламжтайгаар гаргахад 2D зурагт шилжүүлэн сайжруулах шаардлага харагдсан

Даалгавар1.Фото зургийг харж ,өөрийн мэдрэмжээр хуулж зурсан зураг

ОБО-н 16 ангийн сурагчид БХАЗ -зурах ЧЭ -н хүрээнд зурсан зураг 2020он

Даалгавар1-т оролцсон ОБО ангийн 32 хүүхдийн бүсэлхийн хувцас зурах чадамжийн нэгжийн юбоканы ажлын зураг зурах даалгаврын зургийг харж байна .

1.Фото зургийг харж дүрсэлсэн боловч бүсэлхийн шулуун, өгзөгний шулуун, ерөнхий уртын харьцаа алдаатай зурагдсан



2.Бүрдэл хэсгүүдийн хэмжээ харьцаа тэдгээрийн байрлал алдаатай зурагдсан

3.Хугацааны хувьд 30-с дээш минут болсон ба зарим хүүхэд яаж зурах хаанаас эхлэх тал дээр хоосон цаас үзүүлэн зурах чадвар байхгүй учраас зураагүй гэх хариулт өгсөн

4.2 талын хэмжээ тэгш биш зурах мөн дугуйрах хазайх гэх мэт алдаа харагдаж байна.

Даалгавар2. Багшийн заасан хэмжээнд тулгуурлан зурах.



Хэмжээ харьцааг зурах аргачлал

https://drive.google.com/file/d/1pBp-j02hUUoFSwu_es5aewXfyo_-21b9/view?usp=sharing

Хэмжээг тодорхойлсон бичлэг

Бичлэгийг үзүүлэн доторхой хэмжээг өгч зуруулсан ба зурж байх хооронд заавар зөвлөгөөг өгсөн .Үүний дагуу юбоканы ерөнхий хэлбэрийг гаргаж багшийн өгсөн фото зурагнаас загварын хэлбэрийг харж зурж гүйцэтгэсэн . Гүйцэтгэх хугацаа хүүхэд бүр өөр байсан ч зөрүү гараагүйн дээр зурахад хүүхдэд хялбар болж сэтгэгдэл өндөр байсан.

Зураг 3.1.3



ОБО-н 1а ангийн сурагчид БХАЗ -зурах ЧЭ -н хүрээнд зурсан зураг 2020он

Даалгавар2-т оролцсон ОБО ангийн 30 хүүхдийн бүсэлхийн хувцас зурах чадамжийн нэгжийн юбоканы ажлын зураг зурах даалгаврын зургийг харж байна .

1.Фото зургийг харж хэмжээнд тулгуурлан зурах үед бүсэлхийн шулуун, өгзөгний шулуун, ерөнхий уртын харьцаа ялгагдаж зөв харьцаатай зурагдсан

2.Бүрдэл хэсгүүдийн хэмжээ харьцаа тэдгээрийн байрлал хоорондын зай алдаагүй ойлгомжтой зурагдсан

3.Хугацааны хувьд 20-с доош минут болсон ба зарим хүүхэд чадах бол уу би зургийн авьяас байхгүй шдээ гэх бодол байсан ч зурж чадсандаа урам авч байсан.

4.2 талын хэмжээ тэгш мөн урд ард талын ялгааг гаргаж өгч зурсан нь харагдаж байна.

Хөтөлбөрийн шинэчлэлтийн хэсэг Ажлын зураг ,зурах ЧН -ийн цаг болон асуулгад орсон өөрчлөлтийг тусгаж өгөх

Ажлын зураг зурах хичээлийн цаг нь эзэмшүүлбэл зохих мэдлэг ур чадварыг олоход хүрэлцэж байгаа эсэхийг 2012-2017 онд хичээлийг заадаг болон зааж байсан багш нараас ,


тухайн хичээлийг сонгон суралцаж буй сурагчдаас цагийн хүрэлцээ ,багш нарын ямар арга зүй нь ур чадвар эзэмшихэд оновчтой байгааг судаллаа.Судалгаанд ҮУПК-д оёдлын болон дизайны 7 багш „Ажлын зураг,зурах ЧН-ийг сонгон судалсан болон судалж байгаа 82 суралцагчийг оролцуулав.

Сурагч нараас

Асуулт1.

Юбканы ажлын зураг зурахад хэдэн минут зарцуулдаг вэ?

а) 15мин б)30мин в)20мин г)5мин



Сурагчид юбканы ажлын зураг зурахад хэдэн минут зарцуулдаг вэ?гэсэн асуултанд

20мин-30мин зурна гэж хариулсан байна үүнээс дүгнэн харахад ажлын зураг зурах аргыг хялбар болгож,хичээлийг үр бүтээлтэй өнгөрөөх ,хичээлийн үргэлжлэх цаг хугацаанд төрөл бүрийн юбка зурах чадамж эзэмших боломжийг олгоход тодорхой хэмжээ харьцааг гаргаж өгөх шаардлага байна.

Асуулт2.

Танд ямар загварчилгаа өгвөл илүү зурах вэ?

а)Бүрдэл хэсгүүдийг нүдэн баримжаагаар пропорцтой зуруулах


б)Хүний биеийн дүрсийг өгөн хувцас өмсүүлэх зарчмаар зуруулах

г)Фото зураг харуулан давтамжтайгаар зуруулах

д)Цээжний харьцааг гаргасан ,бүсэлхийн харьцааг гаргасан бэлэн зураг өгөн зуруулах

е)Бие даан зуруулах

ж)Хэмжээ харьцааг зөв гаргасан биет тоонд тулгуурлан зуруулах



1. Ажлын зураг ,зурах хичээлийг зөв оновчтой зурах арга зүйг боловсруулж турших ,цаашид сайжруулах

2. Зурах арга зүйд чиглэсэн гарын авлага заавар бичиж боловсруулах хэрэгцээтэй байгаа нь тодорхой байна.

Иймээс сурагчдыг мэдрэмжтэйгээр хараад зур гэхээсээ илүү бодитой пропорцтой зурах арга зүйд суралцуулах шаардлага гарч ирсэн юм.

2.2 Олон улсын сэтгүүлүүдэд хэвлэгдсэн ажлын зургийн харьцааг судлах

Ажлын зураг ,зурах ур чадварыг илүү богино хугацаанд олгох хялбар болгохын тулд (Олон улсын сэтгүүл болох Burda , Moden , Шитье гэх сэтгүүлүүдийн эсгүүрийн зураг болон ажлын зургийн хэмжээнүүдийг харьцуулан биеийн хэмжээг масштабаас хамааран ажлын зургийн зурах хэмжээг тооцон боловсрууллаа. Хувцасны ерөнхий урт (эдлэлийн урт,ханцуйн урт)үндсэн шугамууд дээрх өргөний хэмжээнүүдийг ажлын зурагт буулгахдаа энэхүү аргийг улам дэлгэрэнгүй болгох. Стандарт эмэгтэй,эрэгтэй хүний бие галбиртай улам дөхүүлэх мөн гаднах хэлбэр харьцааг харагдах байдлаас нь илүү болгохын тулд энэхүү зөрүүг ашиглан гарах үр дүнг харлаа.

Хүснэгт 3.2.1

burda сэтгүүлийн 2015он 4 сарын сэтгүүл дээрх 114т эмэгтэй цамцны эсгүүрийн болон ажлын зургийн харьцуулалт			
40размерын эмэгтэй цамц	Эсгүүрийн хэмжээ/см/	Ажлын зургийн хэмжээ/см/	Маштабын хэмжээ
Ерөнхий урт	64	1.8	35.56
Цээжний тойрог	26.4	0.8	33.00
Бүсэлхийн тойрог	24	0.75	32.00
Өгзөгний тойрог	28.2	0.8	35.25
Ханцуйн урт	57.3	2.2	26.05
Ханцуйн өргөн	18.5	0.55	33.64

Эх сурвалж олон улсын сэтгүүл burda

Хүснэгт 3.2.3

服装新款搭配杂志, 2013,#4北京服装设计傅会出版社 эсгүүрийн болон ажлын зургийн харьцуулалт			
40 размерын эмэгтэй цамц	Эсгүүрийн хэмжээ/см/	Ажлын зургийн хэмжээ/см/	Маштабын хэмжээ
Ерөнхий урт	60	2,2	27,27
Цээжний тойрог	22	0,75	29,3
Бүсэлхийн тойрог	18	0,6	30
Өгзөгний тойрог	21	0,7	30
Ханцуйн урт	59	2,1	28,09
Ханцуйн өргөн	16	0,5	32

Эх сурвалж олон улсын сэтгүүл 2013,#4北京服装设计傅会出版社хуудас10

Moden сэтгүүлийн 2015он 5сарын сэтгүүл дээрх эмэгтэй цамцны эсгүүрийн болон ажлын зургийн харьцуулалт			
40-ын эсгүүрийн цамц	Эсгүүрийн хэмжээ/см/	Ажлын зургийн хэмжээ/см/	Маштабын хэмжээ
Ерөнхий урт	59	2,1	28,09
Цээжний тойрог	20	0,75	26,6
Бүсэлхийн тойрог	16	0,6	26,6
Өгзөгний тойрог	21	0,8	26,25
Ханцуйн урт	59	2,1	28,09
Ханцуйн өргөн	16	0,5	32

Эх сурвалж олон улсын сэтгүүл Moden

Хүснэгт 3.2.7

Шитье сэтгүүлийн 2015он 5сарын сэтгүүл дээрх эмэгтэй цамцны эсгүүрийн болон ажлын зургийн харьцуулалт			
40-ын эсгүүрийн цамц	Эсгүүрийн хэмжээ/см/	Ажлын зургийн хэмжээ/см/	Маштабын хэмжээ
Ерөнхий урт	66	1.8	36,66
Цээжний тойрог	22,5	0.8	28,12
Бүсэлхийн тойрог	20	0.75	26,6
Өгзөгний тойрог	23	0.8	28,75
Ханцуйн урт	58	2.2	26,36
Ханцуйн өргөн	19	0.55	34,54

Эх сурвалж олон улсын сэтгүүл Шитье

Нийт burda 2015-2017оны сэтгүүл 5,БНХАУ-н оёлын сэтгүүл 2013,2015 оны сэтгүүл,Шитье 2015-2017 оны сэтгүүл 5,Moden 2015-2017 оны сэтгүүл 5 эмэгтэй ижил төрлийн сэтгүүлүүд дээрээс харьцуулалт хийсэн.


Сэтгүүлүүдээс дундаж коффициент хоорондох зөрүү төдийлөн их багын зөрүү гарахгүй байна.Өөрийн өгсөн хэмжээн дээр дундажлан гаргах боломжтой.

Сэтгүүл бүр эсгүүр ажлын зургийн хооронд харьцангуй зөрүү байхгүй ба эдгээр хэмжээнээс цээжний тойрог ,бүсэлхийн тойрог,өгзөгний тойрогт харьцуулалт хийсэн үүний үр дүнд бүсэлхийн тойрог бодит хэмжээнээс 1 см аар бага хэмжигдэж ажлын зурагт зурагдаж байгаа нь харагдсан ба ажлын зураг зурахад бүсэлхий нь бодит хэмжээнээс нарын харагдах нь чухал юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн .

Хэмжээ бүр сэтгүүлүүдийн загвараас хамааран ажлын зургийн өөрчлөлт гарч өргөн нарын хэмжээ,зурган дээр өөр өөр байна тоог илтгэж байна.

ҮР ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.3 Судалгааны үр дүн



Хамгийн түгээмэл арга бол биеийн өндрийг харьцангуй хэмжихийн тулд толгойн өндрийг хэмжих нэгж болгон ашиглах явдал юм. Дундаж тоо нь долоон толгой боловч зургаагаас найман толгой хүртэл байдаг нь хэвийн гэж тооцогддог. Хамгийн тохиромжтой дүрсийг найман толгой өндөр хэлбэрээр дүрсэлсэн үндсэн хэмжээг зурж гаргасан.

2.4 Ажлын зураг,зурах туршилт, үр дүн

А-хэлбэрийн юбка ,Шулуун юбка, Бариу юбка 3 өөр хэлбэрийн юбкыг 3-н ижил хэмжээг ашиглан зурах аргаар зурсан ба бүх зургийн үндсэн шулуун нэг байгаа боловч загвар хэлбэр өөр өөр гарч ирсэн нь загварын өөрчлөлтийг хийхэд зурж чадахгүй хүн ч зургийг зурах боломжтой болсон.



А-хэлбэрийн юбка

Шулуун юбка

Бариу юбка

Өмд зурах шулуун ,бариу,өргөн өмдний хэлбэрийг ижил хэмжээг ашиглан зурах аргаар зурсан ба бүх зургийн үндсэн шулуун нэг байгаа боловч загвар хэлбэр өөр өөр гарч ирсэн нь загварын өөрчлөлтийг хийхэд нөлөө үзүүлэхгүй байгаа ба зурж чадахгүй хүн ч зургийг зурах боломжтой болсон.



ДУГНЭЛТ



Сургалтын байгууллагуудад уламжлалт сургалтын аргаас салж Чадамжид суурилсан сургалтын тогтолцооруу шилжиж сургалтын агуулга ,арга зүйд өөрчлөлт шинэчлэлт хийсээр байна. бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлээр суралцаж байгаа суралцагч нарт заавал эзэмшсэн байх ур чадвар дотор “Ажлын зураг зурах” ур чадвар багтсан байна.Тэгвэл ААН-ийн үзэж байгаагаар оёдолчин хүн

захиалагчийн хүсэл, сонирхлыг тусгасан загварыг хурдан хугацаанд пропорцтой буулгах ур чадвар эзэмших нь чухал гэж тодорхойлсон .Чадамжийг ажиглахуйц,хэмжигдэхүйц,бодит хүчин зүйл нь дадлага юм. Ур чадварыг богино хугацаанд хэрхэн олгох вэ? гэсэн асуулт гарч ирснээр энэхүү судалгаа хийгдэх шалтгаан болсон .

Туршилт судалгааны үр дүн:

1. Ажлын зураг зурахад юу нөлөөлөх вэ гэсэн анхны асуултын хариу бол хүний биеийн анатоми.Тиймээс зураг зурахад зайлшгүй шаардлагатай хүний биеийн харьцааны талаарх үндсэн цэгүүдийг авч үзэх хэрэгтэй болсон ба судалгааны үндсэн дээр хүний биеийн харьцаа түүний хоорондын уялдаа холбоо байрлалын талаар бүрэн мэдээлэлтэй болсон.Энэхүү хэмжээ харьцаан дээр тулгуурлан хавтгай биет дээр хувцас өмсүүлэн зурах харагдах байдлаас зөв гэсэн хэмжилтүүдийн үр дүн тодорхойлогддог болох нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

2. МБС,сургалтад ажлын зураг зурах ЧН-н хичээлийн агуулга ,цагийн багтаамж:

Чадамжтай гэж үнэлэх боломж нь сургалт мэдлэгт суурилж ,чадвар хандлагаар чадамж илэрхийлэгддэг үүнтэй нягт холбоотой зүйл бол цаг цагийн хүртээмж юм. Энэ судалгаагаар цагийн хуйвд шинэчлэлт хийн цагт багтаж хялбар аргаар заах биш цагийг уртасган шаардлага байгаа нь судалгаанаас тодорхой харагдаж байна.

3. Туршилтын хамрах хүрээг цаашид нэмэгдүүлэн ҮУПК-н ОБО 1а,1б ангийн нийт 62сурагчаар бүсэлхийн хувцас зурах ЧН -н дагуу юбка зурах даалгаврыг 2 өөр арга зүйгээр зурах даалгавар өгч зуруулсан .Мөн 7 багшаас асуулгын аргаар заах арга болон цагийн хүртээмжээр судалгааг явуулсны үр дүнд зурах арга зүйд чиглэсэн гарын авлага заавар бичиж боловсруулах хэрэгцээтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна.

4. Ажлын зураг зурах хичээлийн чухал хэсэг бол хувцасны бүтцийг илэрхийлж буй үндсэн дүрс,хэлбэр харьцааг гаргах явдал юм.

Хувцасны онцлог ,деталь хэсгүүд,хуваалт,загварын гол санаа түүний харьцааг түүний хэлбэр хийцийг зөв илэрхийлж хавтгайд зурснаар мэргэжилтнүүдэд таны ажлын зургийг харан ойлгоод унших, түүний дагуу үйлдвэрлэх үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ.Иймээс хялбар ойлгомжтой зурах арга барилыг судалгааны үндэслэлд тулгуурлан гаргаж ирэн түүнийг 3-н хэмжээ ашиглан зурах аргаар бүтээлээ зурж туршиж үзсэн.Үүний үр дүнд цаг ашиглалт бага ,хялбар болон ижил хэмжээгээр бусад хэлбэр хийцийг илэрхийлэх боломж бүрдэж байна.

НОМ ЗҮЙ



1. Захиалгат хувцас оёх технологи УБ хот2006он

2. Зохиомж УБ хот2006он

3. Оёлын технологи УБ хот 2008он

4. Энциклопедия мужской одежды в технических рисунках

Анна Рукавишникова 2020он

5.(2002).Мэргэжлийн боловсролын шинэчлэл,"Монголын мэргэжлийн боловсролыг дэмжих төсөл".УБ

6.(2000).Мэргэжлийн сургалтын стандартыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийцүүлэх нь

7.Цээпил .С .(2002).Мэргэжлийн боловсрол,сургалтын шинэчлэлийн онол арга зүйн зарим асуудал.УБ



<http://myfashionschool.ru/>

<https://fine-craft.ru/>

<https://www.labyrinth.ru/books/517331/>

[https://bakemono.ru/lessons/pencil/886-](https://bakemono.ru/lessons/pencil/886-osnovy-risovaniya-tela.html)

[osnovy-risovaniya-tela.html](https://bakemono.ru/lessons/pencil/886-osnovy-risovaniya-tela.html)

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

СУРАГЧДЫН ЗӨВ ТӨЛӨВШИЛ, ХАНДЛАГА,
ХАРИЛЦААГ ХИЧЭЭЛД ДҮГНЭХНЬ

АНГЛИ ХЭЛНИЙ БАГШ Ж.ЛОСОЛМАА
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАГШ Л.АЛТАНЗУЛ



СЭДЭВ: "СУРАГЧДЫН ЗӨВ ТӨЛӨВШИЛ, ХАНДЛАГА, ХАРИЛЦААГ ХИЧЭЭЛД ДҮГНЭХ НЬ"

Сэдэв сонгох болсон үндэслэл:



Өнөөгийн боловсролын зорилгын нэлээд чухал хэсэг нь сургалтыг чанартай явуулж, сурагч бүрт гарах ахицыг үнэлэх явдал болоод байна. Зөвхөн академик чадварыг үнэлдэг үе өнгөрч мэдлэг чадвараас илүү хандлага, төлөвшилийг үнэлж ажилд авдаг цаг иржээ. Коллежийн салбарт ихэнх нь өсвөр насны сурагчид суралцаж ерөнхий боловсролын сургуулиас ялгаатай бие хүн болон төлөвшиж олон талын мэдлэг чадварыг эзэмшин гарч байна. Бидний гаргасан бүтээгдэхүүнүүд нийгэмд эзлэх байр суурь, хандлага төлөвшил ямар байна вэ? Насны ангилалаар авч үзвэл өсвөрийнхөн дийлэнх хувийг эзэлж байна. Сургуулийн эрхэм зорилгодоо уялдуулан эдгээр хүүхдүүдэд уг салбарт суралцах хугацаанд зөв, хандлага, төлөвшилийг эзэмшүүлэх боломж бий юу? гэх мэт асуудалын дагуу олон улсын кембрижийн сургууль коллежийн хөтөлбөрөөс жишээ авч зарим зүйлийг хэрэгжүүлж туршиж үзхийн тулд энэхүү сэдвийг сонгон авлаа.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО:



Олон улсын кембрижийн хөтөлбөрийн хувь хүний хөгжлийн үзүүлэлтүүдийг коллежийн сурагчдад хичээл, амжилтын шалгуураар эзэмшүүлэхийг зорьсон. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

Судалгааны зорилт:

1. Хүний насны үечлэл, өсвөр насны онцлог судлаачдын гаргасан мэдээ мэдээллийг судлан түүвэрлэх
2. Хандлага, төлөвшил, харилцаатай

холбоотой гадаад дотоодын ном, сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэл уншин судалж, дүн шинжилгээ хийн, тоймлон бичих

3. Үндсэн ухагдахуун нэр томъёонуудыг судалж тодорхойлох
4. Кембрижийн хөтөлбөрийн хувь хүний чадваруудыг судлан, тоймлон бичих
5. Тухайн бүлгийн хандлагыг судалгаагаар тогтоох
6. Сурагчдаас чанарын, анкетийн судалгаа авч, анализ хийх

7. Судалгааны үр дүнд үндэслэн өөрийн санал дүгнэлтийг бичих
8. Хичээлд ашиглах, шинээ санаа туршиж хэрэгжүүлэх
9. Дэвшүүлэх ашиглаж болохуйц санаа гаргах, нэгдсэн үр дүн дүгнэлт бичих

Судалгааны объект:

Сүхбаатар дүүргийн Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 1-р курсийн оюутнууд.

Судалгааны арга зүй:

- **Бие хүний чиг хандлагыг тодорхойлох сорил Б.Басс**
1967 онд Б.Бассын зохиосон бие хүний чиг хандлагыг тодорхойлох судалгаа авсан. Нийт 27 бодомжоос бүрдэнэ. Сорилыг хийхдээ хамгийн их үнэлэмж өгч буй хэсэгт 2 оноо, нийцэхгүй байгаа хэсэгт 0 оноо, бөглөхгүй орхиход 1оноо болно.Гарсан оноог нэгтгэн хавтгайд тэмдэглэж сурагчдын ерөнхий хандлагыг тодорхойлно
- **Чанарын судалгаа**
Анги тус бүрээс эерэг, сөрөг, дундаж хандлагатай хүүхдүүдээс ярилцлага авах. 23 ангийн төлөөл
 1. Зөв хандлага, төлөвшил, харилцаа гэж чиний бодлоор юу вэ?
 2. Зөв хандлага, төлөвшил, харилцаа хүнд ямар хэрэгтэй вэ?
 3. Эдгээрийг хэнээс үлгэр дууриалал авдаг вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцаа)
 - 4.Багш хэрхэн нөлөөлж байна вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцаанд)
 5. Сургуулийн орчинд яаж хэрэгжүүлдэг вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцааг) асуултын дагуу авна.

СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ:

Хичээл бүрийн онцлогт тохирсон амжилтын шалгуур гаргаж, нийтээр дагаж мөрдөх зөв зохистой хэм хэмжээг оюутнуудад төлөвшүүлэн сургуулийн эрхэм зорилгыг биелүүлсэн боловсон хүчин бэлтгэх ач холбогдолтой.

ОНОЛЫН ХЭСЭГ



Эрик Эриксоны "Бие хүний хөгжлийн" тухай онол

Эриксон хүний нийгэмтэй харилцах харилцаанд гол анхаарлаа хандуулж өөрийн онолоо боловсруулсан. Түүний хувьд хүн төрөлхтөнд түгээмэл нийгэм-сэтгэлзүйн хөгжлийн үе шатыг бодгаль хүн дамждаг. Хөгжлийн үе шат болгон нь тодорхой хямралт үед эхлэх бөгөөд эдгээр үе шат бүрд байх эерэг, сөрөг тал бүхий хямралыг шат дараалан эерэгээр шийдсэн тохиолдолд өөрийгөө бүрэн дайчилсан бие хүн төлөвшинө гэж үздэг[1].

Хөгжлийн тавдугаар үе шат: /Өсвөр нас /12-20 нас/. Би-ийн адилтгал ба үүрэг
холидох мэдрэмжийн зөрчил. Өсвөр насны хүүхдүүд өөрийгөө өөртэйгээ адилтгасан дотоод адилтгалыг тогтмол мэдэрч, энэ мэдрэмжийг нь бусад хүмүүс хүлээн зөвшөөрч байна гэсэн итгэлтэй байх нь чухал. Ингэснээр энэ шатны эерэг тал болох өөрийн итгэл үнэмшил, дотоод ертөнц, чиг зорилгодоо үнэнч байдал үүснэ. Гэхдээ ийм итгэл үнэмшил нь бусадтай харилцах харилцаанд эргэх холбоогоор батлагдаж байх нь чухал. Хэрвээ эерэг холбоо батлагдахгүй бол өөрийгөө танин мэдэлгүйгээр хэтэрхий дэврүүн зантай болж, хүршгүй зорилго тавин төөрч будилж магадгүй. Ийм тохиолдолд “ би ирээдүйд хэн болох вэ?, юу хийх ёстой вэ?, амьдралдаа ямар зорилго тавих вэ?” гэх мэт ойлголтын төөрөгдөл буюу үүрэг холидолтын зөрчилд автана.

Хүүхдийн оюун ухааны хөгжлийн тухай Жан Пиажегийн онол:[2]

Швейцарийн сэтгэл зүйч Жан Пиаже /1896-1980/ оюун ухааны хөгжлийг дараах байдлаар явагддаг гэж үзжээ. “Мэдлэг бол үйлдэл юм”[3]. Үйлдлийн явцад схемүүд бий болно. Хүмүүс хөгжлийнхөө явцад мэдээллийг зохион байгуулах, гадны ертөнцийг ойлгохын тулд илүү нарийн схемүүд хэрэглэдэг. Пиаже хүүхдийн оюун ухааны хөгжлийг чанарын хувьд өөр хоорондоо ялгаа бүхий 4-н үе шат болгон ангилжээ. Үүнд:

Формоль үйлдлийн шат /12-оос дээш нас/ Үүнийг хийсвэр үйлдлийн шат гэж нэрлэж болно. Учир нь үүний өмнөх шатан дээр хүүхэд юмсын багтаамж тоо ширхэг, орон зай зэрэг физик шинжүүдийн аль нэгийг ашиглан үйлдэл хийх чадвартай байдаг учраас тэдний танин мэдэх үйл ажиллагаа нь харьцангуй хязгаарлагдмал шинж бодит зүйлээс хамааралтай байдаг гэж Пиаже үзжээ.

Сургалт ба оюун ухааны хөгжлийн харьцааны тухай Л.С.Выготскийн онол:

Оросын сэтгэл зүйч Л.С.Выготскийн үзэж байгаагаар, бидний өссөн орчин танин мэдэхүйн чухал үүрэгтэй байдаг. Бидний суралцах үйл явцад үзүүлж байгаа нийгмийн нөлөөг харгалзахгүйгээр танин мэдэхүйн хөгжлийг ойлгох боломжгүй юм гэж үздэг. Танин мэдэхүйн хөгжил нь бусадтай хамтран асуудлыг шийдвэрлэх нийгмийн харилцан үйлчлэлийн үр дүнд явагддаг. Энэ харилцан үйлчлэлд орсноор хүүхдийн танин мэдэхүйн хөгжлийн түвшин дээшлэх бөгөөд оюун ухааны үйл ажиллагаа нь хөгжиж эхэлдэг. Хүүхдийн хөгжлийг тайлбарлахдаа Л.Выготский 2 бүсийг тодорхойлсон. Эдгээр нь хөгжлийн бодит ба ойролцоо бүсүүд. Хүүхдийн хөгжлийн бодит бүс гэдэг нь хүүхэд өөрөө, бие дааж шийдвэрлэж, хийж чадаж байгаа үйлдлүүдээр тодорхойлогдоно.

- [1] Эрик Эриксон үзэж уг онолоо боловсруулсан ажээ.
- [2] Хүүхдийн хөгжлийн хэрэгцээ ба нийгмийн ажил /24,25,26,27 хуу/
- [3] Жан Пиаже хэлсэн байдаг

Хүүхдийн хөгжлийн “бодит бүс” нь:

- Хэний ч тусалцаагүйгээр хүүхэд бие даан хийж чадаж байгаа зүйлүүдээр тодорхойлогдоно.
- Энэ бол өчигдөрийн хөгжлийн үр дүн, өнөөдрийн хүрсэн амжилт юм.
- Сургалт нь хүүхдийн аль хэдийн хийж чаддаг болсон зүйл дээр тулгуурлан оюуны хөгжлийг араас нь идэвхигүй дагаж явах ёсгүй.

Хүүхдийн хөгжлийн “ойрын” бүс нь:

- Хүүхдийн хараахан бие даан хийж чадахгүй боловч насанд хүрэгчдийн ялимгүй тусалцаатай хийж чадах зүйлүүдээр тодорхойлогдоно.
- Санаа авахуулах, заавар өгөх, загнах, дэмжин урамшуулах гэх мэт.
- Энэ төвшин нь хүүхдийн оюуны хөгжлийн маргаашийг тодорхойлж байдаг.

Сургалт нь хүүхдийн оюуны хөгжлөөс ялимгүй урьтан, түүнийг араасаа дагуулан эрчимжүүлэн явах ёстой.

“Хөгжлийн өмнө явж байгаа цагт л сая сургалт нь сайн сургалт байх юм”[4] гэж Л.С.Выготский бичиж байжээ.

[4] Л.С.Выготский энэ онолдоо сургалтыг хүний хөгжлийн үндэс гэж үзсэн байна.

“Хүүхдийн сэтгэцийн хөгжлийг” тодорхойлсон: Д.Б.Эльконины үечлэл

Насны үечлэл	Зонхилох үйл ажиллагаа	Танин мэдэх үйлийн чиглэл	Сэтгэцийн үйлийн түлхүү хөгжих салбар	Тухай насны шинэ бүрдэл /шинээр гарц ирсэн зүйл/
Нялх үе /0-1/	Шууд итгэлийн хөдөлгөөнт харилцаа	Харилцааг танихад	Бие хүний /хэрэгцээ сэдлийн тал/	Харилцах хэрэгцээ сэтгэл хөдлөлийн харилцаа
Балчир нас /1-3/	Эд юмстай хийх үйлдэл	Юмсыг танихад	Танин мэдэхүйн процессууд	Хэл яриа ба харагдах үйлийн сэтгэхүй
Сургуулийн өмнөх нас /3-7/	Дүрт тоглоом	Харилцааг танихад	Бие хүний /хэрэгцээ сэдлийн/	Нийгмийн ач холбогдол бүхий орчны зүгээс үнэлэгдэх үйл ажиллагаа хийх эрэлт хэрэгцээ
Сургуулийн бага нас /7-11/	хичээл	Шинжлэх ухааны анхан шатны эхийг танихад	Оюун ухаан-танин мэдэхүйн	Юмыг зориуд хийх чадвар, үйлдлийн дотооп төлөвлөгөө Өөрийн хяналт

Өсвөр нас /11-15/	Сургалт ба зохион байгуулалт бүхий хөдөлмөрийн үйл ажиллагааны явцад илрэх харилцаа	Янз бүрийн нөхцөлд илрэх харилцааны тогтолцоог танихад	Бие хүний /хэрэгцээ-сэдлийн тал/	“Том болох” мэдрэмж, тэмүүлэл өөрийн үнэлгээ, хамтын амьдралын хэм хэмжээнд захирагдах чадвар
Сургуулийн ахлах нас /15-17/	Мэргэжлийн хандлагатай сурах үйл ажиллагаа	Мэргэжлүүдийг танихад	Танин мэдэхүйн тал	Ертөнцийг үзэх үзэл мэргэжлийн сонирхол

- Бид хүний хөгжлийн болон хүүхдийн сэтгэцийн хөгжлийн онцлогийг тайлбарласан олон онолуудын дотроос Америкийн /Э.Эриксон/, /Швейцарийн Ж. Пиаже/, /Оросын Д.Б.Эльконин/, таван томоохон эрдэмтдийн үзэл баримтлал онолыг судалснаараа хүний хөгжлийг настай нь хамт авч үзэх зүйтэй юм. Тэр тусмаа ялангуяа Э.Эриксон, Ж.Пиаже харын тодорхойлсон насны үечлэл дэлхийн олон улс оронд ихэд алдаршжээ.
- Эдгээр онолуудад адил төсөөтэй зүйлүүд цөөнгүй байгаа нь ажиглагддаг. Жишээ нь: Э.Эриксон, Эльконин нарын хэн хэнийх нь онолд сургуулийн насны үед хүүхдийн хөгжилд хичээл сургалтын нөлөөг, өсвөр үед өөрийгөө таних, бусадтай харилцахын чухалыг тус тус онцлон тэмдэглэсэн байна.
- Гэвч дээрх эрдэмтэд хүүхдийн хөгжлийг үечлэн авч үзэхдээ өөр өөр шалгуур үзүүлэлтийг баримталдаг. Жишээ нь: Жан Пиаже “оюун ухааны хөгжлийг”, Эрик Эриксон “Би” буюу эго-гийн төлөвшилийг, Д.Б.Эльконин “үйл ажиллагаа ба харилцаа” А.Маслоутийн хэрэгцээний шатлалын тухай онол тус тус голлон авч судаллаа.

Хүмүүжил, төлөвшил, нийгэмшил

- Хүмүүжил.** Хүүхдийн хүмүүжил 0-6 насанд эрчимтэй явагдаж 10-12 нас гэхэд хүмүүжлийн суурь тавигдаж дуусдаг. Бид “Өсвөр насны хүүхдийн хүмүүжил” гэж ярихгүй үүний оронд “өсвөр насны хүүхдийн өөрийн хүмүүжил” “төлөвшил”, “нийгэмшил” гэх үгийг хэрэглэнэ.
- Төлөвшил.** Судлаачид “төлөвшил” бол хүмүүжлийн залгамж холбоо, түүний үргэлжлэл бөгөөд өсвөр, залуу настай илүү холбон тайлбарлах хандлага бий. Зарим судлаач төлөвшилийг урт удаан хугацаанд үргэлжлэх үйл явц гэж үздэг бөгөөд түүний үргэлжлэх хугацаа үндсэндээ тодорхойгүй. “Төлөвшил нь хүн хөгжих үйл явцын үр дүн бөгөөд ... урт удаан хугацааны туршид явагддаг. Энэ нь хүний хөгжилд чанарын өөрчлөлт бий болж тэр нь тогтворжин хүнд тогтонги чанар болон шингэхийг хэлнэ” гэжээ.

Нийгэмшил. Хүүхдийн хүмүүжил төлөвшлийн тухай ярихад нийгэмшлийн асуудал зайлшгүй



хөндөгддөг. Судлаач Брим (1969) “Нийгэмшил бол хувь хүн нийгмийн болон бүлгийн амьдралд их, бага ямар нэгэн хэмжээгээр үр өгөөжтэй оролцоход хэрэг болох мэдлэг, чадвар, байр суурь, хандлага эзэмших үйл явц” гэж үзсэн. Хүний нийгэмшил хэлд орох үеэс эхэлж насан турш явагддаг ба насны үе болгонд өөр өөрийн онцлогтой. Ингээд дээр өгүүлснээс үзвэл нийгэмшил хүний насан турш үргэлжлэх процесс бөгөөд түүний эхний чухал үе шат бол хүмүүжил юм.

КЕМБРИЖИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Кембрижийн олон улсын дунд боловсролын хөтөлбөр нь үндсэн дөрвөн үе шаттай.

- Кембрижийн бага боловсрол /5-11 нас/
- Кембрижийн дунд боловсрол-1 /11-14 нас/
- Кембрижийн дунд боловсрол-2 /14-16 нас/
- Кембрижийн бүрэн дунд боловсрол /16-19/ нас




КЕМБРИЖИЙН ДУНД БОЛОВСРОЛ

INTERNATIONAL GENERAL CERTIFICATE OF SECONDARY EDUCATION /IGCSE/ - буюу Олон улсын дунд боловсролын сертификат олгох энэхүү хөтөлбөр нь 14-16 насны суралцагчдад зориулагдсан дэлхийн 160 гаруй улс оронд хүлээн зөвшөөрөгдөн, нийт таван бүлгийн 70 хичээлээс сонгон суралцах боломжийг олгодог. Суралцагчид нь сонгон суралцаж буй хичээл тус бүрээр олон улсын сертификат авах ба мөн бүлэг тус бүрээс нэг, хэлний хоёр нийт долоон хөтөлбөр сонгон амжилттай суралцаж INTERNATIONAL CERTIFICATE OF EDUCATION /ICE/-буюу ОУ-ын суурь боловсролын сертификат авах боломжтой.

КЕМБРИЖИЙН БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

CAMBRIDGE INTERNATIONAL AS AND A LEVEL- буюу Олон улсын ахлах боловсролын сертификат олгох энэхүү хөтөлбөр нь 16-19 насны суралцагчдад зориулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, гурван бүлгийн 55 хичээлээс сонгон суралцах боломжийг олгодог. Суралцагчид нь сонгон суралцаж буй хичээл тус бүрээр олон улсын сертификат авах ба мөн бүлэг тус бүрээс хөтөлбөр сонгон амжилттай суралцаж хамгийн багадаа зургаан кредит цуглуулан ADVANCED INTERNATIONAL CERTIFICATE OF EDUCATION /AICE/- буюу Олон улсын ахлах түвшний боловсролын диплом авах боломжтой.

“Судалгааны хэсэг”



1-р асуултын хүрээнд:


Зөв хандлага, төлөвшилийг 50 орчим хувь нь соёлтой боловсон байх 36% нь дүрэм журамд захирагдах 9% нь бусаддаа нөлөөлөх манлайлах чадвар гэж үзжээ. Яг тодорхой оновчтой тогтсон ойлголтгүй байв.

Судалгааны зорилго.

Тухайн сурагчийн зөв хандлага, төлөвшилийн талаар ерөнхий судалгаа хийх, нийт массын төлөөлөл ойлголтыг гаргаж ирхэд энэхүү судалгааны зорилго оршино.

Уг судалгаанд Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн 23 ангийн 69 суралцагч оролцов.


2. Зөв хандлага, төлөвшил, харилцаа хүнд ямар хэрэгтэй вэ?



2-р асуултын хүрээнд:

Ажил болон амьдралд чухал нөлөөтэй гэж 35% нь хамт олны уур амьсгалд эерэг гэж 28% нь хувь хүний хөгжилд 21% нь сэтгэл зүйд эерэг нөлөөтэй 16% тус тус үзжээ. Ерөнхий чиг баримжаа руу нилээн дөхсөн хариултууд байлаа.

3. Эдгээрийг хэнээс үлгэр дууриалал авдаг вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцаа)




3-р асуултын хүрээнд:

Ихэвчлэн олны танил хүмүүсээс үлгэр дуурайлал авдаг ба багш нар мөн адил чухал нөлөөтэй болох нь харагдаж байна. Эцэг эхийн нөлөөлөл багагүй оролцдог нь дээрх судалганаас харагдаж байна.

Сошиал ертөнцийн хүч давамгайл учраас олны танил хүмүүс дийлэнх хувийг эзлэжээ.

4. Багш хэрхэн нөлөөлж байна вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцаанд)




■ үлгэр дууриалал болдог ■ Маш их нөлөөлдөг ■ Заримдаа сөрөг ■ Бусад

4-р асуултын хүрээнд:

Багш хүн эерэгээр болон сөргөөр нөлөөлж болдогийг харуулж байна. Сөргө нөлөөллийн хариултуудыг нарийвчлан бичиж орууллаа. Эдгээр хариултанд дүн шинжилгээ хийсэн.

5. Сургуулийн орчинд яаж хэрэгжүүлдэг вэ? (Зөв хандлага, төлөвшил, харилцааг)



5-р асуултын хүрээнд:

Олон нийтийн дүрэм журамыг хүүхдүүд мөрдхөд бэлэн байдаг, дийлэнх нь сурагч хүний ёс зүй хэм хэмжээг ухамсарладаг байна. Зарим хэсэг нь яг тодорхой ойлголтгүй учраас хариулт өгхөд төвөгтэй байв. Цөөн хэсэг нь төлөвшил хэмээн үзсэн.

Судалгааны үр дүнд үндэслэн хичээлийн хөтөлбөр агуулгадаа кембриджийн сургууль, коллежийн мөрддөг RERIC хувь хүний хөгжил, төлөвшил, хандлагыг ерөнхийд нь мөрддөг зарчмаас оруулж тусгав.

- **Responsible** Өөртөө итгэлтэй \Бусдын үзэл бодлыг хүндэлж, өөрийн үзэл бодлыг хамгаалах\
- **Engaged** Хариуцлагатай \Дэгийг баримтлах\
- **Reflective** Бүтээлч \Бүтээл хийх, суралцах арга барилаа олох\
- **Innovative** Шинийг эрэлхийлэгч \Асуудал шийдвэрлэх чадвартай байх\
- **Confident** Хүсэл тэмүүлэлтэй \Гэрийн даалгавраа хийх\

Зөвхөн академик чадвараар үнэлгээ гаргалгүй хандлага төлөвшил харилцааг хамтатгаж өгөв. Хичээл бүрт өөр өөр санаа гарч ирч болох бөгөөд эрүүл мэндийн хичээл дээр жишээ аван амжилтын шалгуурыг хэрэгжүүлж үзлээ. Ингэхдээ 5 ангид шалгуургүй 18 ангид шалгуурын дагуу хичээл орсон.

Ангид тогтоох дүрэм

“Хамгийн сайн удирдлага, өөрөө өөрийгөө хэрхэн удирдахыг бидэнд үзүүлж чадах удирдлага юм” Гёте

Дүрэм тогтооно гэдэг нь эрх чөлөөг хязгаарлана гэсэн үг биш юм. Харин хүний эрхийг чөлөөтэй байлгаж, харилцан хүндэтгэл, ойлголцлын хүрээнд эрхээ эдлэхийг хэлнэ. Дүрэмтэй байх нь хамтарч ажиллах сэтгэлгээг бий болгоход чухал ач холбогдолтой. Нэг зорилготой байх, хамтын ажиллагаанд дүрэм нь нийтэд хэрэгтэй юм.

Дүрэм алсыг харж сайн боловсруулсан байх хэрэгтэй Жонес 1987

Дүрэм нь цөөхөн хэдэн заалттай байх хэрэгтэй. Сунжирсан урт дүрэмд зохицон нийцүүлэх, шаардлага тавих асуудал гардаг.

Шинээр гарсан дүрмийн утга учрыг сурагчдад сайн ойлгуулах хэрэгтэй.

Сургуулийн, хичээлийн, ангийн зорилгод нийцүүлж дүрэм журам бэлтгэх хэрэгтэй. Зорилгод нийцэхгүй дүрэм байж болохгүй. Сурагчид энэ дүрэмд зохицсоноор юуг сурахаа сайн мэдэж байх хэрэгтэй.

-Анги танхимд сурагчдын урам зоригийг нэмэх сайн дүрэмтэй байваас эрх мэдлээ эдлэх таатай нөхцөл бүрдэнэ. Дүрэмд шагнал урамшуулал, шийтгэлийн талаар нарийн мэдээлэх нь нийтэд адилхан хандаж байгааг харуулна.

-Хичээлдээ байнга хоцорч ирдэг сурагчид өгөх шийтгэлийг дүрмийн дагуу өгвөл тэр сурагч ч гэсэн зөвхөн өөрт нь дургүй учраас багш намайг шийтгэж байна гэж бодохгүй байх болно.

АЖИГЛАЛТЫН ТЭМДЭГЛЭЛ

Шалгуур хэрэгжүүлээгүй ангид орход хоорондоо үл ялиг сөргөлдөх, бага зэргийн сөрөг хандлага илэрч байв. Хүүхдүүд цаашид ямар хичээл орох яаж дүн гарах тухай тодорхой ойлголтгүй цөөн хэсэг нь хичээлийн цаг дээр хийсэн даалгавараа хийн үнэлгээгээ авч явж байлаа.

Шалгуур хэрэгжүүлсэн ангид хичээл орход хүүхдүүд санаачлагаараа сандал ширээгээ янзалж, самбараа хүртэл булаацалдах шахуу арчиж, шалгуурт заасаны дагуу даалгаваруудаа цаг тухайд нь тооцуулан, идэвхтэй оролцон явж байлаа. Улиралын эцэст дүн гархад хэн ч ямар нэгэн зөрчил гаргаагүй өөрийгөө юун дээр оноо алдсанаа мэдэж дараагийн улиралд сайжруулахаа ярилцаж байсан. Мөн анги хамт олондоо зөв үлгэр дууриалал үзүүлдэг сурагчид нэмэгдсэн.

НЭГДСЭН ДҮГНЭЛТ



Уг шалгуурыг багш бүр хичээлийн онцлогт тохируулан өөрчлөж ашиглах боломжтой.

Мэргэжлийн ур чадвар, зөв хандлага, төлөвшилтэй мэргэжилтэн бэлтгэж салбартаа тэргүүлэх сургууль болно гэсэн сургуулийн минь эрхэм зорилго биелхэд өчүүхэн хувь нэмэрээ оруулах нэгэн жижиг судалгааны ажил энэ хүрээд дуусахгүй цаашид үргэлжид хэрэгжүүлнэ.


ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: СУРАЛЦАГЧДЫН ХАНДЛАГА, ТӨЛӨВШЛИЙН ОНОШИЛГОО БА ХӨГЖИЛ

НИЙГМИЙН БАГШ :Б.БАТСҮРЭН-
ФИЗИКИЙН БАГШ: М.ГАНЦАЦРАЛ-Г.МОНГОЛ
ХЭЛНИЙ БАГШ: ЦОГЦОЛМАА



СЭДЭВ: СУРАЛЦАГЧДЫН ХАНДЛАГА, ТӨЛӨВШЛИЙН ОНОШИЛГОО БА ХӨГЖИЛ

УДИРТГАЛ



Сурган хүмүүжүүлэх ухаанд удирдан чиглүүлэх ба зөнгөөр нь хүмүүжүүлэх гэсэн баримтлал буюу онол байдаг. Товчхоноор хэлбэл албадах ба найдах арга зүй юм.

Өнөө үед сурган хүмүүжүүлэх энэ 2 онол, баримтлалыг сэргэлдүүлэх буюу зохицуулан хэрэглэх нь давамгайлах болсон. Үүний 1 нь дасгалжуулалтын арга юм.

Хүүхэд залуучуудыг хүмүүжүүлэх бодлого болсон хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлье.

Германы нэрт сурган хүмүүжүүлэгч: Бернхард Бубе эрх чөлөө, сахилга батын талаар өнөө үед ямар үзэл

баримтлалтай байгааг иш татая.

Тэрээр “ Юу дуртайгаа хийж хүссэнээрээ байх, эрх чөлөөтэй байхыг хүүхэд, залуус болгон мөрөөддөг. Тэд Ямар ч нэг заавар хориглолтгүй, дүрэм журамгүй тийм л амьдралыг хүсч байдаг. Эрх чөлөө бол төлөв байдал биш харин урт удаан хөгжлийн хожмын үр шим нь өөрийгөө даван туулах хязгааргүй тэмцлийн эцэст сахилга батаас бие даах чадвар болон хувирсан тэр цагт л бий болдог. Эрх чөлөөт байдал гэдэг нь зөвхөн хэнээс ч хамааралгүй байх төдий бус, энэ нь өөртөө тодорхой зорилгоо ёс зүйн тодорхой үнэт зүйлд нийцүүлэн өөрийн амьдралаа тохируулж тууштай мөрдлөг болгож ажиллаж чадаж чадах тэр хүсэл чадварыг хэлнэ. Эрх чөлөөг сахилга батын хүчээр л олж авна.

Өнөөдөр өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа орнуудад ч хүүхэд залуучуудын хүмүүжлийн асуудал маш их хурцаар тавигддаг болсон. Тухайлбал:

- Нийгмийн илэрхий хангалуун амьдрал
- Мөнгөний ноёрхол
- Телевиз, цахим орчны дайралт
- Хүмүүжүүлэх соёлоо мартсан
- Хэт аминч үзэл
- Нийгмийн орчны буруу үлгэрлэл зэргийг давж

Хүүхэд залууст хүн чанарыг дээдэлсэн, ахан дүүсэг, эрх чөлөө, тэгш эрх, хүнийг хайрлах, шударга ёс зэрэг үнэт зүйлсийг эрхэмлэдэг иргэн болгон хүмүүжүүлэхэд маш их анхааран ажилладаг болсон.

ҮНДЭСЛЭЛ



Дэлхийн нийтэд хүүхэд залуусыг хүмүүжүүлэх арга зүй нь тэднийг чин сэтгэлээсээ хайрлан хүндэтгэж хууль ёс, хариуцлага, сахилга батад тулгуурласан хандлагатай болсон. Бид ч хүүхэд залуучуудаа үндэснийхээ сурган хүмүүжүүлэх өв уламжлалд суурилсан тэднийг хүмүүжүүлэх бодлого, эрх зүйн орчныг төрөөс бий болгон ажиллах нь зайлшгүй шаардлага тулгамдсан асуудал гэж харагдаад байна.

Хүмүүжүүлэхийн тухайд: Б.Бусеб “ Сурган хүмүүжүүлэх ухаанд шинэ мэдлэг гэж байхгүй. Агуу их сурган хүмүүжүүлэгчдийн онцлог бол тэд аль ч цаг үед байсан өнгөрсөн үеийн үнэнээс тухайн цаг үеийн хурц асуудлуудад тохирох санаа, туршлагуудыг олж чаддаг л байдаг. Ийм учраас өмнөх үеийнхээ хүмүүжүүлэх туршлагаас сурах нь зөвшөөрөгдөх төдийгүй угаасаа шаардлага юм гэж ойлгодог” гэжээ. Аливаа хөгжлийн асуудлыг авч үзэхдээ тухайн төлөвийн шилжилтийг судлан тооцдог. Хүүхэд өөрөө байгаль нийгмийн тогтолцоо бодгаль болохынхоо хувьд байнга хувьсаж өөрчлөгдөж байдаг онцлогтой. Хүний бие организм, сэтгэхүйн үйл, оюун ба сэтгэлгээний цар хүрээнд тооны ба чанарын өөрчлөлт гарах үйл явцыг **хөгжил** гэнэ.

Хүүхдийн хөгжил гэдэг нь: Түүний бие бялдар, оюун ухаан, ажиллах чадвар, биеэ авч явах байдал, юмс үзэгдэлд хандах хандлага ба харилцаанд чанарын эерэг өөрчлөлт гарах үйл явц юм. Орчин үед хүүхдийн хөгжилд хандахдаа хүүхэд төвт үзэл баримтлалд тулгуурлаж байна. Хүний болон хүүхдийн хөгжлийн талаархи боловсрол судлалын гол онолуудын тулгуур үзэл санааг дэд профессор Д. Энхжаргал “ Сурган хүмүүжүүлэх зүйн үндэс” номонд тайлбарласан байна. Тэдгээрийг дурдвал:

1. Экзистенциализмын онол. (М. Хайдеггер, Ж. П. Сартр, Г. Мерсель)

Хүн бүр өөрийн оршихуй халдашгүй ертөнцтэй байх ба өөрөө өөрийгөө танин мэдэх, нээх замаар хөгжлийн эрх чөлөөг олно. Хүн өөрийгөө боловсруулах явцад түүний амьдралд хандах хандлага төлөвшинө. Бодит ертөнц нь хүний ахуйд оршдог бөгөөд хүрээлэн буй орчноосоо чөлөөт хөгжлийг олж авна.

2. Оюун ухааны цогцолбор онол (Г. Гарднер)

Хүүхдийн хөгжлийг бүхэл бүтэн цогц байдлаар авч үзэж, оюун ухааны 7 шинж чадварыг нарийн уялдаа холбоонд нь цогц байдлаар хөгжүүлэхийг чухалчилсан. (Биеийн, хөдөлгөөний, орон зайн, хэл яриа, логикматематик, хөгжим-урлаг, хүмүүс хоорондын ба өөрөө өөртэйгээ харилцах чадварыг багтаасан.)

Үүний тулд : - Хүүхдийг тал бүрээс нь танин мэдэх

- Хөгжих орчин нөхцөл бүрдүүлэх
- Сургалт хүмүүжлийн ажлыг орчинтой нь амьдралтай нь холбон зохион байгуулах

- Хүүхдийн сайн тал дээр нь тулгуурлан албан бус харилцаа тогтоох нь чухал гэж үздэг.

3. Конструктивизмын онол \ Ж. Дьюи, Ж. Пиажа, Л. С Выготский \

Энэ онолын үзэл баримтлал нь сүүлийн 20 жилд эрчимтэй хөгжиж байна. Онол-үзэл баримтлалын интеграци шинжтэй. Боловсрол сургалтын асуудлыг орчин үеийн шаардлагад нийцүүлж шинэчлэхэд гол суурь онол нь болж байна. Хүүхэд сурах явцдаа мэдэх, хийж бүтээх, өөрийн оршин байх нөхцлийг бүрдүүлж, хамтдаа нийгэмшин тасралтгүй хөгжихийг чухалчилдаг гэжээ.

4. Хүүхдийн цогц хөгжлийн онол \Г. Крайг, Б. Г.Ананев, В. А. Аверин\

Биологийн:

Онтогенезийн явц
дахь бодгал
хөгжлийн үр дүн

Нийгмийн:

-Бие хүний хөгжлийн үр дүн
- Нийгэмшихүйн хөгжлийн үр дүн

Эдгээр нь цогц нийлмэл учраас агуулгын хувьд ч үүргийн хувьд ч нэгдмэл юм. Иймээс хүүхдийн хөгжлийг авч үзэхдээ байгаль нийгмийн тогтолцооны шүтэн барилдлагыг анхааран хэрэгтэй.

5. Бүх талын боловсрол олгох 5 талт зарчим:

• Сэтгэлийн тэнхээтэй болох

Амьдралын тодорхой зорилготой, бэрхшээлийг даван туулж чаддаг, өөрийн гэсэн үзэл бодолтойгоороо бусдын итгэлийг хүлээдэг, хүн өөртөө хариуцлага хүлээдэг байх

• Бие бялдарын хөгжил ба ариун байдлыг сахидаг болох

Хүүхэд бүр багаасаа биеэ чийрэгжүүлэх, зөв авч явах аргад суралцан, бэлгийн зөв зан үйлтэй, садар самуунаас ангид байх чадвартай болох

• Оюуны чадамжаа хөгжүүлэх

Мэдлэг олж авах ашиглах чадвар, шинжлэх ухааны танин мэдэхүйн чадвартай, ерөнхийгөөс нарийвчлан тодорхойлох сэтгэхүйн чадвар эзэмшсэн мэдээлэлзүй, газарзүйн мэдлэг чадвар нь өндөр байх

• Амьдралаа зөв авч явах чадвар

Авъяас чадвараа хөгжүүлэх бусдаас суралцах хамтарч ажиллах, төлөвлөлт хийх, цаг ашиглах, шийдвэр гаргах зэрэг чадвар эзэмших

• Бусадтай харилцах чадвар

Өөрийгөө эрхэмлэн үзэх, бусдыг хайрлах, хүмүүн ёсны харилцааг дээдлэх, гэр бүлээ хүндэтгэх гэх мэт харилцааны үнэт чанаруудыг эзэмших шаардлагатай.

Зөв хандлагатай байснаар өөрчилж болох зүйлс:

- Хандлага амьдралыг үзэх үзлийг өөрчилнө.
- Хандлага хүний харилцааг өөрчилнө
- *Линзний зарчим:* Бид ямар хүн бэ гэдгээс шалтгаалж бусдыг үзэх үзэл шийдэгддэг. Өөдрөг хүн бусдыг өөдрөгөөр л хардаг.
- *Зовж саналах зарчим:* Бусдын сэтгэлийг шархлуулдаг хүн бусдаас сэтгэлийн шарх авах нь амархан
- *Лифтний зарчим:* Бид бусадтай харилцахдаа тэднийг өргөж бас буулгаж ч болно. Яах вэ гэдэг нь бидний зан байдлаас хамаарна
- *Сурч боловсрох зарчим:* Суралцах хандлагатай хүн уулзсан бүх хүнээс сурах юм байгаа гэж боддог. Тийм биш хүн бусдыг үл ойшоож тэднээс сурах юм байхгүй гэж боддог.

Коучинг нь: Орчин үеийн багшийн мэргэжлийн чадавхийг дээшлүүлэхэд ашиглах инновацийн технологи юм.


Коучингийн утга учир:

- Зорилго руу тэмүүлэх
- Хувь хүний болон багын нөөц бололцоог бүрэн нээх

Коучинг ашиглаад хүмүүс зорилгодоо үр дүнтэй хурдан хүрдэг, өөрийн хөгжих сонголтыг тодорхойлж чаддаг.

Коучингийн 5 үндсэн зарчим

- Тухайн мөчид хамгийн оновчтой сонголтыг хийх
- Амжилтанд хүрэх нөөц бололцоо гарц байнга байдаг
- Үйлдэл бүрт эерэг хандлагатай байдаг
- Сонголт бүрийн ард сэхдэг эсвэл үхдэг. Өөрчлөлт заавал ирдэг
-

СЭДЭЛЖҮҮЛЭЛТИЙН КОУЧИНГ**ҮНДСЭН ХЭСЭГ****Экзистенциализмын онол.** (М. Хайдеггер, Ж. П. Сартр, Г. Мерсель)

Хүн бүр өөрийн оршихуй халдашгүй ертөнцтэй байх ба өөрөө өөрийгөө танин мэдэх, нээх замаар хөгжлийн эрх чөлөөг олно. Хүн өөрийгөө боловсруулах явцад түүний амьдралд хандах хандлага төлөвшинө. Бодит ертөнц нь хүний ахуйд оршдог бөгөөд хүрээлэн буй орчноосоо чөлөөт хөгжлийг олж авна.

Үүний тулд :

- Хүүхдийг тал бүрээс нь танин мэдэх
- Хөгжих орчин нөхцөл бүрдүүлэх
- Сургалт хүмүүжлийн ажлыг орчинтой нь амьдралтай нь холбон зохион байгуулах
- Хүүхдийн сайн тал дээр нь тулгуурлан албан бус харилцаа тогтоох нь чухал гэж үздэг.

ХЭРЭГЦЭЭНИЙ ШАТЛАЛЫН ОНОЛ

Хүн бүрт ямар нэг юм хэрэг болж, аль нэг зүйлээр дутаж гачигдаж байдаг. Энэ нь хэрэгцээний эх үүсвэр юм. Физиологи хийгээд оюун санааны хувьд гачигдсан зүйлээ тодорхой хэлбэрээ мэдрэхийг хэрэгцээ гэдэг. Хэрэгцээг сэтгэл ханамжаас салангад үзэх боломжгүй. Учир нь хэрэгцээний нөгөө талд сэтгэл ханамж байдаг. Тухайлбал аль нэг бараанаас

тодорхой сэтгэл ханамж авдаг учраас түүнийг худалдан авдаг.

Аливаа зүйлийн сэтгэл ханамж бий болгох чадвар нь түүний ашигтай тал юм. Ашигтай учраас хүн түүгээр гачигдаж уг гачигдалыг арилгахыг чухалчилдаг. Тэрхүү ашигтай бүхэн эрүүл мэндийг бэхжүүлж сэтгэл санааг өөд нь өргөн сайн сайхныг хүртээж байдаг. Сэтгэлзүйчид хэрэгцээг анхдагч ба хоёрдогч гэж ялган үздэг. Анхдагч - физиологийн шинжтэй бөгөөд төрмөл язгуур чанартай. Хоол хүнс, агаар, амралт гэх мэт хэрэгцээ багтдаг. Хоёрдогч - сэтгэлзүйн шинжтэй. Амжилт гаргах, хүндлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, мэдлэг чадвар, гэх мэтийн хэрэгцээ багтана. Хоёрдогч хэрэгцээ хүний амьдралын явцад туршлагын явцад буй болох тул анхдагч хэрэгцээг бодвол илүү олон янз өргөн хүрээтэй хувьсамтгай байна.

Менежментийн ухаанд нэрд гарсан судлаач Абрахам Маслоу хүний хэрэгцээ хүнийг идэвхжүүлэх нөлөөтэйг тогтоож түүнийг эрэмбэ дараалал бүхий таван шатлалтай гэжээ.

1. **Физиологийн хэрэгцээ амьд явахад зайлшгүй чухал.** Хооллох, хувцаслах, орон гэртэй байх, унтаж амрах, гэх мэт амьдралын нэн чухал хэрэгцээ үүнд хамаарна. Эдгээр хэрэгцээ хүний бие физиологиос үүдэлтэй төрөлх шинжтэй.

2. Аюулгүй байх, ирээдүйдээ итгэлтэй байх хэрэгцээ нь орчны зүгээс бие мах бодь, сэтгэл зүйд учруулах аюул заналаас хамгаалах, физиологийн хэрэгцээ ирээдүйд хангагдах итгэлтэй байх явдал юм. Ирээдүйд итгэлтэй байх хэрэгцээний илрэл бол даатгал, тэтгэвэр, тэтгэмж, баталгаатай, найдвартай ажлын байртай, ажиллах аятай нөхцөлөөр хангагдсан мэргэжил боловсролтой байх зэрэг болно.
3. Нийгмийн хэрэгцээ буюу оролцооны хэрэгцээ нь хэн нэгэнд хамаатайгаа мэдрэх, бусад хүмүүст хүн ёсоор үзэгдэхээ мэдрэх, дотночлох хайрлагдах, дэмжигдэхээ мэдрэх гэх мэт социаль харилцан үйлчлэлийн хэрэгцээ юм.
4. Хүндлүүлэх хэрэгцээнд өөрийгөө хүндлэх хувийн амжилт, мэдлэг чадвар, хүрээлэлдээ хүндлүүлэх хүлээн зөвшөөрөх хэрэгцээ багтана.
5. Өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ нь өөртөө байгаа хүч бололцоог борлуулах, хувь хүний хувьд өсөн дэвжих явдал юм.

Хугацааны тодорхой эгшин бүрт хамгийн чухал хамгийн хүчтэй байгаа хэрэгцээгээ хангах гэж хүмүүс тэмүүлдэг. Доод шатны хэрэгцээ хандагдсанаар хүний зан үйлийг тодорхойлогч хамгийн чухал хамгийн хүчтэй хэрэгцээ нь гарцаагүй дараагийн шатны хэрэгцээ болно.

Зөв хандлагатай байснаар өөрчилж болох зүйлс:



- Хандлага амьдралыг үзэх үзлийг өөрчилнө.
- Хандлага хүний харилцааг өөрчилнө
- *Линзний зарчим:* Бид ямар хүн бэ гэдгээс шалтгаалж бусдыг үзэх үзэл шийдэгддэг. Өөдрөг хүн бусдыг өөдрөгөөр л хардаг.
- *Зовж шаналах зарчим:* Бусдын сэтгэлийг шархлуулдаг хүн бусдаас сэтгэлийн шарх авах нь амархан
- *Лифтний зарчим:* Бид бусадтай харилцахдаа тэднийг өргөж бас буулгаж ч болно. Яах вэ гэдэг нь бидний зан байдлаас хамаарна
- *Сурч боловсрох зарчим:* Суралцах хандлагатай хүн уулзсан бүх хүнээс сурах юм байгаа гэж боддог. Тийм биш хүн бусдыг үл ойшоож тэднээс сурах юм байхгүй гэж боддог.

СУДАЛГААНЫ ЯВЦ, ҮР ДҮН




Хүүхэд гэдэг бол өөрийгөө хамгаалах чадвар чадамж нь хязгаарлагдмал, өөрөө бусдаас тусламж хүсч чаддаггүй, насанд хүрэгчдээс хамааралтай тул алтвас сөрөг хүчин зүйлд өртөмтгий байдаг. Иймээс хүүхдийг хүчирхийлэл, үл хайхрах байдал, мөлжлөг зэрэг хүүхдэд хор хохирол учруулах үйлдлээс хамгаалах зайлшгүй шаардлагатай. Хүүхдийн төрөлхийн хүсэл хэзээ хэрхэн хаана өөрчлөгдөж гажуудсаныг нарийвчлан тогтоох хэрэгтэй.

Судалгааны арга зүй: Анкет, ярилцлага, асуулгын, ажиглалт

Судалгааны объект: 15 -18 насны хүүхдүүд

Гэр бүлийн хүрээнд гардаг сөрөг зан үйлүүд

Төрж өссөн гэр бүлийн орчиндоо хүлээж авсан мянга мянган цагийн мэдээлэл бидэнд хавьгүй хүчтэй нөлөө үзүүлдэг. Хүүхдийн оюун санаанд эцэг эхийнх нь хэлсэн үгнээс 25 мянга гаруй цагийн мэдээлэл үлдсэн байдаг гэж эрдэмтэд үздэг. Хүүхэд ахуй үеэс насанд хүртэлээ бидний тээж явдаг энэ бүх мэдээлэл үг яриа үйлдэлд маань нөлөөлж байдаг. Өөрсдийгөө үзэх үзэл, мөн цаашлаад амьдралд хандах хандлага, ажил мэргэжлээ сонгох сонголт гээд бидний амьдралын салбар бүрд энэ нь аливаа зүйлд хандах хандлагад нөлөөлж байдаг. Нөхцөл байдал гэр бүлийн түүхээс хүүхдийн хандах хандлага төлөвшил шууд хамааралтай байдаг. Бидний оюун санаанд эцэг эхийн бичиж үлдээсэн сайн муу мэдээлэл аливаа бүхэн амьдралд зайлшгүй нөлөөлдөг. Энэ бичвэр болоод дурсамжийн агуулах маань хүүхдийн уураг тархи хэмээх ер бусын эрхтэнд хадаглагддаг. Бидний дотроос олон хүн эрүүл бус өсч өч төчнөөн зан авир, хандлага сэдлийг өөрсдийн өсөж хүмүүжсэн гэрээс өвлөж аван, тээж явсаар насанд хүрч амьдралд хөл тавьдаг. Амьдралын буруу хэв маяг нэг үе удмаас нөгөөд хэрхэн шилждэгийн олон жишээ өнөөгийн Монгол оронд маань маш их байна.



Нийгэм болон цахим орчинд гардаг сөрөг зан үйлүүд

Хүмүүний тархи гэдэг олон талаар хөгжсөн, дээд зэргийн боловсронгуй хогон овоо. Тооцоолон бодох дүн шинжилгээ хийх өндөр чадвартай хамгийн сүүлийн үеийн компьютерээр өвч бүрэн тоноглогдсон өрөө шиг 1 тэрбум гаруй мэдрэлийн эсээс бүрдсэн.

Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал



биш байж болох бүтээгдэхүүн болон үйлчилгээг сурталчилсан рекламны дуу эсвэл үг, бас ердийн дуу гээд нийт 500 гаруй зүйлийг долоо тутам ой тойндоо оруулдаг. Түүнчлэн хүүхдүүд ном сонин сэтгүүл телевизээс өдөрт 20-30 мянган үг санаж хоцордог. Энэ бүх мэдээлэл нь хүүхдүүдийн болон насанд хүрсэн хүмүүсийн амьдралд хандах хандлагад нөлөөлдөг.

Өөрийгөө цэгнэх / Гэр бүл, анги болон найз нөхдийн хүрээнд /

№	Өөрийгөө цэгнэх	Тийм	Үгүй	Заримдаа
1	Хамгийн сүүлд худлаа хэлсэнээ санаж байна уу?			
2	Ямар зорилгоор худлаа хэлсэн бэ?			
3	Үүнийгээ бусадтай хуваалцдаг уу?			
4	Бусдыг уурлуулахаас, гологдож хаягдахаас би үнэхээр айдаг уу?			
5	Эргэн тойрондоо байгаа хүмүүсийг аз жаргалтай байхад нь туслахын тулд би асар их үүрэг гүйцэтгэх ёстой мэт бодогддог			
6	Би хүмүүсийн дунд биеэ хэрхэн авч яваагаа мөн бусад хүмүүс миний дэргэд ямар зан байдал гаргаж байгааг алийг нь дээд зэргээр анзаарч мэддэг			
7	Өөрсдөө илэрхийлэхээс нь өмнө би бусдыг хэрэгцээг зөнгөөрөө мэддэг			
8	Би “үгүй” гэж хэлэхээс өөр аргагүй байсан ч тэгж хэлж чаддаггүй			
9	Би “тэгэх ёстой” “ингэх хэрэгтэй” гэсэн дааж дийлшгүй ачаа үүрч, тэр болгоноо биелүүлж чадахгүй бол өөрийгөө буруутгадаг			
10	Би зөрчилдөөнөөс зайлсхийдэг			
11	Бусад хүмүүс миний талаар юу гэж бодож байгаа бол гэхээс миний санаа зовдог			
12	Миний чухам хэн болохыг бусад хүмүүс мэдчих вий гэхээс би айдаг			
13	Би хэрээс хэтэрсэн олон зүйл амалдаг			

Нийт оноо: Гэртээ, Анги хамт олны дунд

0 — 4 оноо / Доод / Үргэлж хүмүүсийн таалалд нийцүүлж, тэднээс сайшаал магтаал сонсох гэж хичээдэг эрүүл бус хандлага танд бага байна. Тэгэхээр та өөртөө хэт их анхаарч, хувиа бодоод бусдад хангалттай санаа тавьдаггүй байж болох юм.


5 — 7 оноо / Дунд / Тодорхой зарим зүйл дээр та санаа их зовдог. Та өндөр оноо тавьсан асуултуудаа нягталж үзээд яг юун дээр асуудалтай байгаагаа тодорхойлохыг хичээ

8 — 11 оноо / Өндөр / Бусдын санаанд тааруулж, сайшаал магтаал хүлээх гэсэн таны хичээл зүтгэл бусадтай харилцах харилцааг чинь муутгаж, таныг сэтгэл дундуур болгож байна. Үүнийг дүгнэж цэгнэн өөрчлөх нь таны нэн тэргүүнд анхаарах зүйлийн нэг.

12 ба түүнээс дээш: / Хамгийн өндөр / Та бусадтай харилцах харилцаанаасаа маш их шарх авсан байна. Та үүнд нэн даруй, нухацтай анхаарч, дааж давшгүй сэтгэлийн дарамтанд орохоосоо өмнө туршлагатай найдвартай, эсвэл мэргэжлийн хүнээс тусламж авах хэрэгтэй.

Хандлага тодорхойлох

1. Та мөрөөдөл тэмүүлэлгүй болчихоод байна уу?
2. Та зожиг хүн үү?
3. Та ганцаараа байхыг хүсдэг үү?
4. Өөрт тулгарсан бэрхшээлийн төлөө та үргэлж бусдыг буруутгадаг уу?
5. Таны амьдралд дарамт учруулдаг хүмүүсээс та холдохын түүс болдог уу?
6. Та хичээлээсээ залхаж байна уу?
7. Яах учраа олохгүй үе таньд байдаг уу?



Хүүхдэд ноогддог түгээмэл гурван дүрийг бүтээхдээ ямар ямар үүрэг гүйцэлдүүлдэг болон үүнээс улбаалаад насанд хүрэхдээ ямар зан байдалтай болдогийг судалгааны үр дүнгээс харуулья

Бүтээх дүр	Хүүхэд ахуйд гүйцэтгэх үүрэг	Насанд хүрэх үеийн зан байдал
Баатар	- Сургуульдаа амжилттай сурах - Гэр бүлийнхээ нэр төрийг өргөх - Гэр бүлийнхээ муу муухайг хаацайлах - Эцэг эхийнхээ өмнөөс амжилтанд хүрэх	- Амжилтанд хэт шунах - Төгс болох гэж зүтгэх - Ямарваа зүйлд улайрч зүтгэх - Үнэнээ хэлж сул талаа бусдад харуулж бусадтай дотносохоос цэрвэдэг - Дотроо нэг л хоосон мэдрэмж тээх - Өөрийнхөөрөө байж үл чадах
Тэрслэгч	Өөрийгөө зовлонд унагаснаар гэр бүлийнхээ бусад гишүүдийн гаж буруу зан байдлаас анхаарлыг зориуд холдуулах	- Ажилд муу - Хариуцлагагүй - Идэвхгүй үлбэгэр - Ажил төрөлдөө ч бусадтай харилцахдаа ч тууштай үнэнч байж үл чадах - Донтолын яман нэгэн хэлбэрт автах
Асран халамжлагч	- Гэрбүлээ хамламжлах - Хэт өндөр хариуцлага үүрч өөрийгөө золиослож бүх юмыг хүндээр тусгаж авч шаргуу зүтгэх - Эцэг эхийнхээ байхгүй нэгний эсвэл хариуцлага хүлээдэггүй нэгнийх нь үүргийг гүйцэтгэх	- Хэт их үүрэг хүлээх - Бусдын өмнөөс хариуцлага хүлээх - Дүрэм журамд баригдмал - Ажлын хэнээтэй - Бүгдийг хянах зуршилтай - Тайван амар байж чаддаггүй - Байнга ядаргаанд ордог - Бусдад үйлчилж байгаадаа дургүй нь хүрдэг
Алиалагч	- Ханийн орлогч - Аав ээжийнхээ нэгнийг орлож сэтгэл санааг нь хуваалцдаг	- Зальтай - Бусдыг аргалах гэсэн

- Чи юу ч сурахгүй
- Чи өөрийгөө хэн гэж бодоов
- Чи ээжийгээ, аавыгаа яаж зовоож байгаагаа харичхдаа
- Нялх хүүхэд шиг байдгаа больж үз
- Яг одоо чамд уйлах шалтгаан байхгүй
- Чамайг би сайн хашраагаад өгье
- Чамд чаддаг зүйл гэж алга

- Чи яагаад бүх хичээлдээ сайн үнэлгээ аваагүй юм
- Чи яг (өөрийгөө тааламжгүй ханддаг төрөл садантайгаа зүйрлэх).... юмаа
- Чи яагаад тэр нь шиг байж болдоггүй юм.
- Чи ёстой тэнэг хүүхэд
- Чи яг хүүхэн шиг аашлах юмаа

Түүнчлэн бие махбодийн эсвэл бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан бол өөрийн үнэлэмжийг гутаах үгсийг ч бас сонсож байсан хэрэг. Хэрэв ийм зүйл байгаа бол!!!!

- Гомдол цөхрөл
- Уйтгар гуниг
- Өөртөө итгэлгүй байдал
- Хэт аминч
- Бусдыг шүүмжилдэг
- Бүхнийг өөрийнхөөрөө байлгах гэж оролдох
- Донтолтын эмгэг шинжүүд би болдог
- Ирээдүйд бусдыг дарангуйлагч
- Хэт бардам
- Хардалт энэ ёс суртахууны алдаа дутагдал бүхий хүн болдог

ДҮГНЭЛТ



Хүмүүсийн тааллыг эрэлхийлж амьдрах үед наад захын 5-н гол асуудлыг энд дурдъя:

- Үгүй гэж ер чаддаггүй. Бусдын таалалд нийцүүлэгч нь тэдний эрхшээлд ордог. Ингээд эцэстээ бие сэтгэлээрээ ядарч туйлдан уур цухлын уурхай болж хувирдаг

- Үйлдэл маань буруутгалаар удирдуулдаг. Үнэхээр хүссэн учраас биш, харин үр дагавараас нь айсандаа аливааг хийдэг. Бид тухайн зүйлийг заавал хийх ёстой юм шиг ханддаг агаад авах биш өөрөөсөө өгсөөр, дундарсаар байгаа юм шиг санагддаг

- Жинхэнэ мөн чанарынхаа төлөө магтаал сайшаал авдаггүй. Хүмүүсийн таалалд нийцүүлсэн үйлдэлээрээ олж авах гэж чармайж буй чухам тэр л сайшаал магтаалаа бид үнэн хэрэгтээ бодитоор олж авдаггүй. Аливааг бусдын таалалд нийцүүлэгч бидний үнэн дүр төрх хуурамч дүрний ард дарагддаг. Ийн халхалж далдалсан зүйлийг магтаж сайшаах боломжгүй шүү дээ

- Бид хүн хэмээх хосгүй бүтээл, давтагдашгүй нэгэн болох дотоод мөн чанараа бид олж нээж чаддаггүй.

- Өөр хэн нэгэн сайн хүн болох гэж хичээсээр амьдралаа үрдэг таалалд нийцүүлэх нь өөрийн итгэл үнэмшил үгүй болох юм.

Чухамдаа бидний хүн тус бүр олон нийтийн, бие хүний, хувь хүний гэсэн гурван хүрээнд харилцаа үүсгэдэг

1. Олон нийтийн хүрээ / танилын хүрээ /
2. Бие хүний хүрээ /найз нөхдийн хүрээ /
3. Хувь хүний хүрээ / итгэлт андын хүрээ /

1. Хүлээн зөвшөөрөх — Аливаа зүйлийг байгаа чигээр нь хүлээн авах
2. Итгэл үнэмшил - үнэт зүйл бий болгох
3. Эр зориг -
4. Шударга байдал
5. Хүлцэнгүй байдал
6. Хүмүүнлэг
7. Ахан дүүсийн нөхөрлөл
8. Тэвчээртэй байхад суралцах
9. Мэдлэг боловсрол
10. Үйлчилгээ — Бусдад туслах

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

ВЭБЭД-СУУРИЛСАН-СУРГАЛТААР-ДАМЖУУЛАН- АНГЛИ-ХЭЛНИЙ-ХИЧЭЭЛИЙН-СУРГАЛТЫН-ЧАНАРЫГ- САЙЖРУУЛАХ-АРГА-ЗАМ

МОНГОЛ ХЭЛНИЙ БАГШ: Н.АЛТАНСУВД
ХАРИЛЦААНЫ БАГШ: Д.БОЛОР-ЭРДЭНЭ



СЭДЭВ: XREADING ВЭБЭД СУУРИЛСАН СУРГАЛТААР ДАМЖУУЛАН АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН СУРГАЛТЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

ХУРААНГУЙ



Энэхүү судалгаа нь YUPK-ийн I курсийн англи хэлний хичээлийг xreading.com вэбэд тулгуурлан сургалтын чанарыг сайжруулахад явцад тулгарах бэрхшээл түүнийг даван туулах арга замыг судлах, мөн цахим сургалтын чанарыг сайжруулахын тулд тэдгээр бэрхшээлийг даван туулах боломж, шийдлүүдийг эрэлхийх зорилготой болно. Смит (2009)

сүүлийн үед дэлхий дахинд суралцагчдын анхаарлыг хамгийн ихээр татаж байгаа боловсролын нэг хэлбэр бол цахим сургалтын систем хэмээн тодорхойлжээ (Terry Smith, 2009). Цахим сургалт гэдэг нь гэрээсээ, ажил дээрээсээ, аялж байх үедээ гээд интернет холбогдсон ямар ч газраас өөрийн хүссэн цагтаа сургалтын платформд нэвтрэн суралцах боломжийг олгодог илүү уян хатан аргаар сургалцах үйл явцыг хэлнэ. (Bahman Arasteha, 2014) Боловсролын салбарт гарсан томоохон өөрчлөлтүүдийг нэг нь Вэбэд суурилсан сургалт зэрэг техник технологи, компьютер хэрэгслийг ашиглан дэлхийн өнцөг булан бүрт байгаа суралцагчдад боловсролын үйлчилгээг хүргэх явдал юм. Энэ төрлийн сургалт нь суралцагчдын мэдлэгийн түвшин, сургалтын үйл явц, чанарыг сайжруулах зорилгоор МХХТ-ийг сургалтанд ашигладаг. Энэ нь мэдлэгийн менежментийг цахим хэрэгсэлтэй хослуулан зохион байгуулдагаараа онцлогтой (Rosenberg. M.J, 2001). А. Релан, Б.Б.Гиллани нар вэбэд суурилсан сургалтыг вэб хэрэгсэл ашиглан бүтээлч, хамтарсан сургалтын орчинд танин мэдэхүйн сургалтын стратеги хэмээн тодорхойлсон байдаг (А. Realn and B.B.Gillani, 1997).

Судалгаанд YUPK-ийн НБДАХА-1а (28), Гоо засалч-1а (36) гэсэн 2 ангийн нийт 64 суралцагчид хамрагдсан бөгөөд тухайн НБДАХА-1а ангийн хичээлийг xreading.com вэбэд суурилсан цахим хэлбэрээр, Гоо Засалч-1а ангийн англи хэлний хичээлийг тухайн вэбийг ашиглаагүйгээр 2 сарын хугацаанд туршилтын сургалт зохион байгууллаа. Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар нийт 64 суралцагч хамрагдсан бөгөөд асуулгын үр дүн, дүнгийн үзүүлэлтийн харьцуулсан судалгаанд үнэлэлт дүгнэлт хийв. Судалгааны өгөгдлийг KoBoToolbox статистик судалгааны программаар боловсруулан дүн шинжилгээ хийсэн болно. Суралцагчдын онлайн сургалтын хандлага, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлийг олж авах зорилгоор корреляцийн дүн шинжилгээ хийсэн. Тоон өгөгдлийг дэмжих зорилгоор 2 багш дээр онлайнаар ярилцлага хийсэн болно. Чанарын судалгааны үр дүнг нарийвчилсан байдлаар анализ хийж нэгтгэлээ. Судалгааны үр дүнд дараах бэрхшээлүүд тулгарч буйг илрүүлэв. Үүнд:


Цахим орчинд суралцаж байгаа нөхцөл, сургалтыг зохион байгуулж буй багштай шууд холбогдох боломж хомс, сургалтын чанар муу, багш нарын онлайн сургалтанд хандах хандлага сөрөг, багаар ажиллах хамтран суралцах боломж хомс, сургалтын орчин платформын идэвхгүй

байдал, багш нарын мэдээлэл технологийн мэдлэг сул, техник технологийн хангамж бага, нийгмийн харилцаа бага зэрэг томоохон бэрхшээлүүд багтсан болохыг тогтоожээ. Харин xreading.com цахим вэбийг ашиглан зохион байгуулсан сургалт энгийн сургалттай харьцуулахад багштайгаа шууд холбогдож өөрийн уншсан ном, түүнийг ажилласан тест, бичсэн сэтгэгдэл зэрэгт хариу авах боломжтой, сургалтын чанарын хувьд суралцагчийн өөрийн оролцооноос цэвэр шалтгаалах учир багид хамааруулахгүй, онлайн суралцах хандлага өөрчлөгдөж илүү идэвхтэй, өрсөлдөөн ихтэй, өөрийгөө үнэлж, үнэлгээний үр дүнд урам зориг нэмэгдэх цаашид улам илүү идэвхийлэх боломж ихэссэн зэрэг үр дүн илэрсэн бөгөөд үүнээс гадна багаар ажиллах, хамтран суралцах боломж нээлттэй, сургалтын платформын идэвх тогтмол ахиж сургаг багш нарын хувьд ачаалал багасч мэдээлэл технологийн өргөн цар хүрээний мэдлэг шаардахгүй байгаагийн дээр техник технологийн хангамжийн хэрэгцээ бага зэрэг олон давуу талуудыг олж тогтоожээ.

Түлхүүр үгс. Цахим сургалт, Вэбэд суурилсан сургалт, Англи хэлний хичээлийг амжилттай зохион байгуулах аргай зүй, Гадаад хэлний хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах арга зүй

A WAY OF IMPROVE ENGLISH TRAINING'S VALIDITY WITH XREADING WEB-BASED LEARNING ONLINE ENVIROMENT

(Based on english training for first year students in Polytechnic College of Art Production)



ABSTRACT

The purpose of this study is to explore the obstacles to improving the quality of teaching based on xreading.com, a first-year English course at the Polytechnic College of Art Production, and to look for opportunities and solutions to improve the quality of e-learning.

Smith (2009) recently identified e-learning systems as one of the most popular forms of education around the world (Terry Smith, 2009). E-learning is a more flexible learning process that allows you to access the learning platform at time from anywhere connected to the Internet, such as at home, at work or while traveling. (Bahman Arasteha, 2014). One of the major changes in the education sector is the use of technology and computer tools, such as web-based learning, to provide educational services to students around the world. Information and communication technology is used for this type of training in order to improve the level of knowledge, learning process and quality of students. It is characterized by the combination of knowledge management with electronic tools (Rosenberg. M.J, 2001). A. Relan and B.B. Gillani define web-based learning as a cognitive learning strategy in a creative and collaborative learning environment using web tools (A. Realn and B.B. Gillani, 1997).

A total of 64 students from the Polytechnic College of Art Production were involved in the survey, including 2 secretaries-clerks-1a (28) and beauticians-1a (36). The secretary was in charge of the -1a class for xreading.com, and the beautician was in charge of the 1a class for 2 months without using the web. A total of 64 students were randomly selected for the survey, and a comparative study of the survey results and outcomes was evaluated. The survey data were processed and analyzed

using the KoBoToolbox statistical survey software. Correlation analysis was performed to identify factors influencing students' online learning attitudes and performance. Two teachers were interviewed online to support numerical data. The results of the qualitative research were analyzed and summarized in detail. The study found the following challenges. These include:

Conditions of online learning, lack of direct contact with the teacher who organizes the training, poor quality of training, negative attitude of teachers to online training, lack of opportunities for teamwork, inactivity of the learning environment platform, poor information technology knowledge of teachers, technical and technological low supply and little social interaction. However, the training organized using the xreading.com website allows you to connect directly with your teacher and get answers to your books, tests and comments. Compared to regular training, the quality of the training depends on the student's own participation. There is a lot of competition, self-esteem and motivation as a result of the assessment, as well as opportunities to be more active in the future. In addition to the fact that it is not required, the need for technical support has identified many advantages.

Keywords: E-learning, Web-based training, How to organize English courses successfully, How to organize online courses for foreign language.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ



Монголд төдийгүй дэлхий дахинд бүхий л шатны боловсролын байгууллагад сургалтын үйл ажиллагаагаа зохион байгуулахад мэдээлэл харилцаа холбооны технологийг ашиглахыг цаг үе шаардаж байгаа (Samir Abou El-Seoud, 2014) энэ үед бид 2010 оноос хойш цахим сургалтын хэлбэрийг нэвтрүүлж эхэлсэн. Тухайлбал Зайн сургалтын үндэсний хөтөлбөр-2010 хэрэгжүүлж эхэлсэн ч өнөөг хүртэл үр өгөөжөө төдийлөн өгөөгүй удааширалтай байгаа билээ.

Боловсрол бол хүн амынхаа хөгжил, хязгааргүй боломжийг ашиглан нийгэм эдийн засгийн салбарт томоохон өөрчлөлтийг бий болгох чухал салбар юм (Н.Оюунчимэг, 2013). Тиймээс ч бүхий л салбарт өөрчлөлт, шинэчлэл, хөгжлийг бий болгох Монгол улсын 2020, 2021 оны хэтийн зорилго бол Мэдээлэл харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх явдал. Энэхүү хэтийн зорилгын хүрээнд МХХТ-ийг боловсролд ашиглах нь үр дүнгийн биелэлтийг эерэгээр харуулах хөшүүрэг болно.

Мөн Монголд үйл ажиллагаа явуулж буй МБС-т цахим сургалтын тогтолцоо төдийлөн хэвшиж тогтоогүй, гадаад хэлний сургалтын арга зүй чанарыг сайжруулах, техник технологийг сургалтанд ашиглах тур дундаа гадаад хэл сурахад зориулсан вэб сайтыг сургалтандаа нэвтрүүлэх тал дээр мэдээлэл хомс байсаар буй нь нууц биш. Манай орон шиг тархмал суурьшилтай, хөдөө орон нутгаас элссэн суралцагчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж буй зэрэг нь энэхүү судалгааны ажлын бичих үндэслэл болсон.

1.2 СУДАЛГААНЫ ШИНЭЛЭГ ТАЛ

Дэлхий дахинд цар тахал дэгдэж сургалтын үйл ажиллагаа явуулдаг бүхий л байгууллагууд цахим сургалтын хэлбэрт шилжихээс өөр аргагүй нөхцөл байдал үүссэнээр энэ хэлбэрийн сургалт манай оронд төдийгүй дэлхий дахины боловсролын салбарт хүчээр нэвтэрч байгаа нь нэг талаас сайшаалтай ч нөгөө талаас сургалтын чанарын асуудалд анхаарах хэрэгтэй болоод байна (Parfait, 2020).



Ялангуяа Мэргэжлийн боловсролын салбарт олон нийтэд чиглэсэн вэбэд суурилсан сургалт байдаггүй. Хэд хэдэн коллежууд энэ төрлийн сургалтыг ашиглаж эхэлсэн боловч энэ нь олон нийтэд тэр бүр хүртээмжтэй болоогүй, вэбийн бүтэц, багтаамжийн асуудал, хэрэглэгчдийн сэтгэл ханамж сул, багш нар болоод оюутнуудын МХХТ-ийн мэдлэг бага зэргээс үүдэн үр дүнгээ өгөхгүй байна.

Тиймээс МБС-т тэр дундаа англи хэлний хичээлийг цахим хэлбэрээр хөгжүүлэхэд энэхүү вэбэд суурилсан сургалтыг зохион байгуулах ажлын хэрэгцээ шаардлага нийгэмд хэдийнээ үүсч эрэлт бий болсоор байгаад үндэслэн энэхүү судалгааны ажлыг хийлээ.

1.3 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО



Энэхүү судалгааны зорилго нь Монголын мэргэжлийн боловсролын салбарын суралцагчдын англи хэлний мэдлэгийг сайжруулах, цахим сургалтыг амжилттай зохион байгуулах, сургалтын явцад тулгарах бэрхшээл, түүнийг даван туулах, багасгах арга замыг эрэлхийхэд оршино.

1.4 СУДАЛГААНЫ ЗОРИЛТ

Дээрх зорилгын хүрээнд дараах гурван зорилт бүхий алхамуудыг тодорхойлов.

1. ҮУПК-ийн НБДАХА-1а ангийн суралцагчдын англи хэлний хичээлийг xreading.com вэбэд суурилсан сургалтаар
2. Тус сургуулийн Гоо засалч 1а ангийн англи хэлний хичээлийг энгийн цахим хэлбэрээр
3. Хоёр ангийн сургалтанд хамрагдах байдал, хандлага, сэтгэл ханамж, сургалтын чанарын үр дүн зэрэгт анализ хийх

1.5 СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ



Нэгдүгээрт, энэхүү судалгаа нь англи хэлний хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулахад тулгарах бэрхшээлийн тухай судалгаа вэбэд суурилсан сургалтаар дамжуулан сургах явцад суралцагчдын гүйцэтгэл, үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодрулахад туслах юм. Мөн энэхүү сургалтанд хамрагдсан суралцагчд маанв цааши өөрөө бие даан суралцах арга барилыг эзэмшиж тухайн вэбээр дамжуулан англи хэлний мэдлэгээ өөрийн хүссэн түвшинд хүргэх, хямд зардлаар их зүйлийг мэдэж авч, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлж байгаагаарай ихээхэн ач холбогдолтой болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА



Судалгааны асуулгын өгөгдлийг цуглуулахад тоон дүн шинжилгээ хийх, фокус бүлгийн ярилцлагын үр дүнг нэгтгэхэд тухайн нөхцөл байдал тоон бус өгөгдлийг боловсруулахад илүү үр дүнтэй (Collis, 2003), тоон бус өгөгдлийг ажиглалт болоод ярилцлага хийх замаар цуглуулдаг (Babbie, 2014.) чанарын дүн шинжилгээ хийх аргыг хослуулан холимог судалгааны аргыг ашиглав. Асуулгыг гурван үе төрлөөр боловсруулан авч үр

дүнг нэгтгэсэн.

1. Цахим сургалтын явцад илрэх суралцагчдын хандлага, идэвх оролцоо
2. Суралцагчдын сэтгэл ханамжийн байдал, цаашид бие суралцах боломж нөхцөл
3. Суралцагчдын сурлагын чанарын ахиц

Судалгаанд ҮУПК-ийн 2 ангийн нийт 64 хамрагдсан бөгөөд НБДАХА-1а ангий 28 суралцагч xreading.com вэбийн сургалтанд, Гоо Засалч-1а ангийн 36 суралцагч туршилтын бүлгийн сургалтанд хамрагдсан болно. Судалгаанд ҮУПК-ийн НБДАХА-1а (28), Гоо засалч-1а (36) гэсэн 2 ангийн нийт 64 суралцагчид хамрагдсан бөгөөд тухайн НБДАХА-1а ангийн хичээлийг xreading.com вэбэд суурилсан цахим хэлбэрээр, Гоо Засалч-1а ангийн англи хэлний хичээлийг тухайн вэбийг ашиглаагүйгээр 2 сарын хугацаанд туршилтын сургалт зохион байгууллаа. Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар нийт 64 суралцагч хамрагдсан бөгөөд асуулгын үр дүн, дүнгийн үзүүлэлтийн харьцуулсан судалгаанд үнэлэлт дүгнэлт хийв. Судалгааны өгөгдлийг KoBoToolbox статистик судалгааны программаар боловсруулан дүн шинжилгээ хийсэн болно. Суралцагчдын онлайн сургалтын хандлага, гүйцэтгэлд нөлөөлж буй

хүчин зүйлийг олж авах зорилгоор корреляцийн дүн шинжилгээ хийсэн. Тоон өгөгдлийг дэмжих зорилгоор 2 багш дээр онлайнаар ярилцлага хийсэн болно.

Судалгааны өгөгдлийг SPSS статистик программ, KoBoToolbox программаар боловсруулан дүн шинжилгээ хийсэн болно. Багш нарын онлайн сургалтын хандлага, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлийг олж авах зорилгоор корреляцийн дүн шинжилгээ хийсэн. Тоон өгөгдлийг дэмжих зорилгоор 4 багш дээр онлайнаар ярилцлага хийсэн болно. Чанарын судалгааны үр дүнг нарийвчилсан байдлаар анализ хийж нэгтгэлээ. Судалгааны үр дүнд дараах бэрхшээлүүд тулгарч буйг илрүүлэв. Үүнд:

Цахим орчинд суралцаж байгаа нөхцөл, сургалтыг зохион байгуулж буй багштай шууд холбогдох боломж хомс, сургалтын чанар муу, суралцагчдын онлайн сургалтанд хандах хандлага сөрөг, багаар ажиллах хамтран суралцах боломж хомс, сургалтын орчин платформын идэвхгүй байдал, багш нарын мэдээлэл технологийн мэдлэг сул, техник технологийн хангамж бага, нийгмийн харилцаа бага зэрэг томоохон бэрхшээлүүд багтсан болохыг тогтоожээ. Харин xreading.com цахим вэбийг ашиглан зохион байгуулсан сургалт энгийн сургалттай харьцуулахад багштайгаа шууд холбогдож өөрийн уншсан ном, түүнийг ажилласан тест, бичсэн сэтгэгдэл зэрэгт хариу авах боломжтой, сургалтын чанарын хувьд суралцагчийн өөрийн оролцооноос цэвэр шалтгаалах учир багид хамааруулахгүй, онлайн суралцах хандлага өөрчлөгдөж илүү идэвхтэй, өрсөлдөөн ихтэй, өөрийгөө үнэлж, үнэлгээний үр дүнд урам зориг нэмэгдэх цаашид улам илүү идэвхийлэх боломж ихэссэн зэрэг үр дүн илэрсэн бөгөөд үүнээс гадна багаар ажиллах, хамтран суралцах боломж нээлттэй, сургалтын платформын идэвх тогтмол ахиж сургаг багш нарын хувьд ачаалал багасч мэдээлэл технологийн өргөн цар хүрээний мэдлэг шаардахгүй байгаагийн дээр техник технологийн хангамжийн хэрэгцээ бага зэрэг олон давуу талуудыг олж тогтоожээ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН



Судалгаанд ҮУПК-ийн 2 ангийн нийт 64 хамрагдсан бөгөөд НБДАХА-1а ангий 28 суралцагч xreading.com вэбийн сургалтанд, Гоо Засалч-1а ангийн 36 суралцагч туршилтын бүлгийн сургалтанд хамрагдсан болно. Доорх хүснэгтэнд судалгаанд хамрагдсан 2 ангийн суралцагчдын тоог харуулав. Судалгааны чанарыг сайжруулах үүднээс онлайн сургалт зохион байгуулахад оролцсон 2 багшаас ярилцага авч үр дүнг нэгтгэв.

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан 2 ангийн суралцагчдын тоо

Анги	Суралцагчдын тоо
НБДАХА-1а	28
Гоо Засалч-1а	46
Нийт	64

Вэбэд суурилсан сургалтыг удирдаж явуулсан 2 багшийн ажлын туршлагыг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Ярилцлагын асуулгад оролцсон 2 багшийн дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчид	Хичээл орсон анги	Ажилласан жил
Багш 1	Гоо засалч 1а	11
Багш 2	НБДАХА-1а	6

Хүснэгт 3. Асуулгад оролцсон суралцагчдын хүйсийн хуваарилалт

	Тоогоор	хувиар
Эрэгтэй	3	4.6
Эмэгтэй	61	95.4
Нийт	64	100.0

А.Пирсоны корреляцийн дүн шинжилгээ хийж онлайн багшийн гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлүүд болон сургалтанд хамрагдаж буй багш нарын гүйцэтгэлийн оноо хоорондын хамаарал байгаа эсэхийг судлав.

Хүснэгт 4. Онлайн багш ба суралцагчдын гүйцэтгэл хоорондын хамаарал

Хувьсагчууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Багшийн сургалтын үйл явц (GPA)	1										
Суралцагчийн цахим орчинд сурах хандлага	.99**	1									
Компьютер мэдлэг	.88**	.98*	1								
Багшийн харилцаа зан байдал	.98**	.104**	.91**	1							
Багшийн оролцоо	.97**	.108**	.101*	.102**	1						
Багшийн цаг хуваарилалтад өгсөн санал хүсэлт	.89**	.97*	.87**	.92*	.95**	1					
Сургалтын идэвхтэй орчин	.95**	.104**	.93**	.99*	.101*	.92*	1				
Хамтын ажиллагаа	.92**	.100**	.89**	.95*	.97**	.87*	.96*	1			
Сургалтын уян хатан байдал	.95**	.104**	.96**	.99*	.103*	.91*	.100**	.96*	1		
Сургалтын чанар	.103**	.104**	.94**	.101**	.102*	.93*	.99*	.95*	.99*	1	
Техникийн нөхцөл	.73**	.81*	.81**	.75*	.82**	.70*	.76*	.89*	.77*	.76*	1

** . Корреляци нь 0.01 түвшинд (2-tailed) ач холбогдолтой.


Хоёр багшаас цахим сургалтаар англи хэл сурахад суралцагчдад тулгарч буй бэрхшээлийн тухай асуулгыг ярилцлагын хэлбэрээр авахад гарсан үр дүнг дараах байдлаар харуулав. Багш 1 вэбэд суурилсан сургалтыг зохион байгуулсан бол Багш 2 цахим сургалтын энгийн хэлбэрээр сургалтаа явуулсан болно.

Хүснэгт 5. Вэбэд суурилсан сургалтын явцад суралцагчдад тулгарч буй бэрхшээлүүд

Тулгарч буй бэрхшээл	Сургагч багш нар
Багшийн харилцаа зан байдал	Ins 2
Багшийн цагийн хуваарилалт	Ins 1, Ins 2
Нийгмийн харилцаа	Ins 1
Компьютерын мэдлэг сул	Ins 2
Техникийн асуудал	Ins 2
Хамтран ажиллаж буй байдал	Ins 2

Хоёр сарын турш хичээлийн хөтөлбөрийн дагуу ижил сэдвийн хүрээнд цахим сургалт явуулж үнэлгээний оноогоор суралцагчдын дүнг харьцуулж үзвэл дараах байдлаар харагдаж байна. Гоо засалч 1a ангийн 36 суралцагчдын дүнг нэгтгэн ангийн дундаж оноог Vocabulary, Grammar, Writing, Reading, Speaking, middle term exam гэсэн дөрвөн шалгуурын хүрээнд үнэллээ.

Диаграмм 1. Гоо засалч 1a ангийн суралцагчдын үнэлгээний дундаж үзүүлэлт



ДҮГНЭЛТ



Энэхүү судалгаа нь YUPK-ийн суралцагчдын англи хэлний мэдлэгийг вэбэд суурилсан сургалтаар дамжуулан сайжруулах явцад тулгарсан бэрхшээлийг судлах, мөн гадаад хэлний хичээлийг цахим хэлбэрээр зохион байгуулах шинэлэг арга барилыг турших, сургалтын чанарыг сайжруулах арга замыг эрэлхийлсэн болно.

Судалгаанд YUPK-ийн NBDAHA-1a (28), Гоо засалч-1a (36) гэсэн 2 ангийн нийт 64 суралцагчид хамрагдсан бөгөөд тухайн NBDAHA-1a ангийн хичээлийг xreading.com вэбэд суурилсан цахим хэлбэрээр, Гоо Засалч-1a ангийн англи хэлний хичээлийг тухайн вэбийг ашиглаагүйгээр 2 сарын хугацаанд туршилтын

сургалт зохион байгууллаа. Судалгаанд санамсаргүй түүврийн аргаар нийт 64 суралцагч хамрагдсан бөгөөд асуулгын үр дүн, дүнгийн үзүүлэлтийн харьцуулсан судалгаанд үнэлэлт дүгнэлт хийв. Судалгааны өгөгдлийг KoBoToolbox статистик судалгааны программаар боловсруулан дүн шинжилгээ хийсэн болно. Суралцагчдын онлайн сургалтын хандлага, гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлийг олж авах зорилгоор корреляцийн дүн шинжилгээ хийсэн. Тоон өгөгдлийг дэмжих зорилгоор 2 багш дээр онлайнгаар ярилцлага хийсэн болно. Чанарын судалгааны үр дүнг нарийвчилсан байдлаар анализ хийж нэгтгэлээ. Судалгааны үр дүнд дараах бэрхшээлүүд тулгарч буйг илрүүлэв. Үүнд:


Цахим орчинд суралцаж байгаа нөхцөл, сургалтыг зохион байгуулж буй багштай шууд холбогдох боломж хомс, сургалтын чанар муу, багш нарын онлайн сургалтанд хандах хандлага сөрөг, багаар ажиллах хамтран суралцах боломж хомс, сургалтын орчин платформын идэвхгүй байдал, багш нарын мэдээлэл технологийн мэдлэг сул, техник технологийн хангамж бага, нийгмийн харилцаа бага зэрэг томоохон бэрхшээлүүд багтсан болохыг тогтоожээ. Харин xreading.com цахим вэбийг ашиглан зохион байгуулсан сургалт энгийн сургалттай харьцуулахад багштайгаа шууд холбогдож өөрийн уншсан ном, түүнийг ажилласан тест, бичсэн сэтгэгдэл зэрэгт хариу авах боломжтой, сургалтын чанарын хувьд суралцагчийн өөрийн оролцооноос цэвэр шалтгаалах учир багшид хамааруулахгүй, онлайн суралцах хандлага өөрчлөгдөж илүү идэвхтэй, өрсөлдөөн ихтэй, өөрийгөө үнэлж, үнэлгээний үр дүнд урам зориг нэмэгдэх цаашид улам илүү идэвхийлэх боломж ихэссэн зэрэг үр дүн илэрсэн бөгөөд үүнээс гадна багаар ажиллах, хамтран суралцах боломж нээлттэй, сургалтын платформын идэвх тогтмол ахиж сургаг багш нарын хувьд ачаалал багасч мэдээлэл технологийн өргөн цар хүрээний мэдлэг шаардахгүй байгаагийн дээр техник технологийн хангамжийн хэрэгцээ бага зэрэг олон давуу талуудыг олж тогтоожээ.

Цахим сургалтын чанарыг сайжруулах, вэбэд суурилсан сургалтаар дамжуулан суралцагчдын сургалтын явцад тулгарч буй бэрхшээлүүдийн нөлөөг бууруулах, багасгах зорилгоор гадаад хэл тэр дундаа англи хэлийг сурах хийгээд сургахад дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна.

Тухайн сурч буй хэл дээр суралцагчдын түвшинд тохирсон ном унших дадлыг хэвшүүлэх, Лингорс олон улсын компанитай хамтран ажиллаж xreading.com вэб сайтыг сургалтын хөтөлбөрт албан ёсоор нэвтрүүлж, суралцагчдын нэвтрэх эрхийг сургуулиуд төлбөрийн системд суутган авч нийтээр хэрэгжүүлэх, вэб сайтын хандалт, суралцагчдын ном унших идэвх сонирхолыг нэмэгдүүлэх зорилгоор уншлагын марафоныг тогтмол зохион байгуулж шалгарсан суралцагчдыг тогтмол урамшуулж байх, багийн ажиллагаа, хамтын хөдөлмөр, оролцоо, хариуцлагатай байдлыг бий болгох, нэмэгдүүлэх зорилгоор багийн уншлагын марафоныг тогтмол зохион байгуулах, түүнд урамшуулах, идэвхтэй оролцсон, удирдсан багш нараа сургуулийн төдийгүй цаашлаад үндэсний хэмжээнд алдаршуулах зэрэг болно.

Цаашид энэхүү вэбэд суурилсан сургалтаа улам бүр өргөжүүлж ҮУПК төдийгүй МБС-ын бүхий л байгууллагуудад таниулж зөвхөн суралцагчдад бус багш нарынхаа хэлний мэдлэгийг сайжруулахад ашиглах бүрэн боломжтой бөгөөд энэ төрлийн сургалтаа эхлүүлэхээр хэдийнээ төлөвлөөд байна. Мөн энэ удаагийн судалгаа маань сургалтанд хамрагдсан суралцагчдын талас харсан бол дараа дараагийн судалгааны ажил маань сургалт зохион байгуулж буй багшийн зүгээс дээрх вэбийн сэтгэл ханамж, суралцах арга барил дүгнэх журам зэрэгт судалгааныхаа цар хүрээг өргөжүүлж үндэсний хэмжээнд өрнүүлэн судлах нь дараа дараагийн судалгааны ажлын маань үндсэн зорилго оршино. Манай орны МБС-т энэ төрлийн судалгааны ажил дөнгөж эхэлж байгаа учир багш судлаач бид бүхний хийх ажил нэн их байгааг энэхүү судалгааг хийж байх явцад олж харсан болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ



Н.Оюунчимэг. (2013). *Багш өөрийгөө хөгжүүлэх нь*. Улаанбаатар.

Б.Мөнгөнцэцэг. (2015). *Багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих нь*. Улаанбаатар.

A. Realn and B.B.Gillani. (1997). *Web-Based instruction and traditional classroom: Similarities and differences*.

Babbie, E. (2014.). *The Basics of Social Research (6th ed.)*. Wadsworth Cengage, . Belmont, California.

Bahman Arasteha, S. P. (2014). *“Highly Available and Dependable E-Learning Services Using Grid System”*. .

Collis, J. &. (2003). *A practical guide for undergraduate and postgraduate students*, . Palgrave Macmillan. Basingstoke: Business Research.

Parfait, N. (2020). *Students' challenges in Asynchronous E-Learning in Rwandan Higher Education*. Wuhan, China.

Rosenberg. M.J. (2001). *“E-learning strategies for delivering knowledge in the digital age”*.

Samir Abou El-Seoud, I. A.-E. (2014). *A Research Study on the Effect of E-Learning on Higher Education*. E-Learning and students' Motivation.

Terry Smith, L. R. (2009). *“E-Learning and Constructivism: From Theory to Application”*. USA: Macon State College, Macon, Georgia.

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

“КАРБОН ХҮЧИЛ” СЭДВЭЭР ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙСЭН НЬ

ХИМИЙН БАГШ: ДА. СОЛОНГО
ХИМИЙН БАГШ: Б.МЯДАГМАА



СЭДЭВ: “КАРБОН ХҮЧИЛ” СЭДВЭЭР ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА ХИЙСЭН НЬ

ХУРААНГУЙ



Химийн шинжлэх ухаан нь суралцагчдад ахуй амьдралын болон шинжлэх ухаан, технологийн мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад химийн хэл, арга, сэтгэлгээгээр хандах, цаашид суралцах шаардлагатай мэдлэг, чадвар

эзэмшүүлэх зорилготой. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сурагчийг тодорхой суралцахуйн зорилтууд руу чиглүүлж, дэмжих зорилготой агуулгын уялдаа холбоо, сурагчийн эзэмших мэдлэг, чадварыг тооцон үзэж сайтар, нягт нямбай боловсруулсан нэгж хичээлийг боловсруулах явдал юм. Нэгж хичээлийг боловсруулахад хэрэглэгдэх арга, хэрэглэгдэхүүн, суралцагчийн нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ, мэргэжлийн хичээлийн хоорондын уялдаа холбоог тогтоож хичээлийн судалгаанд үндэслэн жил бүр нэмж баяжуулан ашиглаж байна. Тус төлөвлөлтийг 2011, 2018 оны Улс, Бүсийн заах аргын уралдаанд анх төлөвлөн боловсруулж Улсад I байр, бүсэд II байр тус тус эзлэж байсан бөгөөд жил бүр баяжуулан туршиж байгаа хичээл болно.

Түлхүүр үгс: Асуудал шийдвэрлэх сургалтын арга зүй (Problem-Based Learning - PBL)

Үндэслэл

Суралцахуйн зорилт нь сурагч юуг сурах гэж байгаагаар илэрхийлэгдэх боловч нөгөө талаас багш юуг заахаар төлөвлөж байгааг харуулдаг. Хичээлийг төлөвлөхдөө Бид юуг заах вэ?, Хэрхэн заах вэ? Хэрхэн зохион байгуулах вэ? Хэрхэн үнэлэх вэ? Гэсэн 4 чиглүүлэх үйлээр химийн мэдлэгийг тухайн түвшний суралцахуйн үр дүнг томъёолж хэрэглэгдэхүүн, хэрэглэх сургалтын аргыг сонгож, сурагчдын амьдрал орчноос олж авсан мэдлэгт гарч болох алдааг тооцоолон боловсруулдаг. Энэхүү илтгэлдээ 2011 он болон 2018 онд Улс, Бүсийн заах аргын уралдаанд оролцож байсан МБС-ын II ангийн суралцагчдын судлах химийн хичээлийн “Карбон хүчил” сэдвийг заахдаа ашигласан арга, хэрэглэгдэхүүн, нэгж хичээлийн төлөвлөлийг туршсан үр дүнг орууллаа. Улс бүсийн заах аргын уралдаанд оролцогч нь тухайн ангийн суралцагчийн химийн мэдлэгийн түвшин, онцлог байдал, мэргэжлийн хоорондын интеграцийг судлах боломжгүй байдаг. Иймд сэдэлжүүлэх аргыг хичээлийн эхэнд тухайн ангийн сурагчидтай танилцах, суралцахуйн зорилго агуулгаас хамаарч мэдлэг бүтээх, туршилтын ажил гүйцэтгэх, үр дүнг тайлбарлах учир шалтгааныг ойлгох чадварт суралцах, ахуй нөхцөлд зөв мэдлэгийг хэрэглэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн байхаар төлөвлөсөн.

Ахлах ангийн суралцагчдад химийн хичээлийг заахдаа асуудал шийдвэрлэх аргыг голчлон хэрэглэдэг. Сургалтанд асуудал шийдвэрлэх аргыг хэрэглэх нь багшаас их ур чадвар шаардана. Сурагчийн тухайн үеийн мэдлэгийн түвшин, онол-практикийн шинэ баримтыг тайлбарлахад хүрэлцэхгүй зөрчил үүсдэг. Тэрхүү зөрчилд түшиглэн асуудал дэвшүүлэн учир шалтгааныг химийн онолын үүднээс туршин тайлбарлахад чиглэсэн сургалт явагддаг.




Хичээлийн эхэнд: сэдэлжүүлэх арга хэрэглэхдээ тухайн судлах хичээлийн амьдрал орчноос олж авсан мэдлэгт анализ хийх зорилготой дараах асуултыг асуух

- Зурагт үзүүлсэн бүтээгдэхүүнийг нэрлэнэ үү?
- Органик ямар химийн бодис нэгэн зэрэг агуулдаг бол?


Хичээлийн явцад: 1. Шинэ мэдлэгийг эрэл олох хүсэл эрмэлзэл төрөх үеэр үүсэх асуудлын тохироог бүрдүүлэхийн тулд асуудалд хариулж болох “**Хими бидний амьдрал**” сэдэвт мэдээллийг агуулсан сонин хэлбэрээр боловсруулсан хичээлийн хэрэглэгдэхүүнийг сургалтанд ашиглаж оюун дүгнэлт хийлгэн органик Карбон хүчил гэх химийн нэршлийг баримжаалах дасгал ажиллуулах явцдаа:

- ✓ Эхэд ямар, ямар химийн нэр томъёо байна вэ?
- ✓ Нэр томъёо дахь нийтлэг химийн нэрийг олж судлах хичээлийг тодорхойлно уу

Үүн дээр үндэслээд ажлын хуудас ашиглаж **хичээлийн сэдэв** болон судлах **Карбон хүчлийн функциональ** бүлэг нэршил **гомологи эгнээний гишүүдийг** суралцагч тодорхойлох дасгал ажил хийлгэнэ.



Ажлын хуудас:
Карбон хүчил үүсэх механизмыг сайтар ажиглана уу



Алхам №1
Карбон хүчлийн гомолог эгнээг гүйцэтгэн бичнэ үү

№	Томъёо	Түүхэн нэршил	Олон улсын нэршил
1	$\text{H}-\text{C}(=\text{O})-\text{OH}$	Шоргоолжийн хүчил	Метаны хүчил
2	$\text{CH}_3-\text{C}(=\text{O})-\text{OH}$	Цуугийн хүчил	Этаны хүчил
3	$\text{CH}_3-\text{CH}_2-\text{C}(=\text{O})-\text{OH}$	Пропионы хүчил	Пропаны хүчил
4	?	Госны хүчил	Бутаны хүчил
5	?	Бамбайн хүчил	Пентаны хүчил




Онолын тайлбар шаардсан үзэгдэл, баримтуудтай учрах үед үүсэх асуудлыг тохирох

Карбон хүчлийн шинж чанар туршилт гүйцэтгэх явцад суралцагчдад онолын тайлбар шаардсан үзэгдэл ажиглагдана. Энэ үед хичээлийг багш төлөвлөхдөө алхамчлсан байдлаар агуулгыг удирдан чиглүүлнэ.


Тухайлбал: Карбон хүчил давстай урвалд орж шинэ давс ба ус нүүрсхүчлийн хий үүсгэж байгааг туршиж учир шалтгааныг тайлбарлана. Энэ үед суралцагчдын лабораторийн туршилт үйлдэх чадварыг судлахад:



Гал унтраагч хийцгээе



Бомболог хийлцгээе



Алхам №3

Хэрэглэгдэхүүн: Цуу, хүнсний сод
Хувиар сав, гялгар уут, халаас, лаа, шүдэнэ

Ажлын явц:
1. Лаа асаагаарай. Дараагаар нь жижигхэн шилэн савны тавны нэгээр нь цуу хүчил (этаны хүчил) хийгээрэй.
2. Гялгар уут ашиглан шилэн савруу хоолны хайбаганы хагасар сод хийгээрэй. Уусмал хоосрох болно.
3. Шилгэнийг гадагш асгалгүйгээр шилэн савыг хажуулуулж налуулаад лааны дээр баригтун.
4. Галын дэл жаж байна?
5. Гал яагаад унтрав?



Санамж

Цууны хүчил


Идэмхий
 $d=1,049 \text{ г см}^3$
Шатамхай
 CH_3COOH

Этаны хүчлийн усан уусмал нь шатамхай, идэмхий, арьсан дээр дусвал цэврүү үүсгэдэг. Этаны хүчилд хордвол ханнагдах, амьсгал боогдох, амьсгалын замын хүнд хэлбэрийн почролд орж нүд улайх, загатлах шинж тэмдэг илэрдэг. Лабораторид 70% концентрацитай хүчлийг шингэрүүлэн хэрэглэдэг. Цууны хүчилтэй ажиллахдаа бээлий, нүдний шилтэй ажилладаг.

Алхам №2 Физик шинж
тодорхойлох


№	Карбон хүчил	Өнгө	Үнэр
1	Цуугийн хүчил		
2	Лимоны хүчил		
3	Алимны хүчил		

СУРАЛЦАГЧДЫН ТУРШИЛТ ҮЙЛДЭХ ЧАДВАР



Суралцагчдын таамаглал дэвшүүлэх чадвар 10 хувь байгаа нь онолын хувьд баримжаалах чадвар туршилтын явц дахь явагдах урвалыг тэгшитгэлээр илэрхийлэх чадвар бага байв. Лабораторид аюулгүй ажиллагааны заавартай бүгд танилцсан боловч мөрдөх, хэмжилт хийх, бодистой харьцах байдал дутмаг байгаа нь хангалттай туршилт үйлдэхгүй байгаатай холбоотой. Хэрэглэгдхүүнтэй ажиллах чадвар дунджаас дээгүүр байлаа. Төлөвлөгөөний дагуу туршилтыг гүйцэтгэх чадвар сайжруулах шаардлагатай

2. Таамаглал дэвшүүлэн урьдчилсан дүгнэлт хийж, түүнийгээ туршлагаар шалгахад үүсэх асуудлын тохироонд туршилтын үр дүнг дүгнэх онолын үүднээс тайлбарлах, шинэ нөхцөлд /гарын доор материал ашиглан гал унтраагуур хийх/ батлах чадварыг сайжруулах дасгал ажлуулах
3. Бүтээлч чанартай бодлогыг бодох үед үүсэх асуудлын тохироог бүрдүүлэхдээ бид байцааны салат хийхдээ уксус ашигладаг уу? Гэтэл дараах мэдээлийг ашиглаад зөв дадал хэвшүүлэх судалгаат зөвлөмж боловсруулах чиглэл өгнө.



Гал унтраагуур

Дээрх мэдээлэлд анализ хийж эрүүл аж төрөх зөвлөмж бичих
даалгаварыг онолын мэдлэгээ ашиглаж бичих



ДҮГНЭЛТ

- 
1. Ахлах ангийн суралцагчдад химийн мэдлэг олгохдоо асуудал шийдвэрлэх сургалтын арга ашиглах
 2. Хичээлийг төлөвлөхдөө агуулыг алхамчлан төлөвлөх
3. Багш өмнөх мэдлэгийг сэргээн сануулахдаа **Check list** аргыг ашиглан систем дэс дараалалтай чиглүүлэх боломжтой.
 4. Амьдрал орчноос олж авсан мэдлэгт гарсан алдааг оношлох, химийн хэл ашиглан алдааг засах
 5. Сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан сургалтын хэрэглэгдэхүүнийг бүтээлчээр боловсруулах, онолын мэдлэгийг хялбар эзэмшүүлэхэд чиглэх
 6. Ажлын хуудас ашиглах ажлуулах нь цаг үр бүтээлтэй ашиглах, суралцагчдын үйлийг чиглүүлэх боломжтой.
 7. Ахлах ангийн суралцагчдын дунд химийн туршилт гүйцэтгэх чадварыг сайжруулах шаардлагатай бөгөөд туршилтын дүнг химийн хэл ашиглан боловсруулах, илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд боломжит лабораторийн ажлуудыг төлөвлөх, турших
 8. Амьдрал орчноос олж авсан мэдлэгт гарч буй алдааг онолын үүднээс тайлбарлаж учир шалтгааныг баримжаалуулах нь асуудал шийдвэрлэх аргыг ашиглаж буй давуу тал юм.


ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

МОНГОЛ ДАРХНЫ УЛАМЖЛАЛТ АРГА БА ОРЧИН
ҮЕИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИ ҮЙЛДВЭРЛЭЛ СУРГАЛТ

МОНГОЛ ДАРХАНЫ БАГШ: Т.ОТГОНБААТАР



СЭДЭВ: МОНГОЛ ДАРХНЫ УЛАМЖЛАЛТ АРГА БА ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИ ҮЙЛВЭРЛЭЛ СУРГАЛТ



Зорилго: Уламжлалт дархан хийх арга барилыг орчин үеийн техни технологтой хослуулан сургалтанд хэрхэн зөв хандуулах үйлдвэрлэл сургалтын орчинг сургалтын анги танхимд бүрдүүлж өгсөнөөр суралцагсад хэрхэн үйлдвэрт гарах дадлага зэрэг хосолсон сургалтын үр дүнд хэрхэн сайн мэргэжилтэй ажилтан бэлтгэхийг тодорхойлохыг зорилоо.

Зорилт:

- Уламжлалт дархан хийх арга барилаас шаардлагтай аргачлалуудыг судлах
- Орчин үеийн техникийг сургалтанд бодитойгоор оролцуулах
- Үйлдвэрлэлийн сургалт дадлага хичээлийг тогтмол явуулах
- Хосолсон дадлага ба онол хичээл богино хугцаанд явуулаж мэргэжилтэй ажилтан бэлдэх

Сэдвийн үндэслэл: Мэргэжлийн сургалтын гол үр дүн хэрхэн зөв төлөвшил хандлагатай тухайн мэргэжилдээ дур сонирхолтой шууд үйлдвэрлэл дээр гараад ажил олгогчын хэрэгцээ шаардлага хангасан уламжлалт арга барил ба орчин үеийн техник технологтой зөв ажиллах уян хатан хөрвөх чадвартай мэргэжилтэй ажилчин бэлдэх явдал юм.

Монгол дархан урлал



Түүх соёл гэдэг тухайн улс орон үндэстэн ястаны хэрхэн яаж оршин тогтонож байсаныг илэрхийлэж байдаг биет ба биет бус өв уламжлалаар, хадаглагдаж, хэрэглэгдэж байгаа эд эдлэл, хэрэглэл, түүхийн олдвороор он цагийн түүхийн бичээсүүд зэрэг олон зүйлээс таниж мэдэж өөр өөрсдийн түүхийн хэлхээг таниж мэддэг билээ. Нүүдэлчин монгол үндэстэн бидний түүхийн бичээс ахуй амьдралтай минь салшгүй холбоотой байдаг. Бидний эртнээс уламжлагдаж ирсэн зан үйл, ахуй нь хэрэглээ, эдлэж хэрэглэж байгаа эд зүйлс нүүдэлчин амьдралын онцлог дархны урлалтай түүхэн холбоотой билээ. Эртнээс ахуй хэрэглээний ээмэг бөгж гоёл чимэглэл, аяга, таваг, сав суулга, галын тулга, морины эдлэл хэрэглэл, дайн байлдааны зэр зэвсэг зэрэг олон зүйлийг хийж ирсэн дархлах урлалыг үндэсний түүх бие даасан өв соёл болголоо хөгжиж өнөөдрийг хүртэл уламжлагдан ирж хэрэглэгдэж орчин үетэйгээ хөл нийлүүлэн монголын ард түмний хэрэглээ болж, дэлхий нийтэд танигдах нэг нэрийн хуудас болж хөгжин цэцэглэж байна.



УЛАМЖЛАЛТ ДАРХАН УРЛАЛ АРГА БАРИЛ



Бидэнд өвлөгдөж ирсэн үндэсний уламжлалт дархны урлал нь гар хийц гэж нэрлэгдэж эртнээс хийж ирсэн арга барил хийх аргачлал нь тэр л хэвээрээ багшаас шавьд өвлөгдөн үлдэх сургалтын уламжлалаар өнөөдрийг хүртэл хадгалагдан ирсэн үнэхээр гайхалтай билээ. Алт, мөнгө үнэт металл, зэс, гууль өнгөт төмөрлөг, хар ба ган төмөрийг өөрсдөө олборлож хайлуулан үнэт гоёл чимэглэл ба ахуй хэрэглээний эдлэл хэрэглэлийг төрөл бүрийн арга ажиллагаа сэдэн янз бүрийн хэлбэр дүрс оруулан уран гоё чамин зүйлийг хийж ирсэнд хүндэтгэн / Дархан хүн бурхан ухаантай / гэсэн нэрийг ард түмэн өгсөн байна.

Уламжлалт арга ажиллагааны давуу тал:


1. Бүх үйл ажиллагаа уламжлалт гар аргаар
2. Материалын орц их
3. Чанартай
4. Захиалагчын хүсэл сонирхолыг бүрэн тусгаж өгдөг
5. Дахин давтагдахгүй бүтээл бүтээгдэхүүн хийх

Уламжлалт арга ажиллагааны сул тал:

1. Удаан
2. Олон тоогоор хийх боломжгүй
3. Материалын орц их орох
4. Өндөр өртөгтэй болдог



Үндэсний уламжлалт аргаар аяганы дотор цохих байдал




Дархан урлалын орчин үеийн техик технолонги

Орчин үед дэлхий улс орнуудын хүн амын өсөлт нийгмийн хэрэгцээ техик технологийн хурдацтай хөгжил дэвшил нь манай улс орон монгол хүн бүрийн амьдрал ахуйд ихээхэн нөлөөлөж байгаа нь нийгмийн бүх салбарт ил тод харагдаж байна. Техник технологийн шинэ дэвшил дэлхийн нийгмийн шаардлагийг хангахад асар их хувь нэмэр болж байгаа. Үүнийг шалтгаалан монгол дархны урлал илүү их хурдаар богино хугцаанд чанартай, гоёмсог, өртөг хямд, олон тооны бүтээгдэхүүнээр нийгмийн хэрэгцээг хангах зайлгүй шаардлага тулгараад байна. Орчин үеийн машин техник нь энэ бүхний гол түхүүр учир бидний нэн тэргүүний эхний зорилго зорилт болгож амьдрал ахуйдаа өргөн хэрэглэх шаардлага мөн.

Орчин үеийн техник тоног төхөөрөмжийн давуу тал:



1. Хурдан
2. Олон тоогоор бүтээгдэхүүн хийх
3. Хямд өртөгтэй
4. Чанартай
5. Өнгө үзэмж сайтай



Орчин үеийн техник тоног төхөөрөмжийн сул тал:

1. Хямд материал ашиглах
2. Материалийн орц багсах
3. ХАБЭА-эрсдэлтэй




Монгол дархан урлал үйлдвэрлэл орчин үеийн хэрэглээ

Хүмүүний хэрэгцээ үнэхээр тасаралтгүй үргэлжлэх гинжин хэлхээ билээ. Энэ хэрэгцээг хангахад бид гар аргаар ганц нэгээрээ хийж гүйцэтгэх боложгүй. Иймд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь одоо ба ирээдүй нь нийт нийгмийн томоохон зорилт юм. Монгол улсын хэмжээнд 70 орчим үйлдвэр дархан урлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулаж байгаа бүртгэлтэй боловч дэлхий түвшиний орчин үеийн тоног төхөөрөмжтэй тогтмол үйл ажиллагаа явуулаж байгаа үйлдвэр

аж ахуй нэгж гарын арван хуруунд ч хүрэхгүй тоологдож байна. Дархны урлал монгол улсын хэмжээнд хангалтгүй үйлдвэрлэл явагдаж чанарын түвшин төдийлэн хангалтай биш байгааг илэрхийлэж байна гэсэн үг юм. Монгол улс ба монгол үндэстний хувьд 10 орчим сая хүн ам тоологдож байгаа мэдээ дэлхийн статик судалгаагаар тэмдэглэгсэн байдаг. Энэ бол бага тоо биш юм үүнээс гадна аялал жуулчлал гадаад улсуудын биднийг өв соёлоо дэлхийд хэзээ бүрэн гүйцэт нээж харуулахыг хүлээн суугаа гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Монголын дархан урлал сургалт арга барил одоо үед

Монгол улсын хэмжээнд албан ёсны төрийн засгийн харьяанд байгуулсан дархан урлалын сургалтын газар Дурслэх урлагийн дээд сургуулийн (монгол дархны анги), Үйлдвэрлэл урлал политехник коллежийн (монгол дархны анги), (үнэт эдлэл дархны анги) гэсэн 3 анги хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулаж байна. Үүнээс үндэсний уламжлал ба орчин үеийн арга барилаар мэргэжилтэй ажилтан бэлтгэх дархны сургалтын үйл ажиллагааг явуулаж байгаа сургууль болохыг зориж байгаа нь манай ҮҮП-коллеж билээ



Дархны үйлдвэрлэл сургалт мэргэжилтэй ажилтан бэлтгэх

Бидний явуулаж байгаа сургалтын үйл ажиллагаа нь зөвхөн сургуулийн сургалтын орчинд дан ганц явагдах бус улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулаж байгаа үйлдвэр аж ахуй нэгжүүдтэй хамтран дадлага сургалтыг тогтмол зохион байгуулаж байгаа сүүлийн үед ихээхэн ашиг тусаа өгч байгаа үр дүнгээр тодорхой харагдаж байна. Гэвч бид өөрсдийн сургуулийн сургалтын орчинд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг түлхүү хэрэглэх нь сургалтын хурд ба суралцагсадын сурах сурах идэвх зүтгэлийг ихээхэн нэмэгдүүлж мэргэжлийн сайн өндөр түвшиний ажил олгогчийн эрэл шаардлагийг хангасан урлаач мэргэжилтэй ажилтан бэлтгэх нөхцөл бүрдэх нь бидний зорилго билээ.




Токарийн машин дээр дадлага хийж

ДҮГНЭЛТ:

Орчин үед дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах бидний гол асуудал тул ирээдүй болсон хойч үе хүүхэд залуусыг зөв сургаж ирээдүй гарцын нээж өгөх явдал нь энэ бүх сургалт үйлдвэрлэлийн ач холбогдол үр лүн байх болно гэж дүгнэж байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ:

1. Д.Энхдаваа “ Монгол дархчлал” УБ. 2006 он
2. Л.Батчулуун “ Монгол дархны урлаг I боть УБ. 2012 он
3. Л.Батчулуун “ Монгол гагнуурын жор УБ. 1992 он
4. www.Google.mn
5. Pinteres.com

ХАВСРАЛТ:

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

ОРЧНЫ ДИЗАЙНЫ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ
СУРГАЛТ, УЛАМЖЛАЛТ АРГА БА ОРЧИН ҮЕИЙН
ТЕХНИК ТЕХНОЛОГИ

ОРЧНЫ ДИЗАЙНЫ БАГШ: Д.ТУУЛ



СЭДЭВ: ОРЧНЫ ДИЗАЙНЫ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛВЭРЛЭЛ СУРГАЛТ, УЛАМЖЛАЛ АРГА БА ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК ТЕХНОЛОГИ

Зорилго: Орчны дизайн мэргэжлээр чимэглэлийн баримал, керамик урлалын арга



технологии, эртний уламжлалт урлаг болон орчин үеийн урсгал чиглэлээр шинэлэг техник технологтой хослуулан гадаа дотор орчинд өнгө хэлбэрээр сэтгэмжит загвар хийх үйлдвэрлэл сургалтын орчинг сургалтын анги танхимд бүрдүүлж өгсөнөөр суралцагсад хэрхэн үйлдвэрт гарах дадлага зэрэг хосолсон сургалтын үр дүнд хэрхэн сайн мэргэжилтэй ажилтан бэлтгэхийг тодорхойлохыг зорилоо.

Зорилт:

- Чимэглэлийн бүтээл хийх уламжлалт арга барил болон гадаадын орнуудын шинэлэг дэвшилттэй технологи аргачлалуудыг судлах
- Орчин үеийн шинэлэг техникийг сургалтанд нөхцөл боломжоос шалтгаалан үе шаттайгаар хэрэгжүүлжэх
- Гэрээт байгуулагын санал зөвлөмжийг үйлдвэрлэлийн сургалт дадлага хичээлдээ тусган хамтран ажиллах
- Онол дадлага хичээл хосолсон богино хугацааны сургалт явуулж мэргэжилтэй ажилтан бэлдэх техник хэрэгсэлийг бүрдүүлэх

Сэдвийн үндэслэл

Мэргэжлийн сургалтын гол үр дүн хэрхэн зөв төлөвшил хандлагатай тухайн мэргэжилдээ дур сонирхолтой шууд үйлдвэрлэл дээр гараад ажил олгогчын хэрэгцээ шаардлага хангасан уламжлалт арга барил ба орчин үеийн техник технологтой зөв ажиллах уян хатан хөрвөх чадвартай мэргэжилтэй ажилчин бэлдэх явдал юм.

Уран баримал

Уран баримал гэдэг нь дүрслэх урлаг-ийн нэгэн төрөл бөгөөд гурван хэмжээст тэнхлэг бүхий бодит биетийг хэлдэг. Уран баримал нь орон зайн урлагийн төрөл юм. Баримлын урлагт хэлбэр



нэмж дүрс үүсгэдэг бол сийлбэрийн урлагт хэлбэр хасаж дүрс үүсгэдэг. Хүний бие сэтгэлийн хамгийн сайн сайхныг тэр дундаа эрүүл чийрэг, хүч чадал, гоо үзэсгэлэн, ариун ёс энгийн байдлыг нэгдмэл байдлаар хослуулан хэрэгжүүлж тухайн цогцолборыг буй болгож байгаа урлаг юм. Дүрээ илэрхийлэх арга нь орон зайн тодорхой хэмжээсэнд барьж, сийлж, цоолж бүтээнэ. Уран баримал тодорхой биет материалаар бодит байдлыг дүрсэлнэ. Дүрслэлийн объектын хувьд ихэвчлэн хүн болон амьтан дүрсэлнэ.

Өгүүлэмж маш товчхон, зохиомж нь нарийн, үүгээрээ уран зурагтай төстэй. Гэхдээ уран баримал, уран зураг хоёр нь дүрслэлийн элементээрээ, дүрээ илэрхийлэх аргаараа ялгаатай байдаг. Уран баримлыг чулуун цоолбор, мод, яс, чулуу, ган, сийлбэр, цаасан шуумал, зэс, гуулин, хөөмөл, ган цутгамал, гөлтгөнө, цемент, гантиг, боржин, хүрлээс эхлээд хатуу зөөлөн янз бүрийн материалыг чадварлаг ашиглан урлагийн энэ салбарт шинийг бүтээж байна. Уран баримлыг зориулалтаар нь суурь ба сүрлэг том (монументаль) гэж хуваадаг. Суурь баримал нь үзвэрийн зориулалттай байдаг бол сүрлэг том баримлыг уран барилгатай зохицуулан орд харш, сүм хийд, цэцэрлэгт хүрээлэнтэй цогцолбор болгон урласан байдаг. Баримлын урлагийг дотор нь зохиомжтой ингэмэл (товгор) баримал болон уран баримлын чимэглэл гэж ангилдаг. Монументаль уран баримал бол сүрлэг, бадрангуй чанарыг илэрхийлнэ. Голчлон хөшөө дурсгалуудад сүрлэг том баримлыг уран барилгатай зохицуулан орд харш, сүм хийд, цэцэрлэгт хүрээлэнтэй цогцолбор болгон урласан нь олон байдаг. Сэдэвчилсэн уран баримал нь уран сайхны агуулга бүхий зохиомжит бүтээлүүд болно. Хөрөг баримал нь түүхэн болоод алдар суут хүмүүсийн дүр дүрслэл бүхий уран бүтээлүүдийг энд хамаарна. Ингэмэл баримал нь хавтгай дээр товойлгон ихэвчлэн барилгын гоёл чимэглэлд зориулагдаж байснаа хожим XVIII зууны үед уран баримлын тусгай төрөл болсон. Ингэмэл нь



Керамик урлал

уран баримлын биет болон эзлэхүүнт чанарыг уран зургийн дүрслэлтэй хосолдоогоор онцлог. Монголын уран барималд хамаарагдах нэн эрт үеийн дурсгалуудад манай орны Алтай, Хангай нутгаар элбэг байдаг буган чулуу, хүн чулуу, бичигт чулуу юм. Монгол гүрний үед холбогдох уран баримлын зүйлс ховор боловч хүн чулуу, бичигт пайлуур, уран барилгын чимэглэл, чулуун цоолтвор баримлын зүйлс бий.

Керамик гэдэг үг нь эртний грекээс гаралтай үг бөгөөд утгачилбал “Хүрдний урлаг” гэж тайлбарладаг. Харин керамик урлал гэдэг нь шавраар бүтээгдэхүүн урлахыг хэлдэг. Керамик урлал нь жижиг баримал, бэлэг дурсгал, ваар сав, уран барилгын чимэглэл, шаазан сав суулга урлал гэж хэд хэдэн ангилалтай байдаг. Керамик урлалын материал түүхий эд нь байгалийн нанги шавар юм. Мөн өөрөөр тайлбарлавал энэхүү гайхамшигтай урлаг нь эрт үеэс хүмүүсийн хэрэгцээн дээр үндэслэн бий болсон гэхэд болно. Эртний Вавилон улс ваар сав, эд ахуйн зүйлсээс эхлээд орд харшаа керамик урлагаар чимэглэж байсан гэдэг. Харин орчин үед керамик урлагийг барилгын хана, шал, тосгуур суултуур, плита зэрэгт өргөн хэрэглэж байна. Ингээд бодоход энэ урлаг бол маш их хөдөлмөр үнэ цэнээр хийгддэг гайхамшигтай урлаг юм. Мөн Хятадын керамик хамгийн алдартай нь байдаг. Керамик урлаг- шавраар янз бүрийн зүйл хийх - ардын гар урлалын эртний төрөл. Эрт дээр үеэс керамик эдлэл хүмүүст үйлчилж ирсэн. Тэдгээр нь ашигласан түүхий эд материалын төрөл, паалантай бүрээсийн найрлага, үйлдвэрлэлийн арга, зорилго зэргээрээ ялгаатай байв. Боловсруулахад тохиромжтой шаврын байгалийн нөөц хаана ч байсан шавар урлагчид янз бүрийн хэлбэр дүрс бүхий цэцгийн сав, аяга, лонх, аяга, колбо, ваар зэрэг өдөр тутмын амьдралд хэрэгтэй олон зүйлийг бүтээдэг. Материалын уян хатан байдал, өнгө аяс, эд зүйлсийг алаг, баялаг өнгө өгдөг олон төрлийн паалантай байдал нь керамик эдлэлүүд нь зөвхөн ашиг тустай үүрэг

гүйцэтгэдэг төдийгүй урлагийн бүтээл болоход хувь нэмэр оруулсан. Янз бүрийн эрин үеийн керамик эдлэлүүд нь тухайн үеийн онцлог шинж чанаруудаар тэмдэглэгдсэн байдаг. Түүний сонирхол бидний үед хадгалагдан үлдсэн. Өнөө үед керамик эдлэл өргөн хэрэглэгддэгдотоод засал чимэглэлийн хуваалт, lattices хэлбэрээр. Зуух нь керамик тоосгоор хийгдсэн байдаг. Шаазан рельеф, гоёл чимэглэлийн болон сэдэвчилсэн хавтан, лааны тавиур, гоёл чимэглэлийн ваар, сав, аяга, цэцгийн сав зэргийг бие даасан эд зүйл болгон ашигладаг бөгөөд онцгой сэтгэл хөдлөл, тав тухыг бий болгодог найрлагад ашигладаг. Төрөл бүрийн хэлбэр, хэмжээтэй ваар нь маш их алдартай, ханын керамик - гоёл чимэглэлийн таваг, хавтан, давхарга. Ийм керамик эдлэлийг чадварлаг сонгосноор тэд дотоод засалд сайн нийцэж, түүнийг нөхөж өгдөг.

Керамикийн технологийн үндсэн төрлүүд майолика, терракотта, шамот, шаазан, фаянс юм. Тэд шаврын найрлага, галлах горим, гоёл чимэглэлийн техникээр ялгаатай.

Шамот- гоёл чимэглэлийн ваар, рельеф, гоёл чимэглэлийн баримал бүтээхэд ашигладаг. Эдгээр бүтээгдэхүүнүүд нь гоёмсог ширхэгтэй бүтэцээр ялгагддаг бөгөөд паалангаар чимэглэсэн нь тэдэнд өвөрмөц амтыг өгдөг. Шаазан- каолин, хуванцар шавар, кварц, хээрийн жоншны нарийн хольцоос гаргаж авсан эрдсийн масс. Шаазан бүтээгдэхүүн нь цагаан, нимгэн (нимгэн хэлтэрхий), ил тод байдал зэргээр ялгагдана. Тэд бүрхүүлгүй байсан ч шингэнийг нэвтрүүлэхийг зөвшөөрдөггүй. Фаянс нь шаазантай ойрхон боловч цагаан, тунгалаг чанарыг эзэмшдэггүй, хэлтэрхий нь зузаан, бүрхүүлгүй, чийгийг нэвтрүүлэх боломжийг олгодог. Шаазан, вааран эдлэл



нь үндсэндээ аяга таваг, гоёл чимэглэлийн зүйлс - ваар, аяга таваг, төрөл бүрийн найрлага гэх мэт. Фаянс - керамик хэлтэрхий нь сүвэрхэг байдлаасаа болж чийглэг уур амьсгал, ялангуяа температурын огцом хэлбэлзэлд өртөмтгий байдаг. Үүнийг арилгахын тулд керамик нь паалантай (паалантай) хучигдсан байдаг - шилэн найрлага нь керамик бүтээгдэхүүний бүх гаднах нүхийг дүүргэж, зарим гэрэлтүүлгийг өгдөг. Бүрхүүлийг зориулалтын массын найрлагаас хамааран янз бүрийн аргаар бэлтгэдэг. Хатуу паалантай (хээрийн жонш гэх мэт) ба зөөлөн (хар тугалга эсвэл борын хүчил агуулсан) ялгах. Объектуудыг өргөн сойзоор пааландаж эсвэл хавчаараар шууд паалангын уусмал руу дүрж, сүвэрхэг шавар нь өөртөө хурдан шингэж, дараа нь шатаадаг. Хатуу паалан дээр зурах нь үргэлж бага зэрэг хуурай байдаг тул та үүнийг паалангаар хийсэн болохыг шууд анзаарч болно, харин зөөлөн паалан дээр зурах нь заримдаа паалантай будгаас ялгахад хэцүү байдаг.

Чимэглэлийн болон хэрэглээний урлаг

Чимэглэлийн болон хэрэглээний урлаг нь хүмүүсийн хэрэглээний болон урлаг, гоо зүйн хэрэгцээг хангахад зориулагдсан гэр ахуйн эд зүйлсийг бүтээх бүтээлч үйл ажиллагааны төрөл юм. Урлаг, гар урлалд төрөл бүрийн материалаар хийсэн, өөр өөр технологи ашиглан хийсэн бүтээгдэхүүн орно. Чимэглэлийн объектын материал нь металл, мод, шавар, чулуу, яс байж болно. Бүтээгдэхүүн хийх техник, уран сайхны аргууд нь маш олон янз байдаг: сийлбэр, хатгамал, уран зураг, хөөцөлдөх гэх мэт. Чимэглэлийн урлагийн объектын гол онцлог нь гоёл чимэглэлийн байдал бөгөөд дүрслэл, түүнийг илүү сайн, илүү үзэсгэлэнтэй болгох хүсэл эрмэлзэлээс бүрддэг. Чимэглэлийн болон



хэрэглээний урлаг нь үндэсний шинж чанартай байдаг. Энэ нь тухайн үндэстний зан заншил, дадал зуршил, итгэл үнэмшлээс үүдэлтэй тул түүний амьдралын хэв маягтай ойр байдаг. Чимэглэлийн болон хэрэглээний урлагийн чухал бүрэлдэхүүн хэсэг бол ардын урлаг, гар урлал юм - хамтын бүтээлч сэтгэлгээнд суурилсан уран сайхны ажлыг зохион байгуулах, орон нутгийн соёлын уламжлалыг хөгжүүлэх, гар урлалын бүтээгдэхүүн борлуулахад чиглэсэн хэлбэр юм.

урлаг, гар урлал(lat.deco - чимэглэх) - янз бүрийн салбарыг хамарсан урлагийн өргөн хэсэг бүтээлч үйл ажиллагаауран сайхны бүтээгдэхүүн бий болгоход чиглэгдсэн ашиг тустай, уран сайхны шинж чанартай. Хамтын нэр томъёо нь уламжлалт байдлаар гоёл чимэглэлийн болон хэрэглээний гэсэн хоёр төрлийн урлагийн төрлийг нэгтгэдэг. Гоо сайхны таашаал авах зорилготой, цэвэр урлагтай холбоотой дүрслэх урлагийн бүтээлүүдээс ялгаатай нь урлаг, гар урлалын олон тооны илрэлүүд нь практикт хэрэглэгдэх боломжтой. Өдөр тутмын амьдрал.

Гоёл чимэглэлийн болон хэрэглээний урлагийн бүтээлүүд нь хэд хэдэн шинж чанартай байдаг: тэдгээр нь гоо зүйн чанартай; уран сайхны эффектэд зориулагдсан; өдөр тутмын амьдрал, дотоод засал чимэглэлд үйлчилдэг. Эдгээр бүтээлүүд нь: хувцас, хувцас, гоёл чимэглэлийн даавуу, хивс, тавилга, урлагийн шил, шаазан, фаянс, үнэт эдлэл болон бусад урлагийн бүтээгдэхүүн юм. Эрдмийн уран зохиолд 19-р зууны хоёрдугаар хагасаас эхлэн урлаг, гар урлалын салбаруудыг материалаар нь ангилж(металл, керамик, нэхмэл эдлэл, мод), гүйцэтгэх техник дээр(сийлбэр, уран зураг, хатгамал, хэвлэх, цутгах, товойлгох, интарсиа (янз бүрийн модоор хийсэн зураг) гэх мэт) болон сэдвийг ашиглах функциональ шинж тэмдгээр(тавилга, аяга таваг, тоглоом). Энэхүү ангилал нь урлаг, гар урлал дахь бүтээн байгуулалт, технологийн зарчмын чухал үүрэг, үйлдвэрлэлтэй шууд холбоотой байдагтай холбоотой юм.

Уламжлалт чимэглэлийн барималын арга барил

Бидний үеийнхэний багш нар орос, чех, герман, хятад зэрэг орнуудад суралцаж төгссөн монголдоо болон ази, европдоо нэр хүндэдтэй тодорхой орон зай эзэлсэн уран бүтээлч хүмүүсээр хичээл заалган ирсэн азтай хүмүүс юм. Орчин үеийн хотжил, хөгжлийн шаардлагад нийцүүлэн хямд төсөр богино хугацаанд хийх шинэ дэвшилтэд технологийн ахуй хэрэглээний бүтээл чимэглэл орчинд шаардлагатай болж ази, европын орнуудын техник технологийг үйлдвэрлэл сургалтанд хэрэгжүүлэх шаардлага гарч сургууль болон өөрийн нөөц боломжинд тулгуурлан үе шаттайгаар хэрэгжүүлж ажилаж байна.



Шахмал материалын технологийн харьцуулалт:

Уламжлалт арга ажиллагааны сул тал

А. Дамжлага ажиллагаа ихтэй

1. Моддь зорох,
2. Хээ чимэглэл хийх,
3. Хэв авах,
4. Цутгах,
5. Засах,
6. Будах өнгөлөх

Б. Олон төрөлийн материал их хэмжээгээр орох

В. Материалын орц их орох

Г. Өндөр өртөгтэй болдог

Ногоон байгууламжын ваарны эх загварыг азийн сүүлийн үеийн шинэ технологиор хийхэд:

Давуу тал:

1. Дамжлага ажиллагаа багатай
2. Цөөхөн материал ордог
3. Хугацаа бага орох
4. Чанар сайтай
5. Шинэлэг зохиомж дизайны шийдэл гаргах боломжтой

Орчны дизайн мэргэжлийн үндсэн чиглэл керамик урлалын орчин үеийн дэвшилтэд техник технолог



Монгол улсад зах зээлийн нээлттэй эдийн засгийн цаг үед орчин үеийн техник технологи шинэчлэгдэн сайжирч, уран бүтээлчид гадаадын дэвшилтэд тоног төхөөрөмж оруулж ирсэнээр тог цахилгаан бага зарцуулдаг, богино хугацаанд ажилдаг хөнгөн багтаамж сайтай хүчин чадал өндөр керамик шатааж боловсруулах дунд зэрэг, том оворын зуух, туршилт шинжилгээний муфль зуух, ваар эргүүлэх хүрд мөн металл өнгөлөг паалан, олон төрөл зориулалтын нягтрал хатуулга сайтай, өндөр градусын шавар, гар урлалын технологи орж ирсэн нь



уран бүтээл, сургалтын дэвшил өөрчлөлт гарах боломжтой боллоо. Орчин үед дэлхий улс орнуудын хүн амын өсөлт нийгмийн хэрэгцээ техник технологийн хурдацтай хөгжил дэвшил нь манай улс орон монгол хүн бүрийн амьдрал ахуйд ихээхэн нөлөөлөж байгаа нь нийгмийн бүх салбарт ил тод харагдаж байна. Техник технологийн шинэ дэвшил дэлхийн нийгмийн шаардлагийг хангахад асар их хувь нэмэр болж байгаа. Үүнээс шалтгаалан керамик урлалаар орчин үеийн шинэ техник технологиор илүү их хурдаар богино хугацаанд чанартай, гоёмсог, өртөг хямд, олон тооны бүтээгдэхүүнээр нийгмийн хэрэгцээг хангах зайлгүй шаардлага тулгараад байна.

Орчин үеийн техник тоног төхөөрөмжийн давуу тал:

- 1.Тог цахилгаан бага зарцуулдаг
- 2.Бүтээмж өндөр
- 3.Хямд өртөгтэй
- 4.Боловсруулалт сайн, чанартай
- 5.Өнгө үзэмж сайтай

Орчин үеийн техник тоног төхөөрөмжийн сул тал:

- 1.Хэврэг хөнгөн чанарын материалтай /их хариуцлагатай болгоомжтой харьцах/
- 2.Паалан, шавар нь өндөр градуст шатдаг
- 3.Тоног төхөөрөмжийн сэлбэг зардал ихтэй

Уран бүтээл, сурагчдын мэргэжлийн дадлага ажилд хэрэглэхээр хувиараа авсан, америкийн керамик шатааж боловсруулах том оворын болон туршилт шинжилгээний жижиг муфль зуухаа байрлуулж цахилгаан шугамын холболт хийгдэж байна.

Керамик урлал үйлдвэрлэл орчин үеийн хэрэглээ шаардлага

Керамик урлал зах зээлийн шилжилтийн үед уналтанд орж материал сэлбэг хэрэгсэл тасран уналтанд орсон гадаад харилцаа сэргэн уран бүтээлчид өндөр хөгжилтэй орнуудад үзэсгэлэн гаргаж эхэлсэнээр 2010 оноос техник технологи, материал хэрэгсэл оруулж ирж керамик урлал сэргэн хөгжиж эхэлсэн. Керамик урлал нь жижиг бэлэг дурсгал, интерьерийн баримал, гадаа талбайн баримал чимэглэл хийхэд бөх бат, орчинд өнгө, хэлбэрийн зохицол сайтай чимэглэлийн баримал, дизайны шийдэл гаргахад төгс зохицсон урлал юм. Хүмүүний хэрэгцээ үнэхээр тасаралтгүй үргэлжлэх гинжин хэлхээ билээ. Энэ хэрэгцээг хангахад бид гар аргаар ганц нэгээрээ хийж гүйцэтгэх боломжгүй. Иймд үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь одоо ба ирээдүйн нийт нийгмийн томоохон зорилт юм. Уран бүтээлч урчууд хот хөдөө керамик урлалын урлан, студ, үйлдвэр сургалтын газар байгуулан оюутан залуучуудыг сурган хот, орон нутгийнхаа өнгө үзэмж хөгжилд хувь нэмрээ оруулж байна.

Орчны дизайн мэргэжлээр керамик урлалын сургалт

Монгол улсын хэмжээнд дүрслэх урлагийн олон мэргэжлээр албан ёсны төрийн өмчит 2 сургууль сургалт явуулдагаас Дүрслэх Урлагийн Академи дээд сургуулийн (Керамик урлалын анги), 4 жил бакалавр, 2 жил магистрийн зэрэгтэй, Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн (Орчны дизайнч анги) 2,5 жилийн бүрэн дунд боловсрол, мэргэжлийн анхан шатны боловсролын үнэмлэхтэй үндэсний уламжлал ба орчин үеийн арга барилаар мэргэжилтэй ажилтан бэлтгэн төгсгөж байна. Мөн хувийн керамик урлалын студ, урлан, сургалтын газрууд хичээл сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

Орчны дизайны мэргэжлийн сургалт мэргэжилтэй ажилтан бэлтгэх

Бидний явуулаж байгаа сургалтын үйл ажиллагаа нь зөвхөн сургуулийн сургалтын орчинд дан ганц явагдах бус улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулаж байгаа үйлдвэр аж ахуй нэгжүүдтэй хамтран дадлага сургалтыг тогтмол зохион байгуулаж байгаа сүүлийн үед ихээхэн ашиг тусаа өгч байгаа үр дүнгээр тодорхой харагдаж байна.Гэвч бид өөрсдийн сургуулийн сургалтын орчинд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг түлхүү хэрэглэх нь сургалтын хурд ба суралцагсадын сурах сурах идэвх зүтгэлийг ихээхэн нэмэгдүүлж мэргэжлийн сайн өндөр түвшиний ажил олгогчийн эрэл шаардлагийг хангасан урлаач мэргэжилтэй ажилтан бэлтгэх нөхцөл бүрдэх нь бидний зорилго билээ.

ДҮГНЭЛТ


Орчин үед дэлхий нийтийн хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэн алхах бидний гол асуудал тул ирээдүй болсон хойч үе хүүхэд залуусыг зөв сургаж ирээдүй гарцын нээж өгөх явдал нь энэ бүх сургалт үйлдвэрлэлийн ач холбогдол үр лүн байх болно гэж дүгнэж байна.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ:

С.Бадрал “ Дүрслэх урлаг” 1, 2, 3, УБ. 1996 он

1. Б.Бадрах “ Дезайны онолыг зарим асуудал” УБ. 2000 он
2. Г.Амарбат “ Хавтгайн урлаг төлөвлөлтийн үндэс ” УБ. 1989 он
3. [Www.Google.mn](http://www.Google.mn)
4. Pinteres.com

ХАВСРАЛТ:



[illegible][illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

МСҮТ БОЛОН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖ-д ҮСЧИН
МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГЧДЫН УР ЧАДВАРЫГ
ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

ҮСЧНИЙ БАГШ: Д.АМАРТҮВШИН



СЭДЭВ: МСҮТ БОЛОН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖД ҮСЧИН МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАГСДЫН УР ЧАДВАРЫГ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН СУДАЛГАА

ХУРААНГУЙ



Судалгааны ажил нь хоёр бүлэг, дөрвөн зүйл, дүгнэлт, номзуй, хавсралтаас бүтсэн 51 хуудастай. Нэгдүгээр бүлэгтээ Политехник коллежд үсчин мэргэжлээр суралцагсдын ур чадварын талаарх онолын үндсэн асуудал болон тэдний ур чадварыг судалсан үр дүнг бичиж, хоёрдугаар бүлэгтээ Политехник-д үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварын онцлог, түүнийг хөгжүүлэх арга замыг тодорхойлж бичсэн болно.

Судалгааны ажлын зорилго нь: Налайх дүүргийн МСҮТ-д болон ҮУПК-д үсчний мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн ур чадварыг судалж, түүнийг сайжруулах арга замыг тодорхойлоход оршино. Үүний тулд **дараах зорилтуудыг** дэвшүүлэн судалгааны ажлаа гүйцэтгэсэн юм. Үүнд:

1. Үсчний мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн ур чадварын талаарх онолын үндсэн асуудлыг судалж, онолын тойм гаргах,
2. Үсчний мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн ур чадварын үндсэн чиглэл, зайлшгүй шаардлагатай дасгалуудын бүтцийг тогтоож, тодорхойлох,
3. Үсчний мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн ур чадварын онцлогийг илрүүлж, тэдгээрт тулгуурласан аргазүйг боловсруулах оролдлого хийлээ.

СУДАЛГААНЫ ТААМАГЛАА

Үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг суралцах хугацаанд нь хөгжүүлж чадсанаар мэргэжилтэн бэлтгэх ажлын чанарт өөрчлөлт гарч чадна гэж үзэж байна.

Судалгааны хамгаалах зүйл нь:

1. Үсчний мэргэжлийн ур чадварыг илрүүлэх судалгаа, үр дүн, онцлог
2. Үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг хөгжүүлэх дасгалуудын сонголт, бүрдэл хэсэг.
3. Үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг хөгжүүлэх арга зам зэрэг болно.

Судалгааны ажлын онолын ач холбогдлыг:

Үсчний мэргэжлээр суралцагсдын мэргэжлийн ур чадварыг суралцагсдын онцлогт тохируулан сонгож судалсанд, **практик ач холбогдлыг нь:**

ҮУПК-д үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх арга зүйг зааж сургасанд;

ҮУПК-д үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг хөгжүүлэх аргыг үс угаах, үс тайралт, үсэнд хими хийх, үс долгионтуулах, үсийг сорлох үндсэн техникийн жишээн дээр хөгжүүлэх оролдлого хийсэнд тус тус оршино гэж үзэж байна.

Политехник коллеж-д үсчин мэргэжлээр суралцагсдын ур чадварын хөгжлийн талаарх онолын үндсэн асуудал

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор чадамжид суурилсан сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг 2011 оноос эхлэн хийж байна. 2013 онд судлаач С.Болор-Эрдэнэ, Б.Галбадрах, Ц.Лувсандорж, Клавз Даал Кристенсен, Жэн Метисон, Р.Эрдэнэтуяа, Ц.Батчимэг, Ц.Отгонмягмар, Д.Одгэрэл нарын бүрэлдэхүүнтэй чадамжид суурилсан сургалтын онол, аргазүйн үндэс боловсрогдон, хэрэгжиж байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг эрэлтэд суурилсан, олон өмчийн тогтолцоонд тулгуурласан, баялаг бүтээхэд чиглэгдсэн, сургалтын байгууллага болгон шинэчилж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг бэхжүүлэх арга хэмжээ авч, тэдгээрт суралцагсдын нийгмийн асуудлыг онцгойлон анхаарч байна.

Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн сургалтын арга зүй нь юунд суралцах, яаж сургах, хэрхэн сурч эзэмших гэсэн гурван үндсэн зорилтыг шийдвэрлэнэ.

Нэгдэх зорилт нь мэргэшлийн тодорхойлолт, мэргэшлийн түвшний стандартад харгалзах сургалтын агуулга, материалын сонголтоор шийдвэрлэгдэнэ.

Хоёрдугаар зорилт нь үйлдвэрийн сургалтын хичээл, заах, сургахуйтай холбоотой. Багшлах үйл ажиллагаа нь сурагчдад мэдээлэл өгөх, сургалтын үйл явцыг удирдан зохион байгуулах, практик чадвар олгох, тэдний танин мэдэх үйл ажиллагааг удирдахад чиглэгдэнэ.

Гуравдугаар зорилт нь суралцаж сурах гэсэн зарчим буюу сурагчдыг сурахад нь яаж дэмжлэг үзүүлэх, ямар менежмент, аргазүй хэрэглэхийг зөв тогтооно гэсэн үг юм. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд багш, сурах бичиг, мэдээллийн бусад эх үүсвэрүүд, сургалтын орчин голлох үүрэг гүйцэтгэдэг. Үйлдвэрлэлийн сургалт нь мэргэжлийн чадвар, дадал эзэмшүүлэхэд бүрэн чиглэгдэж байдаг.

Мэргэжлийн чадвар дадал нь мэдлэгийн үндсэн дээр практик үйлийг зорилго чиглэлтэй, ухамсартайгаар гүйцэтгэхэд бэлэн байх явдал, өөрөөр хэлбэл, мэргэжлийн үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, чадвар, үйлийн гүйцэтгэлийн технологи, менежментээр тодорхойлогдоно. Мэргэшсэн хөдөлмөрийн үйлийн хэрэгжилт нь мэргэшлийн чадварыг эзэмшсэн байдал, гүйцэтгэх ур чадвараас хамаардаг байна.

Үйлдвэрлэлийн сургалт нь мэргэжлийн чадвар, дадал эзэмшүүлэхэд бүрэн чиглэгдэж байдаг.

Тухайлбал, мэргэжлийн чадвар дадал нь мэдлэгийн үндсэн дээр практик үйлийг зорилго чиглэлтэй, ухамсартайгаар гүйцэтгэхэд бэлэн байх явдал, өөрөөр хэлбэл, мэргэжлийн үйл ажиллагаанд шаардагдах мэдлэг, чадвар, үйлийн гүйцэтгэлийн технологи, менежментээр

тодорхойлогддог байна. Үүнийг эрдэмтэн С.Цэпил “*мэргэжлийн чадвар нь зөвхөн биеэр цйлдэх төдийгүй, оюун ухааны цйлдэлд бэлэн байх хосолмол чадвар*” юм гэж тодорхойлсон байдаг.

Тодруулбал, сурагчид өөрийнхөө хөдөлгөөн нэг бүрийг ухамсартайгаар хянаж, тааруулж явах ба алхам бүр нь ямар нэг зайлшгүй үр дүнд хүрэх ёстой.

Ийнхүү сурагчид нь хөдөлмөрийн үйлийг олон дахин давтсаны үр дүнд түүнийг хөнгөн, хурдан, чадмаг гүйцэтгэж байгаа үйл явцыг бараг автоматаар хийх болсон үед ур чадвар нь дадалд хувирна. Ингэхлээр дадал гэдэг нь дасгалын үр дүнд бий болсон төлөвшсөн чадварын автоматчилагдсан хэсэг юм гэсэн онол, үзэл баримтлал нь судалгааны ажлаар улам тодорхой харагдлаа.

Түүнээс гадна мэргэжилтний ур чадвар нь хөдөлмөрт хандах хандлага, ёс суртахууны хариуцлага, ажил хэрэгт бүтээлчээр хандах, нягт нямбай ажиллах зуршил, бэрхшээлийг тэвчээртэй давах болон хөдөлмөрийн өндөр чанарын төлөө тэмцэх, сайн чанарыг бүтээгдэхүүнээр хэрэглэгчийн шаардлага, хэрэгцээг найдвартай хангах зэрэг шалгуураар хэмжигдэж болдог.

Судалгааны аргаас танилцуулахад: Бидний мэдэх гар хурууны дасгал дээр дараах 5 нэмэн боловсруулж, цогц дасгалын аргыг туршснаар суралцагсдын ур чадвар харьцангуй сайжирч байсан нь судалгаанаас тод харагдаж байгаа юм .

Судалгааны ажлынхаа явцад үсчний мэргэжлээр суралцагсдын ур чадварыг нэмэгдүүлэхийн тулд хөдөлгөөнт дасгалын тогтолцоог боловсруулж, түүнд дагалдуулан сургах замаар үр дүнг тооцож үзэхэд үсчний үндсэн чадваруудад хэрэглэгдэх хөдөлгөөний дадал, эв дүй, ур чадвар мэдэгдэм ахиж байсан болно.

Чадамжид суурилсан сургалтыг хэрэгжүүлэхийн тулд гүйцэтгэлд суурилсан сургалтын аргуудыг боловсруулж хэрэгжүүлдэг байна. Үүнд дор дурдсан нэр томъёонуудыг анхаарч үзэх нь чухал. Үүнд:

- Чадамжид суурилсан сургалт ЧСС – СВТ
- (Competence – based training)
- Чадамжид суурилсан боловсрол ЧСБ – СВЕ
- (Compotence – based education)
- Чадамжид суурилсан заах арга ЧСЗА – СВИ
- (Compotence – based instruction)
- Гүйцэтгэлд суурилсан заах арга – ГСЗА – РВИ
- (Performance – based instruction)

Чадамжид суурилсан сургалтын аргын шинж чанарууд нь ганцаарчилсан сургалт ба өөрөө сурах аргыг хэрэглэдэг. Тухайн чадамжийг эзэмших байхдаа шаардлага гарвал суралцагч холбогдох онолын судалдаг. Суралцагч урьд өмнө эзэмшсэн ур чадвар, мэдлэг эсвэл чадамжийг үнэлүүлж, тодорхой чадамжийг алгасан судалж болдог байна.

Судалгааны аргаас танилцуулахад: Бидний мэдэх гар хурууны дасгал дээр дараах 5 нэмэн боловсруулж, цогц дасгалын аргыг туршснаар суралцагсдын ур чадвар харьцангуй сайжирч байсан нь судалгаанаас тод харагдаж байгаа юм .

Энэхүү 8 тоот хөдөлгөөн нь манай мэргэжлийн хувьд үргэлж хоёр хөл дээрээ босоо ажилладаг хүмүүст судасны бүдүүрэлд өртөхөөс сэргийлнэ.

- Мөн цусны эргэлт сайжруулна
- Сээр нурууны шохойжилт, суultaас сэргийлнэ
- Гар хурууны эвсэл сууна

Сэнсний таталт, хайчаар үс засахад хурдан хөдөлгөх, будгийн багс барих, индүү ороолт хийх, химийн дармар ороох зэрэг хуруу гарыг үе мөч болгохоор салгах, эв дүй суулгах ач холбогдолтой болох нь 4-5 жилийн судалгаа туршилтаас нотлогдсон.



/Зураг 1/



/Зураг 2/



/Зураг 3/



/Зураг 4/




/Зураг 5/



/Зураг 6/



/Зураг 7/





/Зураг 8/

Үс засаж сэнсдэх, тайрах, индүүдэх зэрэг эдгээр үйлдлүүдийг хийхэд хөдөлгөөн маш чухал үүрэгтэй ба дээрх 8 тоот дасгалыг жигд тасралтгүй хийснээр ажлын байр буюу дадлагын танхимд ур чадвар сууж хөгжих бүрэн боломжтой .



Хайчны барилт буюу гар бугуйн хэсгээр эргэлт хийх дасгалын зургууд.




Политехник коллежд-д үсчин мэргэжлээр суралцагсдын ур чадварыг судалсан үр дүн, онцлог

Политехник коллеж-ийн сургалтын чанарыг сайжруулах асуудлыг үсчний мэргэжлээр суралцаж буй оюутнуудын жишээн дээр судалж тэдний мэргэжлийн ур чадварыг үндсэн 4 чиглэлээр судалж тогтоож, хөгжүүлэх асуудлыг судалгааныхаа зорилго болгон ажиллаж үр дүнг 3 жилээр тооцож гаргах оролдлого хийсэн. Тодруулбал:

1. Үсний хайч, хайчаар тайрах ур чадвар
2. Үсэнд хими хийх ур чадвар
3. Үс долгионтуулах ур чадвар
4. Үсийг сорлох ур чадвараар тус бүр судлан тодорхойллоо.


Үсчний мэргэжлээр суралцаж буй оюутнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургах туршилтыг 2017-2018 оны хичээлийн жилд 13, 2018-2019 оны хичээлийн жилд 23, 2019-2020 оны хичээлийн жилд 15, бүгд 51 суралцагч дээр явуулж, мэргэжлийн ур чадварыг сайжруулах ажлыг сурагч тус бүр дээр гаргаж үзэхэд, судалгааны ажил нь сургах туршилт, мэргэшүүлэх туршилт, үр дүнг тооцох туршилт зэргээс бүтэж байсан бөгөөд энэхүү бүтэц нь үсчний сайн мэргэжилтэн бэлтгэхэд чухал нөлөөтэй болох нь харагдсан юм.

Судалгаанд хамрагдсан сурагчдын хайч хэрэглэж үс тайрах чадварын судалгаа




Үс тайрах чадварын сул түвшин 2018-2019 онд 2 сурагчид, 2019-2020 онд 6 сурагчид, гарч сул түвшин 2020-2021 онд 4 сурагчаар ахисан байна. Энэ нь тухайн сурагчдын хөдөлгөөний чадвартай холбоотой байлаа. Жишээ нь хөдөлгөөний эвсэл, хурд, тэнцвэр, эв дүйтэй холбоотой байлаа.

Судалгаанд хамрагдсан сурагчдын үсэнд химийн ороолт хийхэд суралцсын үр дүнгийн судалгаа




Судалгаанд хамрагдсан үсчний мэргэжлээр суралцаж буй 51 оюутны 36 оюутан нь 2018-2019, 2019-2020 онуудад төгссөн төгсөгчдийн химийн ороолт хийх чадварын дундаж ба өндөр түвшин жилээс жилд ахиж ирсэн байна.

2020-2021 онд суралцаж буй оюутны хичээлийн жилийн эхний саруудын амжилт, үсэнд химийн ороолт хийх чадвар муутгүй хөгжиж байгааг диаграммаас харж болно.



Дундаж түвшний 10 оюутан өөр мэргэжлээр дадлагажин мэргэшсэн байсан учир үсчний мэргэжил эзэмшихэд харьцангуй саад бэрхшээл болж өгдөг нь судалгаагаар тогтоогдсон юм. Энэ нь нэг талаас нас, мэргэжлээс хамаардгийг харуулж өгсөн болно.



Судалгаанаас үзвэл үсчин мэргэжлээр суралцаж байгаа сурагчдын үс засах чадвар жилээс жилд сайжирч байгаа нь чадамжинд суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаатай холбоотой юм. Иймээс сургалтын хөтөлбөрийг сайжруулах мастер багш нарыг багш мэргэжлээр давтан сургаж, тэдний мэргэжлийн ур чадварыг багшлах ур чадвартай хослон эзэмшүүлэх бодит хэрэгцээ байгаа нь бидний судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Политехник-д үсчин мэргэжлээр суралцагсдын ур чадварыг хөгжүүлэх арга зам

Үсчин мэргэжлээр суралцсан буюу одоо суралцаж байгаа судалгаанд хамрагдсан 51 сурагчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхийн тулд гарын нарийн хөдөлгөөнийг хөгжүүлэх дасгалыг боловсруулан туршиж, тэдэнд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж байх зайлшгүй шаардлага байгааг судалгааны ажлынхаа үр дүнгээс олж мэдсэн болно.

Үсчин хүнд шаардлагатай дасгал, хөдөлгөөнүүдийн иж бүрдлийг боловсруулан 51 сурагч нэг бүрд сургаж, тэдний үс засалтын үед зайлшгүй харгалзаж байх хөдөлгөөний дадлуудыг олгосон болно. Энэхүү дасгалуудын бүрдэл нь дасгалжуулалтын явцад бэхжиж, үс засах бүрт төгөлдөрждөг байна.

Үсчин мэргэжлээр суралцсан буюу одоо суралцаж байгаа судалгаанд хамрагдсан 51 сурагчдын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхийн тулд гарын нарийн хөдөлгөөнийг хөгжүүлэх дасгалыг боловсруулан туршиж, тэдэнд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж байх зайлшгүй шаардлага байгааг судалгааны ажлынхаа үр дүнгээс олж мэдсэн болно.

Үсчин хүнд шаардлагатай дасгал, хөдөлгөөнүүдийн иж бүрдлийг боловсруулан 51 сурагч нэг бүрд сургаж, тэдний үс засалтын үед зайлшгүй харгалзаж байх хөдөлгөөний дадлуудыг олгосон болно. Энэхүү дасгалуудын бүрдэл нь дасгалжуулалтын явцад бэхжиж, үс засах бүрт төгөлдөрждөг байна.

Судалгааны үр дүн, дүгнэлт

1. Үс тайрах чадварыг судалгаанд 51 сурагчаас 36 буюу 75 хувь нь мэргэжлийн түвшинд эзэмшиж чадсан билээ.
2. Үс долгионтуулах арга зүйг үсийг угааж ,чийгшлийг оновчтой тохируулах,сэнсний халуун хүйтнийг тааруулах, үүсгэсэн долгионыг удаан хугацаанд хадгалах чадвартай болгох чадварыг 56 сурагчдад бүрэн эзэмшүүлэв.
3. Үсэнд химийн ороолт хийх чадварыг сайн эзэмшүүлэх үндсэн нөхцөл нь химийн бодисыг экологийн хувьд зөв хэрэглэдэг болгосноор амжилттай шийдэж болохыг судалгааны явц багш нарын туршлагаас олж тогтоолоо.
4. Үс сорлох чадварыг сурагчдад эзэмшүүлэх хуучин будагтай үс , хими хийлгэсэн үсэнд сайн ордоггүй бөгөөд эмэгтэй хүний биеийн эрүүл мэндийн онцлогоос болж (минструац ирэх) сорлох үйл ажиллагаа амжилттай болдогийг шинжлэх ухааны үүднээс мэддэг болгоход багш анхаарч ажиллах нэн чухал шаардлагатайг сургалтын болон судалгааны явцад илрүүлсэн болно. Үсчин мэргэжлийн үйлчилгээ нь хүн таних арга ухаанаас ихээхэн хамааралтай болох нь практик ажлын явцад тогтоогдож байна.
5. Үсчин мэргэжлийг сонгосон сурагчдад ерөнхий эрдмийн, мэргэжлийн суурь мэрэгшүүлэх хичээлүүдийн оновчтой харьцаг тогтоож, мэргэжлийн хичээлүүдийн эзлэх жинг гуравны хоёроос доошгүй байхаар тогтоох нь нэг жилийн хугацаанд мэргэжилтэн бэлтгэх ажлыг сайжруулахад чухал нөлөөтэй болохыг судалгааны явцад мэдэж авлаа.

НОМ ЗҮЙ, ЭХ СУРВАЛЖ



1. (2002).Мэргэжлийн боловсролын шинэчлэл,"Монголын мэргэжлийн боловсролыг дэмжих төсөл".УБ
2. (2002).Хөдөлмөрийн зах зээлийн дүн шинжилгээ ба мэргэжлийн сургалтын эрэлт хэрэгцээ.УБ
3. (2003).Мэргэжлийн сургалтын арга зүйн асуудал.УБ
4. (2000).Мэргэжлийн сургалтын стандартыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийцүүлэх нь .УБ
5. (2004).Монгол улсын стандарт MNS5370...2004СХҮТ.УБ
6. (2004).МБС-ын стандарт,хөтөлбөр боловсруулах тухай зөвлөмж, магадлал хийх журам.МАЗТ.УБ
7. (2004).Мэргэжлийн сургалтын модуль боловсруулах аерга зүй .УБ
8. (2004).Мэргэжлийн шалгалтын тест боловсруулах арга зүй.МАЗТ.УБ
9. (2005).Хөдөлмөрийн зах зээлийн чанарын судалгаа явуулах аргачлал .МАЗТ.УБ
10. (2012).Мэргэжлийн боловсрол, сургалт .МБСҮЗ.УБ
11. (2017).МБС-ын байгууллагын багшийн арга зүй ,судалгааны ажлын шилдэг илтгэл шалгаруулах улсын XVI уралдааны эмхтгэл
12. Булгантуул.Э., (2011). Үс заслын технологи. УБ.
13. Болорэрдэнэ.С.,(2013).Чадамжид суурилсан сургалтын гарын авлага.УБ
14. Булгантуул.Э Одгэрэл.Д.,(2012).Үсчний мэргэжлийн үндсэн сурах бичиг.УБ
15. Ганбаяр.Г Батзориг.П.бусад (2014).Мэргэжлийн боловсрол,сургалтын байгууллагын багшийг чадавхижуулах нь.УБ
16. Отгонмягмар.Ц Мишигжав.Б.,бусад(2018).Мэргэжлийн боловсрол сургалт.УБ
17. Одгэрэл.Д Булгантуул.Э., (2013).Үсчин.УБ
18. Эрдэнэцэцэг.С Батхуяг.С.,(2011).Багш боловсролын үндэс.УБ
19. Жадамба.Б Чулуундорж .,(1994).Сургалтын ридет систем.УБ
20. Цээпил.С .Монгол орны ТМБ-ын үүсэл хөгжил,хэтийн төлөвийн зарим асуудал.УБ
21. Эрдэнэ-очир.Г.(1995). Ерөнхий дидатийн үндэс.УБ
22. Цэвэлмаа.Г.(1999).Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх арга зам .УБ
23. Цээпил . С. (2000).Монгол улсын техни —мэргэжлийн боловсрол үүсэл хөгжил ,шинэчлэл.УБ
24. Цээпил.С .(2000).Мэргэжлийн сургалтын арга зүйн зарим асуудал . УБ
25. Содномдорж.Н . (2000).Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг . УБ
26. Цээпил .С.(2000).Мэргэжлийн боловсролын стандартын загвар.УБ



27. Цэпил .С .(2001).Үйлдвэрлэлийн сургалтын сургах зүйн зарим асуудал .УБ
28. Цэпил .С .(2002).Мэргэжлийн боловсрол,сургалтын шинэчлэлийн онол арга зүйн зарим асуудал.УБ
29. Лханям.Л .(2004). Хөдөлмөрийн эдийн засаг.УБ
30. Энхбат.Г .(2004).Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт дүн шинжилгээ хийх аргачлал. УБ
31. Цэпил.С.(2006).Мэргэжлийн боловсрол ,сургалтын сургах зүй.УБ
32. Цэвээнлхазал.Я . Алтанхуяг.Ц (2003).Хүмүүс ээ! Би чадна....Хөгжлийн бэрхшээлээ засна.УБ
33. Цэвээнлхазал .Я Алтанхуяг.Ц (2003) . Хүүхдийн анхаарлын бэрхшээлийг судлах нь сэтгэл зүйн оношлогоо.Цуврал 2.УБ
34. Цэвээнлхазал .Я Алтанхуяг .Ц (2005) .Бага ангийн сурагчдын сурах чадварыг хичээлээр оношлох нь .УБ
35. Цэвээнлхазал.Я Алтанхуяг .Ц (2003) .Бага ангийн хүүхдийн анхаарлын бэрхшээлийг судлах нь .УБ
36. Цэвээнлхазал.Я Алтанхуяг .Ц (2005).Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургах арга зүй .УБ
37. Цэвээнлхазал.Я ба бусад., (2007) .Хөгжлийн бэрхшээлийг танихуй .УБ
38. Цэвээнлхазал .Я Туяа .Б нар., (2008) “Тэгш хамруулан сургагч багш “ бэлтгэх сургалтын арга зүй.УБ
39. Цэвээнлхазал.Я (2008). Бага боловсролын сурган хүмүүжүүлэх зүй . Их дээд сургуулийн багш оюутануудад зориулсан сурах бичиг .УБ
40. Цэвээнлхазал. Я., (2009)., Мэдлэг бүтээх үйл явцын сургахзүйн үндэс. УБ.
41. Цэвээнлхазал.Я. (2003)., Сурагчдын сурах бэрхшээлийг яаж илрүүлэх вэ. УБ.

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:

ҮЙЛДВЭР СУРГАЛТЫН ХИЧЭЭЛЭЭР СУДАЛГАА ТУРШИЛТЫН АЖЛЫГ ХӨГЖҮҮЛСЭН НЬ

ГООЗАСЛЫН БАГШ: П.МӨНХЖАРГАЛ



СЭДЭВ: ҮЙЛДВЭР СУРГАЛТЫН ХИЧЭЭЛЭЭР СУДАЛГАА ТУРШИЛТЫН АЖЛЫГ ХӨГЖҮҮЛСЭН НЬ

ОРШИЛ

Судалгаа гэдэг нь “мэдлэгийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээлч, тогтолцоотой ажил” юм. Судалгаа нь сэдэв эсвэл асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд мэдээллийг цуглуулах, зохион байгуулах, задлан шинжилгээ, дүн шинжилгээ хийх зэргийг хэлдэг.

Судалгааг дараах байдлаар ялган ангилж болно.

1. Тодорхойлолт
2. Асуудал
3. Төрөл ангилал :
 - Судлаачаар нь
 - Зорилгоор нь
 - ✓ Нээх судалгаа
 - ✓ Тодорхойлох судалгаа
 - ✓ Тайлбарлах судалгаа
4. Зорилго, үр дүнгээр нь
5. Аргаар нь
 - ✓ Онол туршилтын судалгаа
 - ✓ Арга, аргачлал, үр дүнгээр нь
6. Ерөнхий сэдэв, салбараар нь
7. Мөн үзэх

Тодорхойлолт

Аливаа юмны зүй тогтлын учрыг олох үйл ажиллагаа, судлах ажиллагааг судалгаа гэдэг.

Судалгаа гэдэг нь янз бүрийн хүчин зүйлээс хамаарч юмс үзэгдэл, байгаа зүйлийн өөрчлөгдөх, шинэ үзэгдэл, зүй тогтолыг амьдрал дадлагад ашиглаж болох үйл ажиллагаа юм. Судалгаа нь онол арга зүйг ашиглаж, судалгааны арга аргачлал боловсруулан судалж үр дүнг гаргаж мэдээлдэг.

Асуудал

Судалгааны ажилтай холбоотой үндсэн гурван асуудал байдаг:

1. Юу бичих вэ?
2. Яаж бичих вэ?
3. Хаана хэвлүүлэх вэ?

Төрөл ангилал

Судалгааг судалгаа хийж буй хүнээр нь, зорилгоор нь, хүрэх үр дүнгээр нь, хандах бүлгээр, хамарч буй ерөнхий сэдвээр гэх мэтээр олон янзаар ангилдаг.

Судлаачаар нь

1. Идэвхтэй буюу өөрөө хийх судалгаа

2. Идэвхгүй буюу бусдаар хийлгэх судалгаа гэж ангилж үздэг. Зорилгоор нь

1. Нээх,
2. Тодорхойлох,
3. Тайлбарлах гэж ангилдаг.

Нээх судалгаа

Нээх судалгаа нь асуудлыг шинээр дэвшүүлж, шинэ үр дүнд хүрэх үйл ажиллагаа юм.

Тодорхойлох судалгаа

Судалгааны асуудлын хариулыг эрж хайх, олох, юмс үзэгдлийн холбоо харилцаа, өөрчлөлтийн мөн чанарыг бодитой, үнэн зөв тодруулах үйл ажиллагааг тодорхойлох судалгаа гэнэ.

Тайлбарлах судалгаа

Судалгааны асуудлын шалтгаан, үр дагаврыг олж тогтоох үйл ажиллагааг тайлбарлах судалгаа гэнэ.

Зорилго, үр дүнгээр нь

1. Онолын судалгаа
2. Онол туршилтын судалгаа
3. Суурь судалгаа
4. Хавсарга судалгаа
5. Тухайлсан судалгаа
6. Иж бүрэн судалгаа гэж ангилдаг.

Аргаар нь

1. Эмпирик (Empirical)
2. Онолын (Theoretical)
3. Загварчлал (Modelling)
4. Тооцооллын (Computational)

гэж ангилан үзэж байна.

Онол туршилтын судалгаа

Онолын хувьд баталсан зүйлээ амьдрал, дадлага дээр туршиж, онолын судалгааны үр дүнг бодит загвар, байдал дээр шалган туршиж үнэмшил бий болгох явдал юм. Энэ нь онолын судалгааны үр дүн амьдрал дээр нотлогдож байгаа үр дүн юм.

Арга, аргачлал, үр дүнгээр нь

1. Тоон судалгаа
2. Чанарын судалгаа

Ерөнхий сэдэв, салбараар нь

- Эдийн засгийн судалгаа
- Улс төрийн судалгаа
- Зах зээлийн судалгаа
- Сэтгүүл зүйн судалгаа
- Уран бүтээлийн судалгаа

Мөн үзэх

- Таамагт суурилсан судалгаа
- Тоон судалгаа
- Эмперик судалгаа
- Агуулгын судалгаа
- Социологийн судалгаа
- Маркетингийн судалгаа
- Барилгын салбарын судалгаа
- Хүн амын тооллого

Судалгааны тухай товч тодорхой авч үзвэл дараах тодорхойлолтуудыг дурьдаж болох юм. Мөн мэргэжлийн боловсрол сургалтын багшийн ихэнхи хичээл дээр судалгааны арга давтагдах туршигдах нь бий. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийн хувьд прагматик шинж агуулсан бөгөөд аливаа хичээлийн агуулгыг эзэмшүүлэх цогц мэдлэг ур чадварийг ЧАДАМЖ гэж нэрлэн хэрэглэж байна.

Тухайн хичээлийн сэдэв түүний агуулга цар хүрээнээс хамаарч нэгж хичээлд хэрэглэгдэж буй судалгаа туршилтын арга зүй зохион байгуулалт нь өөр өөр байдаг.

Мэргэжлийн багшийн хувьд ажилласан туршлага дээр үндэслэн үйлдвэр сургалтын хичээл дээр тогтмол хэрэглэгддэг судалгааны арга, туршилтын лабортори ажлуудыг хэрхэн хөгжүүлэх, харьцуулах, тайлбарлах талаархи боломж мөн судалгаа туршилтын ажлуудыг хөгжүүлснээр хичээлд ямар үр дүн ахиц гарсаныг тодорхойлохоор энэхүү илтгэлийн судалгааг хийсэн болно.

Түлхүүр үг.

Судалгаа, арга зүй, сургалт

Судалгааны зорилго: Үйлдвэр сургалтын хичээлд түгээмэл ашиглагддаг судалгаа туршилтын аргыг хөгжүүлсэн арга зүй түүний үр дүнг тодорхойлох, мөн цаашид хөгжүүлэх боломжийг судлан тодорхойлох зохилготой.

Судалгааны зорилт

1. Үйлдвэр сургалтын хичээл зааж буй багшийн заах арга зүйг судлах
2. Мэргэжлийн ном сурах бичиг ашиглан арга зүй технологийг нэвтрүүлсэн байдлыг судлах
3. Нүүр будалтын технологи хичээлд хэрэглэсэн судалгаа туршилтын арга зүйн үр дүн ахиц дэвшил

Судалгааны арга зүй


Судалгааг түүвэрлэлтийн арга, жишээ баримт цуглуулах арга, судлан шинжлэх арга, санал асуулгын арга, практик үйлийн арга ашиглан хийсэн болно.

Хамрах хүрээ : Мэргэжлийн сургууль, сургалтын төв, ҮУПК-ийн гоо заслын мэргэжлийн ангийн суралцагсдын дунд хийсэн болно.

Судалгаа 1. Үйлдвэр сургалтын хичээл зааж буй багшийн заах арга зүйг судлах

МСҮТ, ПК болон адил төстөй сургууль сургалтын төвийн үйлдвэр сургалтын хичээлийн агуулга, үйл ажиллагааны талаархи судалгааг зарим нэг сургуулийн хичээлийн хөтөлбөр, сургалтын хөтөлбөр, нэгж хичээлийн хөтөлбөрөөс түүвэрлэн судлах тэдний зааж буй арга технологийн судалгааг хийсэн. Судалгаанд оролцсон багшийн үйлдэр сургалтын хичээлийн зааж буй цаг, ачаалал төстөй суралцах хугацааны хувьд урт богино өөр өөр байсан. Мэргэжлийн дадлага хичээл орж буй багшийн заах арга зүйн судалгааг багш нарын баталгаажуулсан нэгж хичээлийн төлөвлөгөөг ашиглан судалгааг хийсэн. Судалгаанд нийт 27 мэргэжлийн багш оролцсон бөгөөд хичээл сургалтандаа 8-9 аргуудыг нийтлэг ашигладаг мөн мэргэжлийн онцлогоос хамаарч 1-2 аргуудыг заримдаа хэрэглэдэг болох нь харагдаж байна.

Судалгааг графикаар харуулбал:



Судалгаа 1- ийн дүгнэлт хэсэг


Давуу тал	Сул тал
- Дадлага хичээлд прагматик арга давамгайлж тогтсон - Илүү туршлагатай багш нартай - Технологийн инновацийг ихээр нэвтрүүлсэн - Суралцагчын ачаалалаас болж багшаас хурд овсгоо самбаа шаарддаг	- Зарим багш нар нэвтрүүлсэн технологид тохирсон арга зүйгээ тодорхойлоогүй - Судалгаа туршилтын аргуудыг хөгжүүлж байгаа боловч тэр арга зүйгээ ээлжит хичээлийн төлөвлөгөөнд тусгаагүй

Судалгаа 2. Мэргэжлийн ном сурах бичиг ашиглан арга зүй технологийг нэвтрүүлсэн байдлыг судлах

Судалгааг ҮҮПК мэргэжлийн багш нар, Бодит үнэлэмж, Чухал амжилт зэрэг сургалтын төвийн багш нараас авсан судалгаан дээр хийсэн. Үйлдэрлэлийн дадлага хичээлд технологийн дэвшилийг харуулсан олон ном сурах бичгийг орчуулан ашиглаж байна. Түүврийн аргаар дараах хэдэн мэргэжлийг сонгон харуулбал:


Үсчин, Тогооч, Гоо сайхан, Автомашин засвар, Оёдолын мэргэжлийн багш нэр нь Англи, Солонгос, Япон технологийн мэргэжлийн сурах бичгийг хэдийнэ орчуулан сургалтандаа нэвтрүүлсэн байна. Үүнд:

Ашиглаж байгаа ном сурах бичиг	Мэргэжил	Ашиглаж байгаа хичээл/Аль улсынх/
	Гоо сайхан Нүүр будалтын технологи	Монгол, Солонгос Дадлага хичээл
	Үсчин Эрэгтэй, эмэгтэй үс тайралт	Солонгос, Англи Дадлага хичээл
	Тогооч	Орос, Англи
		Дадлага хичээл

	Оёдол	Англи Мэргэжлийн дадлага хичээл
	Автозасвар	Мэргэжлийн дадлага хичээл дээр ашиглаж байна. Орос

Дээрхи сурах бичиг технологийн хагжлийг ашиглаж байгаа арга зүйн судалгаанаас харахад мэргэжлийн дадлага хичээл зааж буй багш нарын 60 гаруй хувь нь гадаад сурах бичиг орчуулан ашиглаж технологийн дэвшлийг нэвтрүүлсэн байна.

Судалгааг графикаар харуулбал:




Судалгаа 2- ийн дүгнэлт хэсэг


Давуу тал	Сул тал
-Шинийг эрэлхийлдэг -Хичээл сургалтаа чанартай явуулах эрмэлзлэлтэй болсон -Сургалтандаа судалгаа туршилтын арга зүй хэдийнэ ашиглан нэвтрүүлсэн	-Арга зүйтэйгээ холбох туршлага дутсан -Ном нь өндөр үнэтэй -Орчуулга өндөр үнэтэй -Эх хэл дээрхи шинэ технологийн ном сурах бичиг ховор -Номын санд мэргэжлийн шинэ технологийн ном сурах бичиг ховор,шаардлага хангахгүй байна.


СУДАЛГАА 3. Нүүр будалтын технологи хичээлд ашигласан судалгаа туршилтын арга зүйн үр дүн ахиц дэвшил

Гоо заслын мэргэжлийн НҮҮР БУДАЛТЫН ТЕХНОЛОГИ мэргэжлийн дадлага хичээл дээр 2021оноос эхлэн Солонгосын мэргэжлийн сургуулийн нүүр будгийн хичээл дээр ашигладаг сурах бичгийг ашиглаж эхэлсэн . Гол агуулга болон шаардлагтай хэсгийг орчуулан дадлага хичээл дээр ашиглаж байна. Энэхүү сурах бичиг нь тухайн улсдаа туршигдсан, шинжлэх ухааны үндэслэлтэй гэж тооцогддог байна. Мэргэжлийн нүүр хувиргалт будалтын багш SON MAN SIK. HAN MYUNG SOOK нарын энэхүү сурах бичгийг ашиглахдаа дараах хичээлүүдийн онцлон сургалтандаа ашиглаж байна.



Нүүр будаж хар зураг өнгө зохиомж гаргаж сурахын тулд эхлээд хүний нүд хамар уруулийг зурж сурах нь чухал гэж үздэг байна. Учир нь нүдний харц уусгалт,гэрэл сүүдэр мөн хотгор гүдгэрийг гарган будаж сурсанаар харандаатай ажиллаж багсийг зөв бариж сурах.мөн нүдний харц нь тухайн хүний сэтгэл хөдлөл болон зохиомжийг илэрхийлэхэд ихээхэн ач хоблогдолтой гэж судлагдсан байна.






Нэг зурааснаас эхлэн хэрхэн нүд уруул хамар зэргийг зурах технологийг харуулсан байдал
ГЭТ2а ангийн суралцагсдаар дээрхи хичээлийг зураж гарын дасгал хийлгэх мөн мэдрэмжийг хөгжлүүлэх хичээлийг судлан туршсан болно.

Сурах бичгийг орчуулан дасгал ажлын дэвтэр болгон хэвлүүлж сургалтандаа ашиглаж байна

Мэргэжлийн нүүр будалтын технологи дадлага хичээл дээр дээрхи сурах бичгийг ашиглан судалгаа туршилт хийснээр сургалтанд шинэ технологи нэвтрүүлэх болон судалгаа туршилтын аргаар хүүхдийн сэтгэх, мэдрэх, зурах, будах зүгшрүүлэх дадлыг хөгжүүлэх хичээл сургалтаа сонирхолтой болгох ажлуудыг хийж эхэлсэн ба энэхүү хичээлийн үр дүн явцыг зургаар харуулбал:



ГЭТ 2а ангийн суралцагсдын нүүр будалтын технологи хичээлийн хар зураг эскиз гаргах өнгөөр илэрхийлэх хичээл.



Зурах гараа зүгшрүүлэх явцад нүдний будалтан дээр тухайн хүүхдийн сэтгэл санааны байдал мэдрэмжээс шалтгаалан нүд болгон өөр харцтай будагдсан байгаа нь судалгааны явцаас харагдаж байна.

Дээрхи хичээлийг хийж гүйцэтгэсний дараах хар зураг гаргах, зохиомжлох болон өнгөөр зохиомжийг илэрхийлэх ур чадвар нэмэгдсэн мөн уусгах цэвэрлэх будах ур чадвар ахисан нь харагдаж байгаа юм. Жишээ оруулав.


Өөрийн заадаг хичээлийн арга зүйн болон чанарын судалгааг сонирхон оюутанаас судалгаа авч дүгнэн үзсэн ба цаашид заах арга зүй болон бусад хичээлийн явц үйл ажиллагаандаа анхаарч ажиллахын тулд дээрхи судалгааг хийсэн болно.

Судалгааг графикаар харуулбал :

https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSes1IFnWjvbC1RsTuRnF7Z_ppCPJQknJ4CqifEk8eC3OzpeNQ/viewform?usp=sf_link


Үйлдвэр сургалтын хичээлийн аль хичээл илүү сонирхолтой вэ?

46 responses



Цаашид өөрийгөө хөгжүүлэх боломжоос аль нь илүү шаардлагатай вэ.

46 responses



Өөрийн ордог хичээл сургалтын санал асуулгаас үзэхэд хамгийн өндөр хувьтай нь нүүр будалтын хичээлийг илүү сонирхолтой гэж 65,2% нь үзсэн байна. Эндээс үзвэл багшийн тухайн хичээлийг судлан судалгаа хийж туршин илүү сонирхолтой болгох арга зүй технологийг сайжруулсан хичээл нь илүү эрэлттэй байгаа нь харагдаж байна. Мөн мэдээлэл технологи илүү хөгжсөн өнөө үед сургалтын агуулга болон хөтөлбөрийг чанаржуулах олон арга зүйг турших дүгнэх шаардлага гарч байна. Оюутанууд бие даан судлах, өөрийгөө хөгжүүлэх сонирхол ихээр нэмэгдсэн байна. Иймд гэрийн даалгавар сонгохдоо мэргэжлийн онцлогийг харгалзан нийтлэг биш сонирхолтой судалгаа туршилтын ажлууд өгвөл оюутанууд маань гүйцэтгэхэд бэлэн байна.

Судалгаа 3- ийн дүгнэлт хэсэг

Давуу тал	Сул тал
- Мэдээлэл нээлттэй - Ашиглах бэлтгэх боломж илүү ихээр нэмэгдсэн - Оюутанууд бие даан судлах турших боломжтой	- Дадлага ангийн тохижилт хангалттай биш - Багшийн хэлний мэдлэг бага

СУДАЛГААНЫ ҮР ДҮН АЧ ХОЛБОГДОЛ

Судалгааг мэргэжлийн дадлага хичээл дээр судлан туршсан бөгөөд энэ нь нүүр будалтын хичээлээр дамжуулан сурагчдыг зурах, сэтгэх, ажиглах, будах өнгө будгаар илэрхийлэх аргуудад дадалжуулан хичээл сургалтаа сонирхолтой амжилттай явуулах, багш арга зүйгээ сайжруулах мэргэжилдээ тохирсон арга зүй ашиглан судалгаа хийх өөрийгөө хөгжүүлэх шаардлагатайг тодорхойлсон гэж үзэж байна .

Мөн судлагдсан туршсан мэдлэгээр дамжуулан оюутан бие даан ажиллах чадвар нэмэгдэж байгаа ач холбогдолтой болно.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Мэргэжлийн сургуулийн багш нь өөрийн мэргэжлийн онцлогт тохируулан заах арга зүй болон хичээлийн бэлтгэл, явц, хөтөлбөрийн хэрэгжилт, агуулга, чанарын асуудлыг гол болгон яриж хэлэлцэж хөгжүүлэх ажлуудыг хийсээр байна.

Багш миний судлан олж тогтоосноор тухайн хичээлийн хэрэгжилтын хамгийн гол асуудал нь ээлжит хичээлийг заах арга зүй юм.

Тухайн хичээлд тохирсон аргуудаас голлох арга нь аль нь вэ? гэдгийг тодорхойлсноор хичээлийн чанар тодорхойлогдоно.

Мөн өнөөгийн сургалтын агуулгын шаардлага нь орчин үеийн дэвшилтэд технологи арга зүйг суралцагсдад эзэмшүүлэн ажил олгогчид нийгмийн шаардлагыг хангах явдал юм.

Судалгаанд оролцсон зарим багш нарын ээлжит хичээлийн төлөвлөгөө болон нэвтрүүлсэн шинэ технологи арга зүй, зааж буй хичээлийн арга зүй зэрэг нь интеграци холбоо бага, эсвэл өөрийн нэвтрүүлсэн шинэ технологи, туршиж байгаа арга зүйгээ бичээгүй зэрэг байдлууд байна.

Мөн өөрийн зааж буй хичээлийн чанар эрэлт явцын судалгаа, дадлага хичээл дээр туршиж буй судалгааны аргаа хөгжүүлэх, туршсан үр дүнгээ тодорхойлсон судалгааны ажлаа илтгэл болгон бичсэн болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Судалгааны арга зүй

<https://ecrc.mn> > media > ecrc > content > projects

2. Д.Пүрэв Судалгааны арга зүй <https://ecrc.mn> > media > ecrc > content > projects

3. Son man sik. Han Myung Sook Нүүр будалтын технологи

4. Ээлжит хичээлийн төлөвлөгөө ҮҮПК мэргэжлийн багш нар

5. Googl- forms sudalgaa


https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSesI1FnWjvbC1RsTuRnF7Z_ppCPJQknJ4CqifEk8eC3OzpeNQ/viewform?usp=sf_link

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a single sheet of white paper with horizontal ruling lines. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.



СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЭХЛЭЛ, ЦАХИМ НИЙТЛЭЛИЙН ТАВ ДАХЬ БҮТЭЭЛИЙН УРИАЛГА:

Энэхүү цахим цуврал сэтгүүлийг ҮУПК-ийн багш ажилтнуудын 2021-2025 оны стратеги төлөвлөлт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд зориулан бүтээв. Сэтгүүлийг жилд 2 удаа гаргах бөгөөд тус сургуулийн инноваци, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүн, шинэ санаа, оновчтой туршилт ажлын амжилтахиулж, нэмэгдүүлсэн цаашдын хөгжлийг тодорхойлох бүтээлүүдийг танилцуулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор нийтэлнэ. Энэхүү цахим сэтгүүл нь 5 дахь сэтгүүл болно.

Эрдэм шинжилгээний бүтээлүүдийн эхлэл нь мэргэн байж, цаашдын сургалт үйлдвэрлэл шинэ санаа оновчтой бүтээлийг дэлгэрүүлэн хөгжүүлэх үйлсэд хамт олноороо мэргэших болтугай.

2022 ОНЫ БАГШ НАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛЖ БАЙНА.

САНААЧИЛАН БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР Б.МЯДАГБАДАМ
ЭХ БЭЛТГЭСЭН: Д.ОТГОНДЭМБЭРЭЛ
ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖҮҮЛСЭН: Э.ТҮВШИН



@rajivgandhicolleges

www.pas.mn



info@pas.mn